



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

АГУУЛГА

“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын хэлсэн үг	3
“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганд Монгол Улс дахь НҮБ-ын суурин зохицуулагч Пратиба Мехтагийн хэлсэн үг	10
“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганы ажиллагааг нээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Т.Билэгтийн хэлсэн үг	15
Ц.Нацагдолгор 2006 оны хүний эрхийн үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт	17
Ц.Мөнх-Оргил Хохирогчийн эрхийн эрх зүйн баталгааг хангах асуудал	21
Д.Одбаяр Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай	28
Д.Солонго Хохирогчийн эрхийн талаарх олон улсын стандарт ба үндэсний хууль тогтоомж	34
М.Ганболд Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирогчийн эрхийг хангаж буй байдал, анхаарах асуудал	46
Д.Батжаргал Гэмт хэргийн болон захиргааны хууль бус ажиллагаанаас иргэнд учирсан хохирлын нөхөн төлөлтийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам	51
Ц.Одончимэг Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал	62

Д.Ганзориг	
Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас хохирсон хохилогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал	71
Д.Энхжаргал	
Хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал	109
Хавсралт:	
Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн үндэсний чуулганаас гаргасан зөвлөмж.....	122

**“ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА” СЭДЭВТ
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
НАМБАРЫН ЭНХБАЯРЫН ХЭЛСЭН ҮГ**

Улаанбаатар хот. Төрийн ордон.

2007.12.04

Хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Ноёд, хатагтай нараа,

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд зохион байгуулж байгаа энэхүү чуулганы ажиллагаанд оролцож буй та бүхний энэ өдрийн амгаланг эрж, чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Хүний эрхийг дээдлэн хүндэтгэж, баталгаатай эдлүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэх нь ардчилсан төрийн хамгийн эрхэм үүргийн нэг гэдгийг юуны өмнө тэмдэглэн хэлье. Энэ үзлийг эш үндэс болгон хүний эрхийн үндэсний чуулганыг гурав дахь жилдээ Хүний эрхийн үндэсний хороо, Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран Төрийн тэргүүний ивээл дор зохион байгуулж байна. Жил жилийн чуулганы сэдвийг сонгохдоо нийт ард түмний ашиг сонирхлыг хөндсөн хамгийн тулгамдсан асуудлыг авч хэлэлцэхийг урьтал болгож, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөллийн аль болох өргөн оролцоотойгоор шүүн хэлэлцэж оновчтой шийдэлд хүрэхийг зорьж байгаа юм.

Энэ удаа ч иргэдийнхээ дуу хоолойг сонссоны үндсэн дээр **“Хохирогчийн эрхийн баталгаа”** гэсэн сэдвийг сонголоо. Сүүлийн жилүүдэд иргэд ганц нэгээрээ бус, бүр хэдэн зуу, мянгаараа нэгэн зэрэг эрх зүйн зөрчлийн хохирогч болох явдал олонтаа гарч байна. Үүнтэй холбогдуулан иргэд маань засаг төрдөө хандан тодорхой шаардлага тавихын зэрэгцээ цаашид ийм зүй бус үзэгдлийг гаргуулахгүй байх талаар шийдвэртэй арга хэмжээ авахыг хүсэлт болгож байна. Үүнийг иргэний нийгмийн удаа дараагийн жагсаал цуглаан, иргэдээс ирүүлсэн олон тооны захидал, гомдлоос тодорхой харж болно.

Хүн төрөлхтний нийгмийг сайн гэж үзэх нэг чухал хэмжүүр нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагааны улмаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн хохирохгүй

байх нөхцлийг бүрэн бүрдүүлсэн улс орны туршлага өнөө хэр байхгүй, байх ч боломжгүй биз. Гэхдээ иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрх зүй, тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдал аль ч улс орны хувьд нэн чухал юм.

Харамсалтай нь шуудхан хэлэхэд одоогоор манай улсад хохирогчийн эрхийг хамгаалах, хэрэгжилтийг хангах баталгаа төдийлөн сайн бүрдэж чадаагүй байна. Үүнээс болж иргэд маань хууль бус үйлдэл, үйл ажиллагааны золиос болж хохирох явдал гарсаар байгаа бөгөөд энэ нь сүүлийн үед бүр өсөх хандлагатай болж байгаа нь санаа зовоож байна.

Би Улсын Их Хурлын 2007 оны намрын чуулганы нээлт дээр хэлсэн үгэндээ хохирогчийн эрхийн асуудалд харьцангуй бага анхаарч байгааг сануулж, иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаа, нэр төр, алдар хүндээрээ хохирчихоод эцэст нь хохирсон эрхээ сэргээлгэж чадалгүй давхар хохирох явдал байж таарахгүй гэдгийг цохон тэмдэглэсэн.

Энэхүү чуулганы үзэл санаа, үндсэн зорилго нь хохирогчийн эрхийг хамгаалах талаар тулгамдаад байгаа хамгийн чухал, нийтлэг асуудлуудыг цогц байдлаар хэлэлцэж, түүнийг шийдвэрлэх оновчтой гарцыг олж, ажил хэрэг болгоход чиглэж байгаа юм. Хүний эрхийн сэдвийн хүрээнд эрх зүйн зөрчилд орооцолдсон хүнийг хэлмэгдүүлэхгүй байх, тэдэнтэй хүнлэг энэрэнгүй харьцах асуудлыг олонтаа ярьж, энэ талаар багагүй арга хэмжээ авч ирсэн. Тодорхой үр дүн ч гарч байгаа гэж ойлгогдож байна. Харин нөгөө талд нь тэдний үйлдсэн эрх зүйн зөрчлийн улмаас хохирч, амьдралд нь гэнэтийн аюул, алдагдал учирсан гэм зэмгүй хүмүүсийн эрхийг хамгаалахад үүнээс дутуугүй ач холбогдол өгөх шаардлагатай юм.

Иргэдэд сүүлийн 5 жилийн дунджаар гэмт хэргийн улмаас жилд 18.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан ба хохирлын хэмжээ жилээс жилд өссөн мэдээ байна. Хэд хэдэн аймгийн жилийн төсөвтэй дүйхүйц энэ үнийн дүн дээр хуулийн байгууллагад хохирлоо бүртгүүлээгүй хүмүүст учирсан бодит хохирол, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирсон хохирлын нийт дүнг бүрэн хэмжээнд нэмж тооцвол ямар хэмжээнд хүрэх нь тодорхой.

Зах зээлийн харилцаанд чадан ядан оролцож, өрх гэрийнхээ өмч хөрөнгийн хуримтлалыг бүрдүүлж яваа ард иргэдийн маань амьдрал

учирдаг энэ гарз хохирлыг улс орны эдийн засгийн анхдагч нэгжид учирч байгаа хохирол гэдэг талаас нь харвал иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах төрийн бодлогод томоохон хүндрэл учруулж байгааг төвөггүй мэдэж болохоор байна.

Гэмт хэрэгт холбогдсон, шийтгэгдсэн хүмүүсийн тоо, тэдгээрт хамаарах мэдээлүүдийг аль ч газрын тайлан мэдээнээс харж болохоор атал уг гэмт хэргүүдийн улмаас хохирсон хохирогчийн талаарх мэдээ, хохирлыг нөхөн төлсөн, эсэх тооцоог нэгтгэн бүртгэдэг тогтолцоо өнөө болтол бүрдээгүй байна. Хохирогч нэг бүрээр хийсэн судалгаа тооцоогүй, хохирол нөхөн төлөгдөж, хөндөгдсөн эрх нь сэргэсэн, эсэхэд тавих нэгдсэн бүртгэл хяналтгүйгээр Үндсэн хуульд заасны дагуу “...хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх...” талаар хүлээсэн үүргээ төр зохих ёсоор биелүүлэх боломжгүй нь тодорхой. Иймд юуны өмнө гэмт хэргийн хохирогчийг нэг бүрчлэн бүртгэж, нэгдсэн мэдээ тайлан гаргадаг, хохирол төлөгдөөгүй шалтгаан нөхцөл болгоныг авч үзэж, хохирогчийн өмнөөс асуудлыг шийдвэрлэдэг тогтолцоонд нэн даруй шилжих хэрэгтэй байна.

Монгол Улсад нийгмийн шилжилтийн үе эхэлснээс хойш энэ зууны эхэн хүртэл гэмт хэргийн түвшин тасралтгүй өсч байснаа сүүлийн жилүүдэд өсөлт нь саармагжих, аажим буурах хандлага ажиглагдаж байгааг судлаачид тэмдэглэсэн нь манай орны нийгэм, эдийн засгийн үзүүлэлт харьцангуй тогтворжиж, шилжилтийн үеийн сөрөг үр дагавар тодорхой хэмжээгээр багасаж байгаатай холбоотой гэж үзэж байна. Гэвч түүний дотор онц ноцтой гэмт хэргийн улмаас амь насаа алдсан иргэдийн тоо сүүлийн 5 жилд бараг хоёр дахин өсч, эрүүл мэндэд хохирол учруулсан хэргийн түвшин төдийлөн буураагүйг анхаарахгүй байх аргагүй юм. Нийт гэмт хэргийн нөхцөл байдалд санаа амиглаж, тодорхой төрлийн хэргүүдийн өсөлт, шинж чанарын өөрчлөлтийг анзаарахгүй байж болохгүй. Энэ бүхний ар талд “хийсч ирсэн” гайгаар хагацал зовлон, үй гашуу, гарз хохиролд автсан өдий төдий хохирогч хүмүүс, гэр бүлүүд байгаа гэдгийг мэдэрч тэдний төлөө чин санаа тавьж ажиллах ёстой.

Зөвхөн танхай балмад хүмүүсийн гарт эрдэнэт хүний амьсүйрч, эрүүл мэнд хохирохоос гадна төрийн зарим байгууллага, албан тушаалтны хариуцлагагүй ажиллагаа, гоомой шийдвэрийн улмаас томоохон ослууд удаа дараа гарч, олон гэр бүлд үй гашуу учруулсныг онцгойлон авч үзэж, буруутай этгээдүүдэд зохих хариуцлага тооцохын зэрэгцээ, төрийн

албаны бүх шатанд сахилга хариуцлага, сонор сэрэмжийг шаардлагын түвшинд хүртэл сайжруулах ажлыг шуурхай зохион байгуулж ард иргэддээ тогтмол мэдээлдэг байвал зохино гэж хүмүүс шүүмжилж байна. Хариуцлагагүйн зүдэд хагацал зовлон үргэлжлэх ёсгүй.

Чөлөөт зах зээлийн харилцааны мөн чанар, зарчим, журамд иргэд маань эрхбиш дасан зохицож, тэдгээрийг амьдралынхаа хэм хэмжээ болгож сурч байна. Гэвч энэ үйл явц ээдрээтэй замыг туулж байна. Ёс суртахуун, шударга ёсыг эс хэрэгсэн, хууль ёсыг уландаа гишгэж, буруу булхайтай замаар мөнгөжиж хөрөнгөжих гэсэн хүмүүс ч олширч залилан мэхлэх аргаар хүмүүсийг бөөнөөр нь хохироодог явдал цөөнгүй гарах боллоо. Хадгаламж зээлийн хоршоонд хэт өндөр хүү зарлаж, хадгаламж авах, гадаад улсад зорчих виз гаргаж өгнө гэх, хуурамч сүлжээ үүсгэн иргэдийн мөнгийг авах, орон суушны захиалгаар хуурч мөнгө авах зэрэг янз бүрийн хэлбэрээр итгэл үнэмшил төрүүлэн иргэдийг олноор нь хохируулсан жишээ баримтыг захаас аван хэлж болохоор байна. Залилан мэхлэгчидэд хууртаж зөвхөн эд хөрөнгөөрөө хохироод зогсохгүй өөрсдөө эд бараа мэт худалдагдсан эмгэнэлтэй тохиолдууд ч удаа дараа гарч байна.

Ийм бусармаг явдлуудыг эхнээс нь мэдэж үр дагавар үүсгэлгүйгээр таслан зогсоох боломж хууль сахиулах болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад, тэнд ажиллаж буй албан тушаалтнуудад байсан нь тодорхой. Гагцхүү санаачлага муутай, хариуцлага сул, төрийн албадын ажлын уялдаа холбоогүй байдал ийм хүнд байдалд хүргэсэн. Нэгэнт болсон үйл явдлын үр дагаварыг арилгах арга хэмжээ авснаар асуудал шийдвэрлэгдэхгүй, харин үүнээсээ сургамж авч цаашид үйл ажиллагааныхаа доголдол, дутагдлыг арилгаж хий зайгүй ажиллах тогтолцоог бүрдүүлэх талаар дорвитой ажил зохиох хэрэгтэй байна. Хэрэв төр алдаа гаргаж иргэд хохирох шалтгааныг буй болгосон бол хариуцлага хүлээж чаддаг байх нь ардчилсан шударга ёсонд нийцнэ. Ер нь нийгэмд болсон сөрөг үзэгдэл болгоны шалтгаан, нөхцлийг олж тухай бүрд нь арилган, давтагдахгүй байх иж бүрэн арга хэмжээ авч занших нь нийгэм хөгжих, хүний эрхийг хангахын гол зангилаа асуудал мөн.

Би энэ талаар Улсын Их Хурлын 2006 оны намрын чуулганы нээлтэд үг хэлэхдээ хадгаламж зээлийн хоршоодод хуруу хумсаа хугалах шахан байж олж цуглуулсан хэдэн төгрөгөө хадгалуулсан ард иргэд, ахмад буурлууд, гадаадад ажиллаж байсан буюу ажиллаж байгаа хүмүүс, тэдний гэр бүлийн олон мянган хүнд хохирлыг нөхөн олгоход улс

оролцож туслах нь шударга ёсонд нийцнэ хэмээн байр сууриа тодорхой илэрхийлсэн. Улсын Их Хурал ч энэ дагуу нэг удаагийн хууль баталж, зарим арга хэмжээ авч эхлээд байна. Үүгээр хохирол барагдуулах ажил хязгаарлагдахгүй, цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боломжтой бүх арга хэрэгслийг ашиглан шуурхай явуулахад онцгой анхаарах ёстой.

“Хаширсан хүн гэж хаширсан хүнийг хэлнэ” гэдэгчлэн манай иргэд зах зээлийн үеийн эдийн засаг, нийгмийн харилцаанд эрсдэл хүлээх боломжуудыг заавал судалж, магадлаж байж оролцох хашир хэрсүү хандлага дутсанаас бусдын заль мэхэнд автаж, гэмт этгээд зорилгоо хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн өөрсдөө хохирсон олон тохиолдлуудаас сургамж авч байгаа бизээ. Өөрсдөө сэрэмж, болгоомжгүй хандсанаас хохирсон бүх бурууг төрд дангаар тохох нь бас л зах зээл, ардчилсан ёсны зарчимд нийцэхгүй гэдэгтэй та бүхэн санал нийлэх байх. Төр ба иргэн хоёулаа үүрэг хариуцлагадаа эзэн болж байж бусдыг хохироодог нийгмийн сөрөг үзэгдлийг багасгаж чадна. Үүнийг хаана хаанаа анхаарах хэрэгтэй юм. Үүнтэй холбогдуулж хүмүүсийнхээ иргэний боловсролыг дээшлүүлэх талаар тодорхой бодлоготой болж, тууштай хэрэгжүүлэх цаг болжээ гэж хэлэх хэрэгтэй. Энэ асуудалд бид ихээхэн анхаарал тавьж, удахгүй “Иргэний нийгэм ба иргэний боловсрол” сэдэвт чуулганыг мөн энэ танхимд зохион байгуулахаар бэлдэж буйгаа энэ дашрамд сонордуулья.

Төрийн албан хаагчийг хууль бусаар халж, чөлөөлөх явдал тасрахгүй байна. Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцахад ч энэ талаар тоо баримттай хэлж байсан. Төрд алба хааж байгаа иргэдийг ингэж хохироохоос урьдчилан сэргийлэх, хохироосон этгээдэд зохих хариуцлага тооцох, шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд мөн л хий зай гарч, хохирогчийн эрх сэргээгдэхгүй сар жилээр чирэгдэх явдал байсаар байгааг хүмүүс шүүмжилж байна. Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулсан нь төрийн албан хаагчийн эрхийг хамгаалахад томоохон дэвшил болсон. Гэхдээ энэ талын бүх асуудлыг шүүхэд найдаж орхих учиргүй.

Намчирхах, нутгархах, тал тохой татах, төрөл садансах зэрэг янз бүрийн ашиг сонирхлын зөрчлийн үүднээс төрийн албанд ажиллаж байгаа иргэнийг дур зоргоороо халж сольсон удирдах албан тушаалтныг тухайн албан тушаалын шаардлагыг хангахгүйгээ харуулсан гэж үзэж хариуцлага тооцож байх нь зүйд нийцнэ. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой

байдлыг хангах, төрийн албан хаагчийн эрхийн баталгааг сайжруулах талаар миний санаачилж Улсын Их Хуралд өргөн бариад байгаа “Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлд олон чухал асуудлуудыг тусгасан. Энэ хуулийг баталснаар хууль бус шийдвэрийн улмаас төрийн албан хаагч хохирохгүй байхад томоохон ахиц гарна гэдэгт итгэлтэй байна. Энэ төрлийн зөрчлийг гаргахгүй байх, таслан зогсоох, нэгэнт хохирсон иргэний эрхийг сэргээхэд Засгийн газар, Төрийн албаны төв байгууллага шийдвэрлэх үүрэгтэй. Ялангуяа Төрийн албаны төв байгууллага энэ талаар үзэгдэж харагдахуйц ажил хийж, ахиц гаргах шаардлагатай байгааг энд зориуд тэмдэглэж байна.

Нийгмийн анхдагч эд эс болсон гэр бүлүүд эв нэгдэлтэй, бат бэх байхаас үндэсний эв нэгдэл, аюулгүй байдал шалтгаална. Гэтэл хохирсон хүмүүсийн багагүй хувь нь гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй байгааг энэ талын судалгаа харуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, үүнээс үүдсэн таарамжгүй орчин нь байнгын шинжтэй учраас хүнийг бие махбодын төдийгүй, сэтгэл санаагаар туйлдуулан дарангуйлдаг нь ойлгомжтой. Үүнээс болж гэр бүл салж сарних, орон гэрээ орхин тэнүүчлэх, сэтгэл санааны гутралд орох, хуримталсан хорсол хилэнгээсээ болж нэг нь гэмт хэрэгтэн болж, нөгөө нь эрсдэх зэрэг янз бүрийн таагүй үр дагаварууд үүсч байна. Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл нь хорвоод мэндлээд хэнд ч муу зүйл хийгээгүй хүүхдүүдэд маань хамгийн хүнд тусч байгааг анхаарахгүй байх аргагүй.

Төрөөс энэ байдалд анхаарал хандуулж “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль”-ийг Улсын Их хурлаас батлан мөрдүүлсэн боловч түүний хэрэгжилт хангалтгүй байгааг өнөөдөр зарим иргэд маань шүүмжилж байна. Хууль гаргаснаар л асуудал шийдэгдэхгүй, харин түүнийг бодит байдлаар хэрэгжүүлэхэд голлон анхаарах учиртай. Тэр болгон ил тодорхой байдаггүй гэр бүлийн хүчирхийлэлтэй төрийн байгууллага дангаараа тэмцэж үр дүнд хүрэх бололцоо муутай. Иймд төрийн холбогдох байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд хамтарч, тодорхой үр дүнд гаргах талаар хамтын ажиллагаагаа илүү үр нөлөөтэй явуулах шаардлага тулгамдаж байна.

Манай иргэд гадаадын орнуудад урт богино хугацаагаар ажиллаж амьдрах, суралцах нь хэвийн үзэгдэл болжээ. Энэ бол орчин үеийн зүй ёсны хандлага юм. Энэ байдалд гадаадад байгаа иргэдийнхээ аюулгүй байдалд санаа тавих, аливаа хуль бус үйлдлээс хохирохоос нь урьдчилан сануулж, сээрэмжлүүлэх, нэгэнт хохирсон бол олон улсын эрх зүйн

хэм хэмжээнд нийцсэн шаардлагатай туслалцааг цаг алдалгүй үзүүлэх асуудалд ч зориуд анхаарах цаг болсон байна.

Хохирогчийн эрхийн баталгааг хангахын тулд юуны өмнө хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх, мөн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах тухай төрөлжсөн хуулиуд батлан гаргаж, хохирогчийн нэгдсэн бүртгэлтэй болж, хохирлын үнэлгээг нарийвчлан тогтоох шалгуур, журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн энэ асуудалд шинжлэх ухааны үндэстэй хандахад хохирогч судлалын шинжлэх ухааныг эх орондоо хөгжүүлэх, энэ чиглэлийн сургалт, судалгааны ажлыг дэмжих бодлогыг баримтлах хэрэгтэй байна. Хохирогчийн эрхийн баталгаа нь зөвхөн эрх зүйн баримт бичигт тусгагдсанаар бус, түүнийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, мөн иргэдийн мэдлэг боловсрол, сонор сэрэмжтэй байдал, нийгмийн бүхий л харилцаа хариуцлагатай болохоос шууд хамааралтай гэдгийг эцэст нь сануулж хэлье. Ний нуугүй хэлэхэд өнөөдөр манай нийгмийн харилцаанд хариуцлагагүй байдал ихээхэн газар авсан тул хохирогчийн тоо нь олон асуудал нь хурц болж байна. Энэхүү чуулган хохирогчийн эрхийн баталгааг хангах асуудалд дорвитой хувь нэмэр оруулна гэж найдаж байна. Чуулганаас гаргах зөвлөмжийг бүх шатанд хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажиллацгаая. Чуулганы ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**“ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА” СЭДЭВТ
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД
МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН СУУРИН ЗОХИЦУУЛАГЧ
ПРАТИБА МЕХТАГИЙН ХЭЛСЭН ҮГ**

2007 оны 12 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгч ноён Намбарын Энхбаяр Танаа,

Эрхэм хүндэт төлөөлөгчид, нөхдөө,

Өнөөдөр Хүний эрхийн үндэсний III дугаар чуулган дээр Монгол Улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудыг төлөөлөн та бүхэнтэй мэндчилж байгаадаа баяртай байна. Энэхүү чуулганы зорилго нь хүний эрхийн тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцэж, хүний эрх, эрх чөлөөний байдлыг сайжруулах, хөхиүлэн дэмжих бодлогын зөвлөмж гаргахад оршдогийг Та бүхэн сайн мэдэж байгаа.

Энэ жил бид хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог эргэн харж хэлэлцэхээр цугларсан билээ. Энэхүү чухал асуудлыг хөндөхөөс өмнө би хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудалд тусгагдсан өөр нэгэн чухал зүйл болох өмнөх чуулганаас гаргасан зөвлөмжийн биелэлтийн талаар уламжлал ёсоор дурдмаар байна.

Өнгөрсөн жил бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх сэдвийг сонгон хэлэлцэж, зөвлөмжийн баримт бичиг баталж гаргасан. Эдгээр зөвлөмжүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгаалалт, халамж, туслалцаа хүртэгчид гэх төсөөлөл, хандлагыг өөрчлөн тэдгээрийг нийгмийн бүрэн эрхтэй гишүүд хэмээх ойлголтыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн. Зөвлөмжийн хүрээнд бид хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, нийгмийн амьдрал, хөгжилд оролцох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн адил тэгш, бүрэн дүүрэн оролцоог дэмжих бүс нутгийн чуулга уулзалтууд зэрэг ажлуудыг амжилттай зохин байгуулсан.

Дээрх зөвлөмжүүдэд тусгагдсан үйл ажиллагаанууд үргэлжлэн хэрэгжсээр байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Тухайлбал, Олон улсын хөдөлмөрийн байгууллага Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон бусад түншүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн нөхөн сэргээх төвийн үйл ажиллагааг шинэчлэх

томоохон төсөл хэрэгжүүлэх талаар анхааран судалж байна. Үндэсний нөхөн сэргээх төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд нөхөн сэргээх бүх төрлийн үйлчилгээ, чанартай мэргэжлийн сургалтад хамрагдах боломжийг баталгаажуулах юм.

Түүнчлэн, НҮБ-аас дэмжиж буй өөр нэгэн санаачлага бол Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын Конвенцид нэгдэн орох асуудал юм. Олон улсын конвенцид нэгдэн орж түүний биелэлтийг хангаснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд чадваржих, тэдгээрийн тусгай хэрэгцээнд нийцсэн, тэдгээрийг хүндэтгэсэн нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдрал дахь идэвхтэй оролцоо нэмэгдэх болно. Мөн энэхүү конвенцид нэгдэн орох ажилд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний байгууллагуудын оролцоо, санаачлага чухал гэдгийг тэмдэглэмээр байна.

Өмнөх чуулга уулзалтын зөвлөмжүүд өнөөдөр батлагдах зөвлөмжүүдийн хамт Та бүхний идэвх, санаачлагаар бүрэн гүйцэд биелэгдэнэ гэдэгт итгэл дүүрэн байгаа болно.

Эрхэмсэг ноёд хатагтай нараа,

Өнөөдрийн чуулга уулзалтын сэдэв гэмт хэргийн хохирогчийн эрхийг нөхөн сэргээх асуудал билээ. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид зааснаас гадна гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийн хохирогчийн эрхийг тус улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гол бичиг баримт болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай Конвенц, Хүүхдийн эрхийн Конвенц, Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын Конвенц болон бусад хүний эрхийн олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээр хамгаалсан байдаг. Үүнтэй холбоотой нэгэн чухал баримт бичиг бол 1985 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей-ийн 40/34 дүгээр тогтоолоор батлагдсан Гэмт хэрэг болон албан тушаалаа урвуулан ашигласны улмаас хохирогсдод зориулсан шударга ёсны үндсэн зарчмуудын тухай тунхаглал юм. Эдгээр олон улсын баримт бичгүүдэд дурдсан хүний эрхийн хэм хэмжээ нь агуулгаараа хүний хөгжлийн үзэл баримтлалтай салшгүй холбоотой болохыг та бид сайн мэдэж байгаа билээ.

1985 оны тунхаглалд тодорхойлсноор “хохирогч” гэж эрүүгийн хууль, эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг хориглосон бусад хууль тогтоомж зөрчсөний улмаас дангаараа буюу бүлгээрээ бие болон

сэтгэл санааны хохирол амссан, сэтгэлийн шаналалд, эдийн засгийн алдагдалд орсон буюу үндсэн эрхээ эдлэхэд нь бодитой доройтол учирсан хүмүүсийг хэлнэ гэжээ.

Хүний эрхийн олон улсын гэрээний төсөл боловсруулагчид өөр өөр эрх зүйн уламжлалыг төлөөлдөг хэдий ч, шударга ёсны үндсэн зарчмууд нь улс орнуудын хувьд нийтлэг байх бөгөөд хохирогчийн эрхэд эрхээ хамгаалуулах, сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх, эрх зүйн тусалцаа авах зэрэг түгээмэл хэм хэмжээ багтдаг байна.

Хохирогч эрхээ хамгаалуулах гэдэг нь чирэгдэлгүй, шударга, өртөг багатай, хүртээмжтэй албан болоод албан бус хэлбэрээр хохирлоо барагдуулдаг шүүхийн болон захиргааны хэрэгслүүдийг байгуулж бэхжүүлэхийг шаарддаг билээ. Монгол Улсын хувьд хууль зүйн үйлчилгээний тогтолцоог алслагдсан нутагт болон нийслэлийн захын хорооллуудад байгуулах нь хохирогчид, нэн ялангуяа ядуу, эмзэг бүлгийн болоод төрийн эрх зүйн хамгаалалтад хамрагдах нийгмийн бусад бүлгийн хүмүүсийн хууль зүйн үйлчилгээний хэрэгцээг хангахад маш чухал юм. Засгийн газар энэ асуудлыг шийдвэрлэх чиглэлээр “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн тусалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, эрх зүйн тусалцааны төвүүд байгуулах талаар манай байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хууль зүйн үйлчилгээний тогтолцоог оновчтой, хүртээмжтэй болгоход илүү ихийг хийх шаардлагатай байна.

Хохирогчдод эрхээ сэргээлгэхэд өмчийг эргүүлэн олгох, гэмт зөрчлийн өмнөх байдлыг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг бусад ажиллагаа багтах бөгөөд үүнд нэн ялангуяа бүлгээрээ хохирсон хохирогчдод нөхөн олговор олгох нь хүний эрхийн түгээмэл зөрчлийг арилгах чухал арга хэрэгсэл гэдгийг анхааран үзэх нь чухал билээ. Нийтийн ашиг сонирхлыг шүүхээр нэхэмжлэн хамгаалах ажлыг дэмжих талаар Хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах явцад хүрээлэн буй орчинд учруулсан хор хөнөөлийг үнэлэх шүүх шинжилгээний арга хэрэгсэл хомс байгаагаас шударга ёсыг тогтооход ихээхэн саад учирч байгааг тогтоосон. Бүлгээрээ хохирсон хохирогчдын эрхийг сэргээхэд шударга, хараат бус шүүх олон нийтийн ашиг сонирхлыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн бүс нутагт амьдарч байгаа нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалж, байгаль орчинд хор хөнөөл учруулагддаг үйлдсэн гэмт хэргийнх төлөө хариуцлага хүлээлгэх нь чухал билээ.

Гэмт хэрэг болон албан тушаалаа урвуулан ашигласан үйлдлийн хохирогчдын хохирлыг зохих ёсоор, бодитоор, түргэн шуурхай нөхөн барагдуулах нь шударга ёсыг тогтоох гол хүчин зүйл юм. Онц ноцтой гэмт хэргийн хувьд нөхөн төлбөрийг буруутай этгээд болон бусад эх үүсвэрүүдээс бүрэн төлөх боломжгүй тохиолдолд засгийн газар үндэсний зохих мөнгөн санг байгуулах, бэхжүүлэх замаар санхүүгийн нөхөн төлбөрийг барагдуулах арга замыг эрэлхийлэх хэрэгтэй. Ноцтой гэмт хэрэг гэдэгт төрийн албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ үндэснийхээ эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл ордог. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын эрүүдэн шүүхийн тусгай илтгэгч 2005 онд Монгол Улсад ирж ажилласны дараагаар гаргасан зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар анхааралдаа аван биелэлтийг хангаж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Хохирогчдод үзүүлэх тусалцааг эрх зүй, эд материал, эрүүл мэнд, сэтгэл зүйн болон нийгмийн халамжийн хэлбэрээр төрийн, сайн дурын, олон нийтийн болон орон нутгийн байгууллагуудаар дамжуулан хүргэх ажил багтдаг байна. Хохирогчдод үйлчилгээ, тусалцаа үзүүлэхдээ амссан хохирлоос хамааран тусгай хэрэгцээ, шаардлагатай хохирогчдод онцгойлон анхаарал тавих нь зүйтэй юм. Эмзэг хохирогчдод тэдний хүртэх боломжтой эрүүл мэнд, нийгмийн халамж болон бусад тусламжийн талаар мэдээлэл өгч, тэдгээр тусламж үйлчилгээг хямд, хүртээмжтэй байлгах хэрэгтэй. Шүүх, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ болоод бусад албаны хүмүүсийг тусгай хэрэгцээтэй хохирогчдын байдлыг ойлгох чадвартай болгох сургалтанд хамруулж зохистой, шуурхай тусламж үзүүлэх арга зүй, удирдлагаар хангах нь зүйтэй. Хууль зүй, дотоод хэргийн яамтай хэрэгжүүлж буй Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх НҮБ-ын хамтарсан хөтөлбөр нь тэдгээр тусгай хэрэгцээтэй хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, тусламжийг сайжруулахад чиглэсэн болно.

Эрхэмсэг ноёд хатагтай нараа, Хүндэт оролцогч нөхдөө,

Өнөөдрийн чуулга уулзалтын хэлэлцүүлэгт багтах гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн хохирогчдод тулгамдаж буй асуудлаар судалгаа хийсэн гурван судалгааны багийн гишүүдэд Та бүхэн надтай хамт талархлаа илэрхийлнэ гэдэгт итгэлтэй байна. Үүнээс илүүтэйгүүр эдгээр хэлэлцүүлгүүд нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих хууль тогтоомжийг боловсруулах, биелэлтийг нь хангахад хууль зүйн

салбарт хөгжлийн үзэл баримтлалыг оруулах шаардлага байгаа талаар илүү ойлголтыг өгнө гэдэгт найдаж байна. Хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд эрх зүйн зохицуулалт, эдийн засгийн бодлогоор ядуу, нийгмийн эмзэг бүлгийн гишүүдийн эрх ашгийг нэн түрүүнд хамгаалах улс төрийн хүсэл эрмэлзэл чухал ач холбогдолтой билээ.

Эрхэм хүндэт зочид, ноёд, хатагтай нараа,

Хохирогчидтой хүнлэг энэрэнгүй, хүндэтгэлтэй харьцах нь зүйд нийцэж, тэд арьс, өнгө, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, эд хөрөнгө, яс үндэс, нийгмийн гарал үүсэл болон хөгжлийн бэрхшээлтэй байдлаасаа үл хамааран хууль зүйн үйлчилгээг хүртэж, хохирсон эрхээ сэргээлгэх эрхтэй юм.

Энэхүү завшааныг ашиглан Та бүхний анхаарлыг ирэх жил болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 60 жилийн ойд хандуулья. НҮБ энэхүү түүхэн чухал үйл явдлыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан алдар хүнд, шударга ёсыг хүн бүрт түгээх үзэл санааг дэлгэрүүлэх аяны ажлаар дамжуулан бүтэн жилийн турш дэлхий даяар өрнүүлэн тэмдэглэх юм. Өнөөдрийн энэ чуулганаас гарах зөвлөмжүүд агуулгын хувьд дэлхий даяар явагдах шударга ёсыг хүн бүрт түгээх аяны үзэл санаатай нэгдмэл байна гэдэгт итгэлтэй байна.

1998 оны 12 дугаар сард Монгол Улсын Засгийн газар болон НҮБ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойг тохиолдуулан Хүний эрхийн талаарх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж байсныг бид цөмөөрөө санаж байгаа билээ. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих бидний хамтын ажиллагааны үндэс суурийг тавьсан тэрхүү чухал баримт бичгийг эргэн харах, хэрэгжилтийн дүгнэх боломж дараагийн үндэсний чуулга уулзалтаар гарна гэдэгт итгэл дүүрэн байна.

Өнөөдрийн энэхүү чуулга уулзалт амжилт, ололтоор дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг Та бүхэнд хүргэе.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**“ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА” СЭДЭВТ
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ АЖИЛЛАГААГ НЭЭЖ,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Т.БИЛЭГТИЙН ХЭЛСЭН ҮГ**

Улаанбаатар хот. Төрийн ордон.

2007.12.04

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Үндэсний чуулганы хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Хохирогчийн эрхийн баталгааг хангах асуудлаар зохион байгуулж байгаа энэхүү үндэсний чуулганы ажиллагаанд оролцож буй Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Үндэсний чуулганы ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, Улсын Их Хурал, Засгийн газрын зарим гишүүд, НҮБ-ын суурин төлөөлөгч Пратиба Мехта, манай улсын төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн төлөөлөгчид, хууль зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын багш, оюутнуудын төлөөлөгч зэрэг 800 гаруй хүн оролцож байна.

Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр тэмдэглэдэг олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс хамтран хүний эрхийн тулгамдсан асуудлыг үндэсний чуулганаар хэлэлцүүлдэг уламжлал тогтоод байгаа билээ.

2005 онд хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн, 2006 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлын талаар Үндэсний чуулган зохион байгуулж чуулганаас гаргасан зөвлөмжийн дагуу олон чухал ажил зохиож, асуудлуудыг шийдвэрлэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчид иргэдээс ирүүлж байгаа захидлуудын дотор гэмт хэргийн улмаас болон байгууллага, албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаа, хүчирхийллээс хохирсон иргэдийн гомдол, мэдээлэл нилээд хувийг эзэлдэг.

Хохирсон хүмүүс зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд зарим үед эрх зүйн зохицуулалт гүйлгэгдэж, төрийн байгууллагуудын элдэв шат дамжлага, хүнд суртал саад болохын зэрэгцээ зарим албан тушаалтнуудын

хариуцлагагүй байдал ч иргэдийг гомдоож, цөхрүүлэхэд хүргэдгийг тэдгээр захидлуудад дурдсан байдаг.

Энэ удаагийн чуулганыг “Хохирогчийн эрхийн баталгаа” гэсэн сэдвээр сонгон зохион байгуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй,” “төрөөс ...хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна...” гэж заасныг амьдралд хэрэгжүүлэхэд энэ чуулганы зорилго оршиж байгаа юм.

Эрхэм хүндэт төлөөлөгчид өө,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж байгаа “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт үндэсний чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

2006 ОНЫ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Ц.Нацагдолгор,
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хүн амын хөгжил,
нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын газрын дарга

2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан хүний эрхийн үндэсний чуулганаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй бэрхшээлийн талаар хэлэлцэж, холбогдох төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудад хандсан 59 зүйл бүхий зөвлөмж гаргасан билээ.

Зөвлөмж нь Улсын Их Хурал, Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээвэр, аялал, жуулчлалын яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Үндэсний статистикийн газар, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар зэрэг тухайлсан байгууллагад хандсан байснаас гадна орон нутгийн бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүд, иргэний нийгмийн, урлаг соёлын болон хувийн хэвшлийн байгууллага зэрэгт хандсан нийтлэг заалттай байсан. Түүнчлэн, зөвлөмжид тусгагдсан зарим арга хэмжээ богино хугацааны дотор хэрэгжих бололцоотой байхад зарим нь ажил хэрэг болоход нэлээд удаан хугацаа шаардагдах асуудлууд байв.

Хүний эрхийн үндэсний комисс, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо зэрэг төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулагдан зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьсан байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлснээр доорх үр дүн гарсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан 11 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн барьснаас 2007 оны 8 дугаар сарын 3-нд Авто замын тухай, Эрүүл мэндийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Хөдөлмөрийн тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай, Авто тээврийн тухай, Биеийн тамир, спортын тухай зэрэг 9 хуульд хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт орсон байна.

2. НХХЯ-аас үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ийм шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй болох явдлыг багасгах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн төсөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын арга хэмжээд ялгаваргүй хамруулах зорилгоор нийгмийн халамжийн тухай болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлж эхлээд байна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байр бий болгосон ажил олгогчийг урамшуулах хөшүүргийг бий болгох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансыг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг 2007 оны 1 дүгээр сард шинэчлэн баталсан байна.
4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 20 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч ажил олгогчийг урамшуулах болзол”-ыг шинээр батлан мөрдөж байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж болох ажлын байрны жагсаалт гаргах талаар судалгаа хийж байгаа ба УИХ-д өргөн бариад байгаа Хөдөлмөрийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах” тухай заалтыг тусган оруулжээ.
6. Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчныг шагнаж, урамшуулах журам Засгийн газрын 2007 оны 208 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдаж, хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл тамирчинд олгогдох шагналын зөрүүг арилгасан болно.
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар тусгай сургуулиудыг нэгтгэн цогцолбор болгон зохион байгуулсан шийдвэрийнхээ үр дүнг БСШУЯ-наас судалж,

харааны согогтой хүүхдийн сургуулийг тусдаа үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлжээ.

8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын стандарт боловсруулах судалгааг Сэргээн засалтын үндэсний төв, ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуультай хамтран хийж, шинээр боловсруулах ажлыг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн 2008 төлөвлөгөөнд тусгуулсан байна.
9. Түүнчлэн, Барилга хот байгуулалтын яамнаас Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны захиалгатай засвархийгдэж байгаа болон шинээр баригдах, тусламжийн хөрөнгө оруулалттай 42 объект, улсын төсвийн хөрөнгө оруулалттай 18 объект, зээлийн хөрөнгө оруулалттай 8 объект, улсын төсвийн хөрөнгө оруулалттай замын 28 объект, Эрүүл мэндийн яамны захиалгатай эмнэлгийн 9 объект, хангамж, үйлчилгээний барилга 2 объектын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийг тусгажээ.
10. Зам, тээвэр, аялал, жуулчлалын яамнаас 2006 оны 12 дугаар сард “Явган хүн ба хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан замын техникийн шаардлага MNS 5682 -2006” үндэсний стандартыг боловсруулан батлуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зам барих техникийн шаардлагыг боловсруулж, 2007 оны 12 дугаар сард батлуулахаар ажиллаж байна.
11. 2008 оны сонгуулийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй сонгууль болгон зохион байгуулах талаар Сонгуулийн ерөнхий хорооноос тодорхой ажлууд зохион байгуулжээ. ХБИБҮХ-той хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нарийвчилсан судалгаа гаргаж байна. Түүнчлэн, Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч хараат бус сонголт хийх боломжийг бүрдүүлэх үүднээс 20 сая төгрөгийг ирэх оны төсөвт суулгахаар санал өгчээ.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:

Тодорхой байгууллагуудад зөвлөсөн 47 арга хэмжээний 14 нь 50-100 хувийн биелэлттэй, 8 ажил тасарсан, үлдсэн 25 ажил 50 доош хувийн биелэлттэй, хэрэгжих явцтай байна.

Энэ арга хэмжээ нь зөвхөн нэг жилийн хүрээнд хийгдээд дуусах бус цаашид ч үргэлжлүүлэх тасарсан болон хараахан бүрэн биелэгдэж

амжаагүй ажлуудыг хариуцсан байгууллагуудад дахин тодорхой хугацаа өгч гүйцэтгүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Тухайлбал НХХЯ-ны зүгээс:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийг соёрхон батлуулах ажлын явцыг сайжруулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцыг олон нийтэд мэдээлэх, “Хөдөлмөрийн чадвар түр алдалтын хувь хэмжээ тогтоох жагсаалт, заавар”-ыг Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар шинэчлэн боловсруулан батлуулах ажилд анхааран ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГААГ ХАНГАХ АСУУДАЛ

Ц.Мөнх-Оргил,
УИХ-ын гишүүн, Хууль зүйн
байнгын хорооны дарга

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Хүний эрхийн үндэсний чуулганыг зохион байгуулж буй Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олонд талархал илэрхийлье.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг чуулган энэ удаа манай нийгмийн өмнө, тэр дундаа шүүх, хууль хяналтын байгууллагуудын өмнө тулгараад байгаа хамгийн хурц асуудлын нэг “Хохирогчийн эрхийн баталгаа”-ны асуудалд анхаарлаа хандуулж байгаа нь яах аргагүй цагаа олсон чухал арга хэмжээ болж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 5.1.9-д зааснаар “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогч, түүний төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч” бүгд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч талууд юм. Гэтэл байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг ярихдаа бид ихэвчлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтны эрхийг хангах тал дээр анхаарлаа хандуулж ирлээ. Сэжигтэнг цагдан хорих хугацааг багасгах, цагдан хорих болон хорих ял эдлүүлэх байрны 1 хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, ялтны хоолны илчлэгийг шалгах гэх мэтчилэн олон асуудлыг бид ярьсаар, шүүмжилсээр, төрийн зүгээс чадах чинээгээрээ анхаарсаар ирсэн. Төрийн хуулийн энэрэнгүй талыг харуулж, эдгээр асуудлыг шийдэх нь зайлшгүй хийх ажил мөн боловч энэ явцдаа бид Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд оролцогч бас нэгэн тал болох хохирогчийн эрхийн байдлыг төдийлөн анхаарахгүй орхисон нь өнөөдөр илт байна.

Хохирогчийн эрхийг хангах нь зөвхөн хуулийн байгууллагууд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд ногдсон үүрэгт ажлаа хийснээр дуусахгүй бөгөөд олон улсын болон төрийн бус байгууллагуудын

дэмжлэг туслалцаатайгаар, бусад улс орнуудын алдаа оноог судалж, тэдгээрийн туршлагыг Монголын хөрсөнд бүтээлчээр суулгах замаар эдийн засаг, эрх зүйн цогц арга хэмжээ авах шаардлагатай болжээ.

Хэдийгээр гэмт хэргийн улмаас хохирогчдод бие махбодын болон эд хөрөнгийн хохирлыг хагас дутуу нөхөн барагдуулсан болоод өнгөрч байгаа ч яг үнэндээ энэ нь гэмт хэргийн улмаас тухайн хүнд учирсан хохирлын зөвхөн нэгээхэн хэсэг нь бөгөөд бидний огт анхаардаггүй, тооцож ч чадахгүй өнгөрч байгаа хохирол бол түүний сэтгэл санааны хохирол байдаг. Гэмт хэрэгт өртсөний улмаас цочирдох, стресст орох, айдаст автах, өөртөө итгэх итгэлээ алдах, өөрөөсөө ичих, өөрийгөө буруутгах, гэмт хэрэгт өртсөнөөс болж нэр хүнд нь гутаагдах, орчиндоо хэвийн аж төрөх боломжгүй болсноос шилжин нүүх, ажлаа солих, цаашилбал, амиа хорлох явдал хүртэл гарч байна.

Гэтэл манайд хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл санааны шаналалыг даван туулахад дэмжлэг үзүүлэх, хохирогчийг хамгаалалтад авах, нууцлах, нэр, хаягаа өөрчлөхөд нь туслах зэрэг хохирогчдод хэвийн амьдралдаа буцаж ороход нь туслах тогтолцоо үгүйлэгдэж байна.

Хохирогчийн эрхийг хангах энэ өргөн цар хүрээтэй үйл ажиллагаанаас түүний эрх зүйн баталгаатай холбогдсон асуудлыг хөндөө.

Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад хохирогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байдаг.

Эдгээр хуулиудад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц дахь хохирогчийн эрх зүйн байдал, хохирол нөхөн барагдуулах үйл ажиллагаа гэсэн хоёр үндсэн асуудлаар хохирогчийн эрх зүйн байдлыг авч үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц дахь хохирогчийн эрх зүйн байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т зааснаар “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах”, “... хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гэж заасан байдаг.

Үүнтэй уялдуулан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн,

эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг “хохирогч” гэж тодорхойлжээ. Хуульд зааснаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч нь өмгөөлөгч авах, хэргийн талаар баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримтыг шалгуулах, шүүх хуралдаанд оролцох, шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах, мэдүүлэг өгөх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, цагаатгах буюу шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах зэрэг нэлээн өргөн эрхтэйгээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцдог.

Ингэхдээ хохирогч мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заажээ. Энэ нь хэдийгээр хэргийн бодит үнэнийг тогтооход чухал зохицуулалт боловч гэмт хэргийн улмаас хохирогч сэтгэл санааны цочролд орсон, нэр төр нь гутаагдсан, айн цочирдсон зэргээс болж буруу, ташаа мэдүүлэг өгөх, нэр төрөө бодоод мэдүүлэг өгөхөөс татгалзах явдал гардаг.

Хэргийн гэм буруутныг тогтооход хамгийн үнэн, зөв мэдээлэл өгч чадах этгээд бол хохирогч байдаг. Гэтэл хохирогч нь гэмт хэрэгт өртөж ихэвчлэн айн цочирдсон, сэтгэлээр унасан байдаг тул ийнхүү мэдүүлэг өгөхийн тулд хохирогч нэгдүгээрт сэтгэл зүйн хувьд тогтвортой болсон, нөгөөтэйгүүр мэдүүлэг өгснөөр гэмт этгээдээс түүний аюулгүй байдалд халдахгүй гэсэн баталгааг өгөх нь чухал юм.

Малыг нь хулгайлсан хулгайчийг хэсгийн төлөөлөгчдөө зааж өгсний төлөө хулгайчийн ах, дүүд зодуулж давхар хохирсон, гадуур шалгагдаж байгаа сэжигтэн хохирогчоо дарамталсан, утсаар загнасан, занасан, нас барсан хохирогчийн ар гэрийнхнийг басамжилсан, мэдүүлэг өгснийхөө төлөө зодуулсан тухай өргөдөл, гомдол тасрахгүй байна.

Иймд хохирогчийг хамгаалах, түүний нэр, хаягийг нууцлах, шаардлагатай бол өөр газар нүүн шилжүүлэх, дүр, төрхийг хувиргах зэргээр байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийн эрхийн баталгааг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал байна.

Мөн хохирогч байцаан шийтгэх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгч хөлслөх нь бараг үгүй байна. Монголын

өмгөөлөгчдийн холбооны судалгаанаас үзэхэд 10 хохирогчоос зөвхөн нэг нь л өмгөөлөгч авдаг байна. Энэ нь магадгүй хохирогч өөрийгөө гэм буруугүй гэж үздэг, хууль эрх зүйн мэдлэг хангалтгүй байдагтай холбоотой боловч нөгөө талаас та бид хохирогчдод туслах, тэднийг соён гэгээрүүлэх тал дээр дутуу ажиллаж байгаагийн илрэл болов уу.

Хохирогчийн эрх зүйн байдлын нэг асуудал нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах асуудал бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 44 дүгээр бүлэгт эдгээр төрийн албан хаагчдын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх иргэдийн эрхийн талаар дэлгэрэнгүй тусгасан.

Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахаар хуульд заасан боловч хохирол барагдуулах хөрөнгийг төсөвт суулгадаггүйгээс бодит амьдрал хэрэгжилт муутай байна.

Нөгөөтэйгүүр хариуцлага алдсан, хууль зөрчсөн дээрх төрийн албан хаагчдад зохих шийтгэл ногдуулах, дахин ийм хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд хуулийн байгууллагууд анхаарал хандуулмаар байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах талаар

Хохирогчийн эрх эрх зүйн байдлын баталгааг хангах нэг чухал асуудал бол хохирлыг нөхөн барагдуулах явдал юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т зааснаар Монгол Улсын иргэн бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1-д заасны дагуу төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар хуульчилж өгсөн нь төрийн байгууллага, түүний албан тушаалтнууд иргэдийнхээ хууль ёсны эрхийг хөндөхгүй байх, хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө бүрэн

хариуцаж иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалахыг үндсэн зарчмаа болгон ажиллах ёстой гэж ойлгогдож байна.

Тиймээс иргэнийхээ аюулгүй амьдрах нөхцөлийг хангаагүй, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж чадаагүйгээс иргэн гэмт хэргийн золиос болж байхад түүний эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудал нь төрийн үүрэг бөгөөд энэ нь гэмт этгээдийг илрүүлж, шийтгэхээс дутуугүй чухал асуудал юм.

2007 оны эхний 9 дүгээр сарын статистикаас харахад улсын хэмжээнд хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 4600 орчим гарснаас гэмт хэргийн улмаас нийт 1417 гаруй хүний амь нас эрсдэж, 1800 орчим хүн хүнд болон хүндэвтэр гэмтэл авчээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтдээ хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас 1,2 тэрбум төгрөг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн улмаас 57.6 тэрбум төгрөг, бусад төрлийн гэмт хэргийн улмаас нийтдээ 59 гаруй тэрбум төгрөгийн хохирол барагдуулахаас одоогийн байдлаар 1.6 тэрбум төгрөгийн хохирол барагдуулаад байна. Нийт хохирлын 2.7 хувийг л барагдуулсан байгаа нь аль ч талаас харсан хангалтгүй үзүүлэлт мөн.

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 16 хүн тутмын 10 нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 9 хүн тутмын 1 нь урьд ял шийтгэгдэж байсан, 3 хүн тутмын 1 нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэгсдийн дийлэнх нь санхүүгийн хувьд боломж муутай хүмүүс байдгаас учруулсан хохирлоо барагдуулах төлбөрийн чадваргүй байдаг байна.

Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хангах асуудлаар зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах зэргээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжинд хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж, гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нөхцлийг бий болгох үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоох, тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох

зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь бас үнэн.

Түүнчлэн, Иргэний хуульд “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” гэсэн байдаг боловч зөвхөн эд хөрөнгийн бодитой хохирол, гарсан зардлыг тооцох, төлүүлэх тал дээр хуулийн байгууллагууд анхаарлаа хандуулж байна. Сэтгэл санаа, эрхийн болон бусад эд хөрөнгийн бус хохирлыг арилгах асуудлыг судалж, хууль тогтоомжид нарийвчлан тусгах шаардлага байна.

НҮБ-аас 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчийн талаарх эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчмын тухай” тунхаглал баталсан. Уг тунхаглалаар гэмт хэргийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах үндсэн зарчмыг тогтоохын хамт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бусад эх үүсвэрээс барагдуулах боломжгүй тохиолдолд хүч хэрэглэсэн хүнд гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, эрүүл мэнд, эд хөрөнгийн хувьд хохирсон хохирогч болон түүний гэр бүлийн гишүүд, асрамж халамжинд нь байсан бусад этгээдэд учирсан хохирлыг төрөөс нөхөн олговор олгох замаар барагдуулж байхыг уриалсан байдаг.

Хохирлыг барагдуулах асуудалтай холбогдуулан миний бие Улсын Их Хурлын гишүүний хувьд хоёр хуулийн төсөл санаачлан боловсруулж, Засгийн газарт саналыг нь авахаар хүргүүлээд байна.

Юуны өмнө, эрүүгийн гэмт халдлагад өртөж амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, хохирлын хэмжээг шүүх тогтоосон боловч гэмт хэрэгтний төлбөрийн чадвараас шалтгаалж хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой хохирогчдод төрөөс мөнгөн туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгай зориулалтын сан байгуулж ажиллуулах тухай хуулийн төслийг удахгүй УИХ-аар хэлэлцүүлэх гэж байна. Дэлхийн олон улс орон ийм сан байгуулж, хохирогчдын эрхийг хангахад ахиц гарсан байна.

Мөн хохирогчийн хохирол барагдуулах баталгааг хангах чиглэлээр боловсруулагдсан Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгалын тухай хуулийн төслийг удахгүй УИХ-д өргөн барих гэж байна. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослын судалгаанаас харахад сүүлийн 3 жилийн байдлаар 15700 гаруй зам тээврийн осол гарч, эдгээр ослын улмаас 1118 хүн нас барж, 3430 хүн

гэмтэж, иргэд байгууллагад 1.6 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Автотээврийн хэрэгслийн жолооч нарын бусдын өмнө хүлээх хариуцлагаа даатгуулснаар даатгалын тохиолдол гарахад талууд даатгалын нөхөн төлбөр авах нөхцөл сайжирч, зам, тээврийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах баталгаа хангагдана гэж хуулийн санаачлагчийн хувьд үзэж байгаа юм.

Эдгээрээс гадна бүх нийтийг хамарсан гамшиг, аюул осол, дэлбэрэлт зэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, түүнчлэн сүүлийн үед олон хүнийг хамарсан, их хэмжээний хохиролтой, ялангуяа залилангийн шинжтэй гэмт хэрэг гарах болсныг анхааралдаа авч эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

Дүгнэн хэлэхэд: Цаашид хохирогчийн эрхийн эрхзүйн баталгааг хангах чиглэлээр та бид багагүй ажил хийх шаардлагатай байна.

Хохирогчийн эрхийг хангах, хохирлыг нөхөн барагдуулах чиглэлээр Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний хууль болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийг сайжруулах, гарцаагүй тохиолдолд эдгээр хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж болох юм.

Хохирогчийн эрхийн баталгааг хангах асуудал нь эдийн засаг, эрх зүйн орчин, хууль тогтоомжийн сурталчилгаа зэрэг нийгмийн бүхий л чиглэлээр төрийн цогц бодлогыг олон улсын туршлагыг судлан өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлыг төр нөхөн төлбөр олгох замаар барагдуулах, сэтгэл зүйн цочролд орсон хохирогчид, ялангуяа бага насны хүүхдүүдэд мэргэжлийн сэтгэл зүйч эмчийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн эмчилгээ хийдэг, хохирогчийг хамгаалах арга хэмжээг авдаг механизмыг бүрдүүлэх, төлбөрийн чадваргүй ялтныг хөдөлмөр эрхлүүлэх замаар төлбөрөө барагдуулах бололцоог хангах зэрэг асуудлыг алхам алхмаар шийдвэрлэж эхэлмээр байна.

“Хохирогчийн эрхийн баталгаа” сэдвээр зохион байгуулагдаж буй Хүний эрхийн үндэсний энэ удаагийн чуулган хохирогчийн эрхийн баталгааг хангах талаар үр дүнтэй, оновчтой арга замыг тодорхойлсон шийдвэр гаргана гэдэгт итгэлтэй байна.

Үндэсний чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**МОНГОЛ УЛСАД ХҮНИЙ ЭРХИЙГ
ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ**

Д.Одбаяр, УИХ-ын гишүүн,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын
үүрэг гүйцэтгэгч

Монгол Улсын Ерөнхийлөгч, Чуулганд оролцогч зочид, төлөөлөгчид
өө!

Одоогоос дөрвөн жилийн өмнө буюу 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдсан билээ. Бид жил бүр Хүний эрхийн үндэсний чуулганд тухайн жилд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын үр дүнг илтгэж ирсэн уламжлалтай.

2007 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нарийвчилсан төлөвлөгөөтэйгээр явуулах, төрийн болон төрийн бус байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тус тусын эрхлэх үйл ажиллагааны хүрээнд хийх ажилтайгаа уялдуулан зохион байгуулах, Үндэсний хөтөлбөрийн хороо, Хорооны ажлын алба болон салбар хороодын үйл ажиллагааг идэвхижүүлж тогтмолжуулах чиглэлээр илүү анхаарч ажиллалаа.

Хуулийг биелүүлэх явцад нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар зарим хүндрэл гарч байгааг арилгах, нийгмийн хөгжлийн явцад шинээр үүсч байгаа харилцааг зохицуулах, хүний эрхийг хангах, хамгаалах, эрх үүргийн нэгдлийг сайжруулах, олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх шаардлагыг харгалзан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулаа. Мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх шатандаа байна.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн “Гэмт хэрэгт холбогдсон этгээд хэргээ шүүхээр аль болох богино хугацаанд шийдвэрлүүлэх, түүнийг цагдан хорьж мөрдөн шийдвэрлэх явдлыг өргөн хэрэглэхгүй

байх...” заалтыг хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд хялбаршуулсан журмаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах хэргийн харьяалал, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл, хялбаршуулсан хэрэг бүртгэх ажиллагаа, шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай тусгайлан зүйл, заалт нэмж тусгалаа.

Насанд хүрээгүй яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 18 сар хүртэл, насанд хүрсэн яллагдагчийг хорьж мөрдөж хугацааг 24 сар хүртэл сунгаж болохоор Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтад нийцүүлэх, хэргийг шуурхай шалган шийдвэрлэх, үндэслэлгүйгээр хүний эрхийг хязгаарлах боломжийг багасгах зорилгоор Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хорьж мөрдөх нийт хугацааг хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд гэмт хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтэрч болохгүй хэмээн ялгаатайгаар багасган тогтоосон.

Дээрх хуульд насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндсэн хугацаа 1 сар байх бөгөөд хорьж мөрдөх нийт хугацаа хүндэвтэр гэмт хэргийн яллагдагчид 2 сараас, хүнд гэмт хэргийн яллагдагчид 4 сараас, онц хүнд гэмт хэргийн яллагдагчид 8 сараас хэтэрч болохгүй байхаар хугацааг багасган тогтоолоо.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” гэсэн заалттай зөрчилдөж байгаа тул 18.1-ийн “...тухайн хүний төрөл садангийн хүнийг дуудан ирүүлж тайлбар гаргуулах” гэснийг хасахаар, жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд 7 хүртэл хоногийн чөлөөг олгохоор заасан бөгөөд энэ хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулж тооцох эсэх талаар тодорхой заагаагүй тул тодруулж, ял эдэлсэн хугацаанд оруулж тооцохоор, гяндан нь жирийн, чанга дэглэмтэй байхаар заасныг өөрчилж, чанга дэглэмтэй холбоотой заалтыг хүчингүй болгохоор тусгав.

Мөн хуульд хорих анги нь эхийн хамт байгаа 0-1 насны хүүхдийг эрүүл мэнд өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр нөхцөлөөр хангах, эмэгтэй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд удаан хугацааны уулзалтыг жилд найман удаа хийж болохоор нэмэлт заалт тусгасан болно.

Шүүх болон хууль хяналтын байгууллагыг мэргэшлийн өндөр мэдлэг, ур чадвар, ёс зүйн шаардлагыг хангасан боловсон хүчнээр бэхжүүлж, тухайн байгууллагын чадавхийг сайжруулах зорилгоор Хуульчдаас сонгон шалгаруулах журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулаа. Энэхүү хуулийн хүрээнд хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг 12 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд зохион байгуулаа.

Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал нь Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн нэг зорилт болон тусгагдсан байдаг. Энэхүү зорилтыг биелүүлэх талаар тодорхой ажлууд хийж байна.

Хадгаламж зээлийн хоршооны үүсгэн байгуулагчдын зарим буруутай, хууль бус үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигч иргэдэд учирсан хохирлын тодорхой хэсгийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах зорилгоор Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулсан болно.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төслийг боловсруулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах сангийн санхүүжилтийн асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөх тэдэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” болон “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсан. Энэхүү хөтөлбөрт заасны дагуу төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хариуцсан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг баталж, ажилд нь оруулаад байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нийгмийн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх эрх зүйн туслалцааны хүрээг өргөтгөх, тэдний өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулах зорилгоор төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан бол уг хэрэгт өмгөөлөгч заавал оролцуулахаар заалт тусгасан.

Хараа хяналтгүй хүүхдийг асрамж, халамжид шилжүүлэх зорилгоор тэнэмэл амьдралтай иргэдийн харьяаллыг тодруулах, бичиг баримттай болгох арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хүүхэд залуучуудын газар,

“Амьдрах ухаан сургалт, үйлдвэрийн тусгай төв”, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын санал хүсэлтээр нийт 399 иргэний материалыг шалган 131 иргэнд холбогдох лавлагаа, 91 хүүхдэд төрсний гэрчилгээг тус тус олгосон байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмж, Монгол Улсын Засгийн газар, Хүний эрхийн үндэсний комиссоос 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зам” сэдэвт үндэсний дээд хэмжээний бага хурлын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс 2007 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд төрсний гэрчилгээг шинээр төрсөн бүх хүүхдэд үнэ төлбөргүй олгохоор шийдвэрлэв.

Цагдаагийн ерөнхий газраас тус төлөвлөгөөний хүрээнд нийслэлийн хэмжээнд орц, хонгилоор тэнүүчилдэг халамж, үйлчилгээний төвд хамрагддаггүй тэнэмэл хүүхдүүдийг аюулгүй орчинд амьдрах, нийгмийн халамж, асрамжид хүлээлгэн өгөх зорилгоор Хүүхдийн халамж үйлчилгээний төвтэй хамтран “Тэнэмэл хүүхэд” арга хэмжээг зохион байгуулж, хараа хяналтгүй 59 хүүхдийг нэгдсэн бүртгэлд хамруулан, 23 хүүхдийг халамж үйлчилгээний төв болон асрамжийн газруудад хүлээлгэн өгсөн байна.

Иргэний бүртгэл-мэдээллийн улсын санг бэхжүүлэн сайжруулах ажлын хүрээнд “Иргэний бүртгэл, паспорт-хяналтын нэгдсэн сүлжээ төсөл”-ийн хөрөнгийн асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэн тодорхой ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд зарим аймаг, сумдыг тус төвийн мэдээллийн сантай холбох төслийг хэрэгжүүлж эхэллээ.

Иргэний бичиг баримтгүй иргэдэд иргэний үнэмлэх олгох, хаягийн бүртгэлгүй хүмүүсийг бүртгэлд бүрэн хамруулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, нийт 37869 иргэдийг баримт бичигтэй болгосон бөгөөд засаг захиргааны нэгж завсардсан 8139, хаягийн бүртгэлгүй 15434 зөрчлийг илрүүлж арилгах арга хэмжээ авчээ.

Иргэний бүртгэл, мэдээлэл, шилжилт хөдөлгөөний асуудлыг цэгцлэх зорилгоор “Иргэний бүртгэлийн улсын үзлэг”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 129 дүгээр тогтоолын дагуу явуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор батлууллаа. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажлын хэсэг байгуулагдсан.

Сонгуулийн ерөнхий хорооноос, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь” төслийн хүрээнд сонгогчдын сонгуульд оролцох оролцоо, ухамсартай, хариуцлагатай сонголтыг нэмэгдүүлэхийн тулд сонгогчдын боловсролын хөтөлбөрийг гарган ажиллаж байна.

Сонгуулийн болон улс төрийн томилогдох албан тушаалд нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх бодлого баримтлах заалтын дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос 2007 оны 06 дугаар сарын 21-нд улс төрийн нам, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон “Сонгууль ба эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт бага хурал зохион байгуулжээ.

Цагдан хорих төвийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, хорих анги, цагдан хорих байранд телекамерын хяналтыг бүрэн нэвтрүүлэх, олон улсын стандартад нийцсэн цагдан хорих байр болон онцгой дэглэмтэй хорих ангийг шинээр барьж байгуулах асуудлыг шийдвэрлэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, сэжигтнийг баривчлах, цагдан хорих ажиллагаа, түүний орчин нөхцлийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор 2007 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдан хорих 461 дүгээр ангийг нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 1000 хүний багтаамжтай цогцолбор барилга байгууламж барих зураг төсвийг батлуулж, барилга угсралтын ажлыг эхлээд байна. “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-ыг шинэчлэн баталлаа.

Цагдан хорих 461 дүгээр ангийн зарим хорих байр, өрөөг шинээр барих буюу шинэчлэн засварлаж, хорих өрөөний агааржуулалт, гэрэлтүүлгийг сайжруулж, нэг хүнд ногдох талбайн хэмжээ, багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор хорих өрөө бүрт нэмэлт цонх гаргасны зэрэгцээ хорих өрөөнүүдэд их засвар хийж, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж, хүний эрхийг хангахад анхаарч ажилласан байна.

Цагдан хорих төвд өмгөөлөгч ажиллах боломжийг бий болгох чиглэлээр Цагдан хорих 461 дүгээр ангид Цагдаагийн ерөнхий газрын харьяа уулзалт, байцаалтын байрны нэгдүгээр давхрыг хамтран ашиглаж хоригдогсдын эргэлтийг зохион байгуулж, хуучин эргэлтийн байрыг засварлан 8 өмгөөлөгчийг нэгэн зэрэг уулзуулах багтаамж бүхий дөрвөн сая найман зуун төгрөгийн өртөгтэй уулзалтын байр байгуулж,

өмгөөлөгч ажиллах боломжийг бүрдүүлжээ.

Нийт хөдөө орон нутаг дахь албадан саатуулах болон баривчлах байруудад орон нутгийн болон тусламжийн байгууллагын хөрөнгөөр засвар хийн ахуй нөхцлийг нь сайжруулаад байна. Тухайлбал, Дорнод аймгийн Цагдан хорих байранд 7 өрөөний шал, 11 ширхэг агааржуулалтын сэнс, 10 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулж өгсөн, Өвөрхангай аймгийн урьдчилан хорих төв нь 1.5 сая төгрөгийн хөрөнгөөр дотроо ариун цэврийн өрөөтэй болсон байна.

Монгол Улсын Засгийн газар 2007 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалтын арга хэлбэрийг сайжруулах тал дээр илүү анхаарч ажилласан нь ажлын үр дүнд эерэгээр нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Урьд нь урсгалаар явж байсан ажлыг тодорхой эзэнтэй болгож, үндэсний хөтөлбөрт тусгагдсан ойрын хугацаанд зайлшгүй хийх шаардлагатай арга хэмжээг 2007, 2008 онд хийх ажлын төлөвлөгөө болгон Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор батлуулан, үүнийг хэрэгжүүлэх ажлыг гардан зохион байгуулах чиг үүрэг бүхий Үндэсний хөтөлбөрийн Хорооны салбар хороо болох 65 хороо улсын хэмжээнд байгуулагдан ажиллаж байна.

Гэвч манай зарим удирдах албан тушаалтнууд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн дагуу хийх ажил нь тэдний үндсэн ажилд хамаарахгүй мэтээр хандаж, хариуцах ёстой ажлаа эзэнгүйдүүлж байгаа нийтлэг дутагдал байна.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолд “... хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тухайн жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг ...төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын ажлыг дүгнэх нэг үндсэн үзүүлэлт болгож байхаар заасныг анхаарч, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тус тусын эрхлэх үйл ажиллагааны хүрээнд уялдуулан зохион байгуулж, идэвх санаачлагатай ажиллахыг уриалж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН ТАЛААРХ
ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ**

Д.Солонго,
Хүний эрхийн үндэсний комиссын дарга

Эрхэм хүндэт нөхдөө,

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан хүний эрхийн үндэсний чуулганыг Монгол Улсын төрийн тэргүүний ивээл дор зохион байгуулдаг уламжлал тогтоод гурав дахь жилтэйгээ золгож байна. Үндэсний чуулганаар хүний эрх, эрх чөлөөний тулгамдсан асуудлыг нийгмийн олон талт төлөөлөлтэйгөөр хэлэлцэж, зөвлөмж гаргадаг билээ. “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” сэдвээр зохион байгуулагдсан өмнөх чуулганы зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагууд тодорхой арга хэмжээ авч, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд чухал хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэн хэлэхэд сайхан байна.

Энэ удаагийн чуулганд хохирогчийн эрхийн баталгааны талаархи асуудлыг хэлэлцэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс зөвшилцөн шийдвэрлэсэн билээ. Чуулганыг энэ сэдвээр зохион байгуулах хэд хэдэн шалтгаан байсан юм. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэж, түүнээс гарах хохирол нь улам бүр ноцтой болж, нэг гэмт үйлдлийн хохирогчдын тоо хэдэн мянгаар тоологдох боллоо. Гэтэл хохирлыг арилгах асуудал зөвхөн эд хөрөнгийн хохирлыг төлүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байгаагийн зэрэгцээ ийм хохирлын тун бага хувь нь нөхөн төлөгдөж байна. Гэм буруутай этгээд учруулсан хохирлоо бүрэн дүүрэн төлөх сонирхлыг бий болгоход чиглэгдсэн зохицуулалт үгүйлэгдэж байна. Хүний эрхийн үндэсний комиссоос эрүү шүүлтийг хориглох чиглэлээр ажиллах явцад хуулийн байгууллагын ажилтнууд, иргэдийн зүгээс сөргүүлэн тавьдаг гол асуудал бол хохирогчийн эрхийн хамгаалалт юм. Энэ нь ч зүй ёсны асуудал гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Эдгээр шалтгаан, нөхцлүүд нь хохирогчийн эрхийг хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх эрхийн асуудлыг үндэсний хэмжээнд хэлэлцэж, нэгдсэн шийдвэр гаргах шаардлагыг бий болгож байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “иргэн нь хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” хэмээн заасан билээ.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг олон улсын хүний эрхийн гэрээ, конвенциор баталгаажуулсан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 6, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэршгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьяаж, шийтгэхийн эсрэг конвенцийн 16, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 39 дүгээр зүйлүүдэд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээдийг эрх зүйн үр нөлөөтэй хамгаалалтаар хангах, зөрчигдсөн эрхээ сэргээн эдлүүлэх нөхцөл бололцоог бий болгох талаар зааж, энэ талаар тодорхой арга хэмжээ авахыг Оролцогч улсуудад үүрэг болгосон байдаг.

Түүнчлэн, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндсэн баримт бичгүүд болох 1907 оны Хуурай газрын дайны үед баримтлах хууль болон заншлын 3 дугаар зүйл, 1949 оны Женевийн Конвенцийн олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед хохирогчдыг хамгаалах тухай 1 дүгээр нэмэлт протоколын 91 дүгээр зүйл, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 68, 75 дугаар зүйлд хохирогчийн эрхийг баталгаажуулсан байна.

Хохирогчийн эрхийг хамгаалах тухай заалт бүс нутгийн хүний эрхийн гэрээ, конвенциудад тусгалаа олсон байна. Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн дүрмийн 7 дугаар зүйл, Хүний эрхийн Америкийн конвенцийн 25 дугаар зүйл, Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 13 дугаар зүйлд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хэн боловч хохирлоо аль болох хурдан шуурхай, хялбар дөт арга замаар нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг.

Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээдийн хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаарх тусгайлсан тунхаглал, зарчим, удирдамжийг НҮБ-аас батлан гаргасан нь эдүгээ олон улсад мөрдөгддөг үндсэн стандарт, хэм хэмжээ болж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай тунхаглал” батлагдсаныг

бид мэдэх билээ. Түүнчлэн, “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн” талаарх НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1990 оны 69 дүгээр тогтоол, “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноштой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-ын тухай мөн Зөвлөлийн 2005 оны 30 дугаар тогтоол, Хүний эрхийн комиссын 2005 оны 35 дугаар тогтоолуудад гэмт хэрэг, эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдөж, хохирсон хүний эрхийг сэргээх талаар арга хэмжээ авахыг НҮБ-ын гишүүн орнуудад уриалж, энэ талаар баримтлах зарчим, удирдамж батлан гаргахыг Ерөнхий Ассамблейгаас хүссэн байдаг. Эдгээр тогтоолын дагуу НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноштой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-ыг 2005 онд батлан гаргасан юм.

Олон улсын хүний эрхийн суурь гэрээ, конвенц болон НҮБ-ын дээр дурдсан тунхаглал, зарчмууд нь хохирогчийн эрхийн үндсэн хоёр асуудалд чиглэгдэж байна.

Юуны өмнө аливаа хохирогчтой хүнлэг ёсоор, эрхэм зэрэг, эрх, эрх чөлөөг нь хүндэтгэн харьцах ёстой бөгөөд төрөөс хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал, бие махбодийн болон оюун санааны сайн сайхан, хувийн амьдралын халдашгүй байдлыг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээ авах үүрэгтэй. Үүний тулд, хохирогч зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө сэргээлгэх ажиллагааны явцад түүнийг дахин “хохироохгүй” байх баталгааг бүрдүүлэх үүднээс тусгай хөнгөлөлт, туслалцаа, дэмжлэг үзүүлэх явдлыг дотоодын хууль тогтоомждоо тусгах ёстой. Харамсалтай нь Монгол Улсад хохирогчийн эрхийг хамгаалах, тэдэнд туслалцаа, дэмжлэг үзүүлэх, эрүүгийн болон захиргааны хэргийг шийдвэрлэх ажиллагааг хохирогчид чирэгдэл, төвөггүй явуулах байдал туйлын хангалтгүй байна. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд хохирогчийн эрх, үүргийг нь тодорхойлсон боловч хохирогчийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны явц, хэмжээ хязгаар, хугацааны талаар мэдээлэл авах, зайлшгүй тохиолдолд хувийн амьдрал, эд хөрөнгө, гэр бүлийн гишүүд, төрөл төрөгсөд, гэрчээ хамгаалуулах, аюулгүй байдлаа хангуулах асуудлууд зохицуулагдаагүй юм. Түүнчлэн, хохирогчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд татан оролцуулахдаа тэдний сэтгэл зүй,

эрүүл мэндийн эмзэг нөхцөл байдлыг харгалзан үзэж, чирэгдэлгүй, нэр төр, эрхэм зэргийг нь хүндэтгэн харьцах хууль зүйн үүргийг эрх бүхий төрийн албан хаагчдад хүлээлгэх нь зүйтэй юм.

Бусад улс орнууд хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хамгаалах, эрх, эрх чөлөө нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай хууль тогтоомж гаргах, Эрүүгийн байцаан шийтгэх хуульдаа бүлэг оруулах зэрэг арга хэмжээ авч байна. Тухайлбал, 2004 онд Оросын Холбооны Улс “Хохирогч, гэрч болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай” Холбооны хуулийг баталж, Казакстан Улс Эрүүгийн байцаан шийтгэх хуульдаа энэ талаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Эдгээр эрх зүйн шинэлэг зохицуулалтад хохирогчид туслах, тэдгээрийг хамгаалах олон чухал арга хэмжээнүүд тусгагдаж, багагүй хөрөнгө зарцуулдаг байна. Хохирогчийг хамгаалах энэ мэт зохицуулалт манай улсын хууль тогтоомжид үгүйлэгдэж байгаа бөгөөд эдгээр материаллаг эрхүүдийг олон улсын эрх зүйн зарчимд нийцүүлэн хуульчлах нь зүйтэй юм.

Хохирогчийн эрхийн олон улсын гэрээ, конвенц, тунхаглал, зарчмуудаар баталгаажуулсан удаах гол асуудал бол хохирлоо нөхөн төлүүлэх эрх юм. Хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хохирогч бүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тэгш, үр дүнтэй боломж эдлэх, хохирлоо хурдан шуурхай, бүрэн дүүрэн, зохистой барагдуулах бололцоогоор хангагдах болон зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга зам, ажиллагааны талаар хангалттай мэдээлэлтэй байх нөхцөл бүрдсэний үндсэн дээр сая хэрэгжих боломжтой.

Хохирогчид зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үр дүнтэй боломжийг бий болгох гэдэг нь захиргаа, шүүх, хуулийн байгууллага хохирогч бүрт хүртээмжтэй, чирэгдэл багатай байхыг хэлж байна. Өөрөөр хэлбэл, хохирсон хэн боловч эрхээ сэргээлгэх, хохирлоо төлүүлэх боломжийг бүрдүүлсэн байх ёстой. Энэ боломж, нөхцөл манай улсад хэрхэн хангагдаж байна вэ? Хохирогч бүрт зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үр дүнтэй боломж олгогдсон эсэхийг хоёр жишээгээр авч үзье.

Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай тунхаглал”, “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-ад “*хохирогч*” гэж “*гэмт хэрэг, эрх мэдлээ хортойгоор ашигласан болон хүний эрх, хүмүүнлэгийн*

эрх зүйг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийн улмаас бие эрхтэн, оюун сэтгэхүйн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, сэтгэл санааны зовлон шаналалд автсан, эд материалын хохирол хүлээсэн, үндсэн эрх, эрх чөлөө нь ноштой зөрчигдсөн хувь хүн, болон хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Харин Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд энэ тодорхойлолтод үндсэн эрх, эрх чөлөө нь ноштой зөрчигдсөн этгээдийг орхигдуулсан байна. Энэ байдал нь хуульд зааснаас бусад хэлбэрээр эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээд эрхээ сэргээлгэж, хохирлоо төлүүлэх боломжийг хязгаарлаж байгаа юм. Олон улсын дээр дурдсан баримт бичгүүдэд зааснаар тухайн хүнийг хохироосон үйлдлийн гэм буруутан нь тогтоогдсон эсэхээс үл хамааран “хохирогч”-ийг тогтооно гэж заасан. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тогтоогдсон, хэрэг илэрсэн эсэхээс үл хамаарч хохирсон этгээд “хохирогч”-оор тооцогдож, төрийн хамгаалалтанд орох, зохих дэмжлэг туслалцаа авах эрх үүсдэг байна. Харин манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зөвхөн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, ял шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш л хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал тавигддаг учраас эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн цаана олон мянган иргэд хохирч, зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө сэргээлгэж чадахгүй үлдэж байна.

Хохирлоо нөхөн төлүүлэх эрх хангагдах дараагийн чухал нөхцөл бол хохирлоо хурдан шуурхай, бүрэн дүүрэн барагдуулах бололцоотой байх явдал билээ. Хохирогчийн хохирлыг ямар хугацаанд барагдуулах эсэхийг тухайн улсын дотоодын хууль тогтоомжоор тодорхойлох хэдий ч энэ хугацаа аль болохуйц богино байх учиртай. Манай улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас харахад шүүхээр шийдвэрлэх хэрэг маргааны хувьд хэргийн шинж байдал, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хянуулах эсэхээс хамаарч, хохирлоо нөхөн төлүүлэх шийдвэр гаргуулах хүртэл ойролцоогоор 2 сар 7 хоногоос 35 сар хүртэлх хугацаа шаардлагатай байгаа юм. Хохирлоо нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан ч энэ шийдвэр биелэгдэх хүртэл дахиад хичнээн хоног, сар болох хийгээд зарим тохиолдолд биелэгдэх эсэх нь ч баталгаагүй байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээгээр 2005 онд төлбөрийн 39.4 хувь нь, 2006 онд төлбөрийн 42.5 хувийг биелүүлсэн гэсэн үзүүлэлт гарчээ. Хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хугацаа

шаардсан ажиллагааны үр дүнд хохирогчид төлөх ёстой төлбөрийн 40 орчим хувь нь төлөгдөж байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм. Хохирол нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэрийн хэрэгжилт ийм байгаа нь шүүхийн шийдвэрийг баталгаажуулах, хоригдлуудын ажлын норм, үнэлгээ, ажлын хөлсний хувиарлалт, зарцуулалттай шууд холбоотой.

Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.5.2 дугаарт “Гэмт этгээдийн учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нөхцлийг бий болгох үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоохын зэрэгцээ тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ”, 2.5.1.4 дүгээрт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажлын ачааллыг оновчтой тогтоох зорилгоор албадын орон тоог хянан үзэж зохицуулах, тэдний ахуй хангамж, урамшууллын хөшүүргийг зохистой тогтооно.” гэж тус тус заасан боловч хэрэгжилт нь удаашралтай байна.

“Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноштой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-ад хохирогчдын хохирлыг хурдан хугацаанд, бүрэн дүүрэн барагдуулах баталгааг бүрдүүлэх үүднээс тусгай хөтөлбөр баталж, хэрэгжүүлэхийг улс орнуудад зөвлөсөн байдаг. Ийм хөтөлбөр нь тодорхой болзол, шалгуурыг хангасан хохирогчийн хохирлыг эхний ээлжинд төрөөс барагдуулж, дараа нь гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тогтолцоог бүрдүүлж, ажиллуулахад чиглэгддэг. Одоогийн байдлаар хохирогчид туслах, хохирол барагдуулах хөтөлбөрийг дэлхийн 35 орон¹ батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт “Зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах зэргээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжинд хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон, цаашид боловсронгуй болгоно” гэсэн чухал заалтыг хэрэгжүүлэх талаар бодитой арга хэмжээ аваагүй байна.

¹ U.S Department of Justice, Office of Justice Program, Office for Victims of Crime “International Crime Compensation Directory” 2005-2006

Хохирлыг бүрэн дүүрэн барагдуулах нь хохирол нөхөн төлүүлэх эрх хангагдах үндсэн нөхцөл мөн. НҮБ-ын зарчмуудад нөхөн төлбөр нь хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйсэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль боловсролын түвшинг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлсэн байх учиртай. Түүнчлэн, хохирогчид олгох нөхөн төлбөр нь бие махбодийн болон сэтгэл санааны хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан боломж, бодит орлого, боломжит орлогыг оролцуулан эд материалын хохирол, зан суртахуунд учирсан хохирол, хууль зүй, эмнэлэг, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээний төлбөр зэргийг бүрэн гүйцэд барагдуулах ёстой болохыг тунхаглал, зарчимд заасан. Харин манай улсын хууль тогтоомжид хохирогчид зөвхөн бодитойгоор учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульчилжээ. Хохирогчид эд хөрөнгө төдийгүй амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа асар их хохирдог ч энэ хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрэлдэн тогтоогүй байгаа нь олон улсын эрх зүйн зарчим, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенциор Монгол Улсын хүлээсэн үүрэгт харшилж байгаа юм. Энэ талаар хоёр жишээ дурдъя.

Гэмт этгээдийн гарт ойр дотны хүнээ алдаж, ямар ч үнээр үл хэмжигдэх хохирол амссан иргэд “хохирогчийн амь нас өчүүхэн төдий үнэлэгдэхгүй байна” гэж бухимддаг. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт “Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй” гэж заажээ. Харин мөн зүйлийн гурав дахь хэсэгт “Гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджаар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдсаны тэтгэмжийг хасна” гэжээ. Иргэний хуулийн энэ зохицуулалтаас хүний амь нас хохироосон тохиолдолд бие эрхтэнд гэмтэл учруулснаас бага хэмжээний төлбөр нөхөн төлөхөөр харагдаж байна. Яаж ч бодсон хүний амь нас хохироосон этгээд илүү хариуцлага хүлээх нь шударга ёсонд нийцэх билээ. Шүүхийн практикт ойр дотны хүнээсээ үүрд хагашсан олон хохирогч амь нас, сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр нэхэмжилдэг боловч хуулиар уг асуудал нэг мөр зохицуулагдаагүй

байгаа нь шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоход хүргэж байна. Энэ байдал нь хүний амь насны үнэлгээг тодорхойлох аргачлал үгүйлэгдэж байгааг харуулж байгаа болов уу.

Бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт ч боловсронгуй бус байна. Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас авч чадаагүй цалин, хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнийг асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх зэрэг бүх зайлшгүй зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй хэмээн хуулиар тогтоожээ. Гэтэл ийм төрлийн гэмт хэргийн хохирогчид эд, эрхтнээсээ салах, биеийн хэвийн үйл ажиллагаа нь алдагдах, гоо сайхандаа засаршгүй гэмтэл авах зэргээр эрүүл мэндийнхээ хувьд ноштой хохирч байхад энэ хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Эд эрхтнээсээ хагацсан хохирогчид зөвхөн авч чадаагүй цалин хөлс, эмчилгээний зардал, хиймэл эрхтэн хийхэд шаардлагатай зардлаа төлүүлж байгаа нь тухайн хүний эрүүл, бүрэн бүтэн байсан эд эрхтний алдагдсан чадварыг нөхөн төлж байгаа хэрэг биш юм.

Хохирогчийн эрхийг хамгаалах баталгааг бий болгох үүднээс юуны өмнө, тэднийг хамгаалах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, учирсан хохирлыг хурдан шуурхай, бүрэн дүүрэн барагдуулах, энэ ажилд зориулагдсан тусгай сан бий болгох, ажиллуулах талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хууль батлах тухай асуудал Засгийн газрын түвшинд яригдаж байсан боловч энэ ажил хангалттай дэмжлэг авч чадахгүй байсаар өнөөг хүрлээ. Хуулийн ийм зохицуулалт байхгүйгээс Засгийн Газар хадгаламж, зээлийн хоршоодын олон мянган хохирогчдын асуудалтай тулгарч, аргагүйн эрхэнд тэдэнд зориулсан нэг удаагийн хууль гаргуулан хэрэгжүүлж байгааг та бид мэднэ. Энэ байдлаас гарах арга замыг яаралтай тодорхойлох шаардлагатай байна.

Дэлхий нийтийг түгшээсэн террорист үйлдэл, алан хядах ажиллагаа Монголчууд биднийг ч тойрч өнгөрөх баталгаа байхгүй. Терроризмтой тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дах хэсэгт “Террорист үйлдлийн хохирлыг арилгах арга хэмжээг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлнэ.” гэж заасан. Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, нийгмийн тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийллийн

хохирлыг Засгийн газрын шийдвэрээр барагдуулах нь учир дутагдалтай юм. Харин дээр дурдсан хохирол барагдуулах сангийн талаарх эрх зүйн зохицуулалтанд энэ асуудлыг тусгайлан авч үзэх нь зохистой гэж үзэж байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, ялах, ял эдлүүлэх төрийн чиг үүргийг биелүүлэх үүднээс зарим төрийн албан хаагчид Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх явцад төрийн албан хаагчийн хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас гэм зэмгүй иргэд гэмт хэрэгт сэжиглэгдэж, цагдан хоригдож, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаа, эрх, эрх чөлөөгөөрөө хохирч байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн хохирогчдын эрхийг хамгаалах нь энэхүү Чуулганаар хэлэлцэж, зөвлөмждөө тусгах ёстой бас нэгэн чухал асуудал гэж бодож байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан байдаг. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйлд “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн нөхөн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй” хэмээн заасан. Монгол Улс дээрх хоёр олон улсын гэрээнд оролцогчийнхоо хувьд төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх боломж, нөхцлийг бий болгох үүрэгтэй.

Үндэслэлгүйгээр цагдан хоригдож хохирсон хүмүүсийн ихэнх нь гомдол гаргахгүй, дуугүй өнгөрч байна. Тэдгээр хүмүүс ямар нэг хохирол, гомдолгүйдээ төлбөр нэхэмжлээгүй хэрэг биш ээ. Тэд арга замаа мэдэхгүйдээ, төрийн байгууллагын төвөгтэй, удаашралтай ажиллагаанаас залхсандаа, дахин ийм байдалд орохоос айсандаа хохирлоо нөхөн төлүүлэх асуудлыг тавихгүй байгаа юм. Хилс хэрэгт сэжиглэгдэн, цагдан хоригдох нь тухайн хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгө, эрх чөлөө, ажиллаж хөдөлмөрлөх, сурч

боловсрох боломжид төдийгүй хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн нэр төрд хохирол учруулж, хүнд дарамтанд орох нөхцлийг бүрдүүлдэг юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, ял шийтгүүлсэн, албан тушаалаасаа түдгэлзүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан иргэнд учирсан хохирлыг арилгах тухай тусгай зохицуулалт бий боловч энэ нь хохирогчийн эрхийг сэргээн эдлүүлэхтэй холбогдсон бүх асуудлыг бүрэн дүүрэн зохицуулж чадахгүй байна. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас хохирсон хохирогч авч чадаагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, хураасан, улсын орлого болгосон эд хөрөнгө, төлсөн торгууль, шүүхийн зардал, өмгөөлөгчийн хөлс зэрэг зөвхөн эд хөрөнгийн хохирлоо л гаргуулахаар зааж, эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмаар нөхөн төлүүлнэ гэжээ. Харин Иргэний хуульд асуудлыг нарийвчлан зохицуулах зохицуулалт үгүйлэгдэж байна. Зарим улс оронд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон хохирогчийн эд хөрөнгийн хохирлыг нь нөхөн төлөхийн зэрэгцээгээр хууль бусаар хоригдсон, ял эдэлсэн хоног тутамд нь тодорхой хэмжээний мөнгөн төлбөр олгож, сэтгэл санааных нь хохирлыг барагдуулдаг туршлага байна. Ийм эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь хохирогчийн эрхийг хамгаалах асуудалд зарчмын дэвшил болоод зогсохгүй ийм төрлийн хэргийг шийдвэрлэх шүүхийн ажиллагааг хөнгөвчилж, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны алдаа дутагдлыг багасгаж, хариуцлагыг дээшлүүлэхэд нөлөөлнө.

Түүнчлэн, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон хохирогчийн эрхийг хамгаалах асуудал хуулийн байгууллагын ажилтнуудын ёс зүй, зан харьцаатай шууд холбоотой. Гэм буруугүй иргэнийг хууль бусаар цагдан хорьж, эрхийг нь зөрчсөн бол хохирлоо нэхэмжлэх эрхийг нь тайлбарлаж, ойлгуулдаг, хэргийг хэрэгсэхгүй болгосон, хоригдсон тухай лавлагааг цаг алдалгүй гаргаж өгдөг, адаглаад уучлал гуйдаг байх шаардлагатай байна.

Төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн шийдвэр цөөн тоотой гардаг ч түүнийг биелүүлэх ажиллагаанд хүндрэл, бэрхшээл их гарч байна. Ийм шийдвэрийг биелүүлэхдээ Засгийн газар, холбогдох байгууллагууд маш хойрго ханддагийг хэлмээр байна. Энэ хүндрэл бэрхшээлийг арилгах

үүднээс 2006 онд Улсын дээд шүүх "...Энэ төрлийн хохирлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргуулахаар зааж байх нь зүйтэй" гэж тайлбар гаргасан ч шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна. Жишээлбэл, нэр бүхий 5 хүнийг эрүүдэн шүүж, нэг нь нас барснаас үүдсэн хохирлыг нөхөн төлүүлэх тухай Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн 2006 оны 7 дугаар тогтоол хэрэгжихгүй байсаар нэг жил болж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ч ийм төрлийн шийдвэрийг биелүүлэхэд хүчин мөхөсдөж байгаа юм.

Хохирогч хүүхдийн асуудалд онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай байна. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 39 дүгээр зүйлд "Оролцогч улсууд ... хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээ авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөл хэрэгжих ёстой." гэж заасан. Түүнчлэн, тус Конвенцийн 3 дугаар зүйлд хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна гэж заасан нь төрөөс хүүхдийн талаар баримтлах үндсэн зарчим юм. Харин бодит байдал дээр хохирол барагдуулах ажиллагааны явцад хохирогч хүүхдийн дээд ашиг сонирхол хангагдаж байгаа болон тэднийг нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөл хэрэгжиж чадаж байгаа эсэх нь тодорхой биш байна. Иймд хохирогч хүүхдийн талаар иж бүрэн судалгаа явуулан тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг нээн илрүүлж, улмаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, дадал хэвшлийг засч сайжруулах талаар арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Хохирогчийн эрхийг хангах, хамгаалах олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлж буй практикийг харьцуулан товч илтгэхэд дээрх дүр зураг харагдаж байна. Цаашид хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон асуудлыг иж бүрнээр нь судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, төрийн албан хаагчдын хариуцлага, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх талаар бүгд хамтран хойшуулалшгүй арга хэмжээ авах шаардлага байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан нь иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах төрийн үйл ажиллагааны зарчим билээ. Төр иргэдээ гэмт халдлага, эрх, эрх чөлөө нь зөрчигдөхөөс хамгаалж чадаагүйн хариуцлагыг шударгаар хүлээх нь дээрх зарчимд нийшнэ гэж үзэж байна.

Хүний эрхийн үндэсний чуулганыг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч, нэг сэтгэлээр хамтран ажилласан Ерөнхийлөгчийн тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрт талархал илэрхийлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН
ШАТАНД ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАЖ
БУЙ БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ**

М.Ганболд,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
хошууч генерал, хууль зүйн доктор

Цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримталж, түүний хэрэгжилтийг хангахад анхаарал төвлөрүүлэн ажиллаж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирогчийн эрхийг хангах, эрхийг нь зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдыг иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхэд анхаарч хуулийн өндөр мэдлэг, мэргэшилтэй ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, дагнан мэргэшүүлэх явдалд анхаарч байна.

“Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг цагдаагийн бие бүрэлдэхүүн, түүнчлэн иргэд, олон нийтэд сурталчлах, судлуулах, манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, тунхаглал, холбогдох бусад баримт бичгээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, “Гэмт хэргийн хохирогчийн сэтгэл зүй”, “Хүчин ба бэлгийн харьцаа”, “Хохирогчтой хэрхэн хүндэтгэлтэй харьцах нь” сэдвээр модулийн сургалт явуулж, сургалтын гарын авлага гаргав.

Хохирогчийн эрх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд анхаарч ажиллах санамж бүхий 5 мянган өврийн тэмдэглэлийн дэвтрийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хийлгэн төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах талаар Монголын нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/, Хүчирхийллийн эсрэг төвтэй хамтран Мөрдөн байцаах газар, Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Дорнод аймгийн цагдаагийн газар, хэлтэст хохирогчийн эрхийг хамгаалах кабинетыг, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран Мөрдөн байцаах газар, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Налайх, Багануур дүүрэг, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Дорноговь аймгийн цагдаагийн газар, хэлтэст насанд хүрээгүй хүнээс байцаалт авах өрөөг тус тус байгуулан ашиглаж байна.

2006 оныг Цагдаагийн ерөнхий газар, “Хохирогчийн эрх ашгийг хамгаалах” жил болгон нэгж бүр хохирогчийн эрх ашгийг хамгаалах зөрчигдсөн эрхийг сэргээх талаар тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар жил бүр цагдаагийн байгууллагын хэмжээнд явагдах албаны болон давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулга, төлөвлөгөөг батлан гаргадаг бөгөөд түүнд Монгол Улсын хууль тогтоомжийг сурталчлах, судлуулах, хохирогчийн эрх, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой сэдвийг тогтмол тусгаж, үр дүнг тооцон ажиллаж байна. Эмзэг хохирогч нарыг байцаах байцаан шийтгэх ажиллагааны арга зүй, тактикийн талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын дунд тогтмол сургалт зохион явуулж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгууллага, алба хаагчаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай соёлтой болгоход анхаарч “Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт”-ыг боловсруулан гаргаж, алба хаагчдаар судлуулж, иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор түүнийг ном хэлбэрээр хэвлүүлэн байгууллага алба хаагчдад тараав.

Энэхүү стандартад цагдаагийн алба хаагч хохирогч иргэдтэй харьцах, тэдний санал, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх, хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх зэрэг асуудлыг тусгаж өгсөн. Үйл ажиллагаагаа гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, олон нийтэд нээлттэй байлгах, тэдний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шуурхай хариу өгч байх зорилгоор www.mngpolice.mn цахим хуудсыг ажиллуулж байна. Түүнчлэн, цахим хуудаст байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, холбогдох эрхийн акт, нийтээр дагаж мөрдөх шийдвэр, иргэдийг хүлээн авах өдөр, цагийн хуваарь зэрэг мэдээ, мэдээллийг байршуулан баяжилт хөдөлгөөн хийж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирогчийн сэтгэл зүйг судлах, тэдэнтэй харьцах арга тактикийг эзэмшүүлэх зорилгоор алба хаагчдыг сургалтад хамруулахад анхаарч байна. Цагдаагийн академийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хичээлийн багтаамж, агуулгыг нэмлээ.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны үед хохирогчид Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар олгогдсон эрх, үүргийг тайлбарлах, эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлэх зорилгоор холбогдох хуулийн

зүйл хэсгийн заалт бүхий санамжуудыг хэвлүүлэн байцаан шийтгэх ажиллагааны үед ашиглаж байна.

Хохирсон иргэнд хууль зүйн туслалцаа авах нөхцөл боломжийг бүрдүүлэхийн тулд өмгөөлөх байгууллагатай хамтран ажиллаж, өмгөөлөгчдийн нэр хаяг, утас зэргийг багтаасан лавлагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын өрөөнд байрлуулсан.

Иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлын мөрөөр хохирогчидтой зүй бус харьцсан, тэдэнд хүндрэл чирэгдэл учруулсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бүрт хариуцлага тооцож, шалтгаан нөхцлийн талаар бие бүрэлдэхүүнд байнга танилцуулан гаргасан алдаа дутагдлыг засуулах дахин давтуулахгүй байхад сургалтыг чиглүүлж байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлж, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын үр дүнгийн гэрээг дүгнэхдээ хохирол нөхөн төлүүлсэн, эд хөрөнгө битүүмжлэн хамгаалсан байдлыг шалгуур гол үзүүлэлтүүдийн нэг болгон дүгнэж байна.

Иргэний нэхэмжлэлийг хангахын тулд сэжигтэн яллагдагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, тэдгээрийн нуугдмал эд хөрөнгийг олж тогтоох ажлыг бололцоотой бүхий л тохиолдолд явуулж байна. 2007 оны эхний 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 25.5 тэрбум төгрөгийн хохирол учирсны 11.8 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн нь хохирол нөхөн төлүүлэлт 2006 оны мөн үеэс 2.5 хувиар өссөн байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 525.3 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна. Дээрх хохирлыг зөвхөн материаллаг хэмээн бодоход хохирогчийн нэр, төр, алдар хүнд, санаа сэтгэл, аюулгүйн байдал ямар түвшинд байгаа нь тодорхой юм.

Судалгаанаас харахад хохирогчдын эрх ашгийг хамгаалан хохирсон хохирлыг нөхөн төлүүлж байгаа үзүүлэлтүүд төдийлөн сайнгүй байгаа нь манай одоогийн мөрдөж буй хууль тогтоомж, бидний өнөөгийн ажиллаж буй практик ажиллагаа одоогийн тавигдаж буй шаардлагын хэмжээнд хүрч чадахгүй хоцорч байгааг харуулж байна. Түүнчлэн, мөрдөн байцаалтын явцад иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор сэжигтэн, яллагдагч нарын хувийн эд хөрөнгийг битүүмжлэн хамгаалах шаардлага гарахад тэдгээр нь урьдчилан бодож тооцож өөрийн хөрөнгийг өөр аж ахуйн нэгж, иргэдийн нэр дээр шилжүүлсэн, хөрөнгөө нуусан байдалтай байдаг болсон.

Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас шаардлага тавихад сэжигтэн, яллагдагч тэдний өмгөөлөгч нар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцохгүй, иймээс бид шүүхийн тогтоол гарсны дараа хохирлоо төлнө гэж тайлбар хийдэг байдал гарах болсон байна.

Хохирогчийн эрх ашгийг хамгаалах ажлыг боловсронгуй болгох зорилгоор дараах ажлуудад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

1. Гэмт хэргийн улмаас иргэдэд байнга учирдаг оюун санааны хохирол болох нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлыг төлүүлдэг эрх зүйн үндсийг бүрдүүлж, мөнгөн үнэлгээнд оруулах;

2. Бие эрхтнээр хохирсон иргэний зөвхөн эмчилгээний шууд зардлыг төлөх төдийгөөр хохирол төлсөнд тооцож байгааг өөрчилж, шууд бус хохирлыг тооцож төлүүлдэг болгох;

3. Хохирсон дээрээ хохироод үлддэг тогтолцоог хэвээр хадгалахгүйн тулд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг төр тодорхой хэмжээгээр хариуцаж хохиролгүй болгож байх хэрэгцээ урган гарч байна. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч ялтан нь хохирогчид нөхөн сэргээх, нөхөн төлбөр өгч чадахгүй байгаа, эмнэлгийн даатгалаар эмчлэгдэхээс хэтэрсэн зардал эмчилгээнд нь гарсан зайлшгүй нөхцөлд төрөөс мөнгөн төлбөр, нөхөн олговрыг олгохоор хуульчилбал зохистой гэж үзэж байна. Үүний тулд гэмт хэргийн хор уршгийг нөхөн төлөх үндэсний хэмжээний сан бүрдүүлэх шаардлагатай. Энэ сан нь бүх төрлийн торгууль, торгох болон эд хөрөнгө хураах шийтгэл, ялтны улсад орж буй орлого, байцаан шийтгэх ажиллагааны зардлаас бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирол болон гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, гэмт хэргийн замаар бий болгосон хөрөнгө, ашиг орлогыг хурааж байгааг уг санд төвлөрүүлэх боломжтой юм.

4. Хохирогч болон бусад гэрчүүдийн аюулгүй байдлыг сайтар хамгаалах, хохирогчийн нэр хүнд хаягийг хэвлэл мэдээллээр болон нээлттэй шүүх ажиллагааны үеэр бусдад дэлгэдэг практикийг зогсооход чиглэсэн арга хэмжээ авах хэрэгтэй. Хохирогч гэж хэн бэ гэдгийг илэрхий болгож болох мэдээллийг нууцлах, хохирогч болон гэрчүүдийн хаягийг гэмт хэрэг үйлдэгчид мэдэгдэхгүй байх арга хэмжээг ч илүү тодорхой болгож хуульчлах шаардлагатай гэж үзэж байна. Хохирогч

болон гэрчид цаашдын аюул заналхийлж байна хэмээн үзвэл тэднийг хамгаалах бүхий л шаардлагатай алхамуудыг хуулийн байгууллагын зүгээс хийхэд чиглэгдсэн ажиллагааг бий болгох шаардлагатай байна. Үүний тулд хохирогч, гэрчийг хамгаалах үндэсний хуультай болох шаардлагатай байна.

5. Иргэд байгууллагуудыг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулж, хохирлыг шуурхай төлүүлэх нөхцөл бүрдүүлэх;

6. Хохирогчоос өмгөөллийн хөлсийг өөрсдөө хариуцдагийг болиулж өмгөөллийн хөлсийг төр хариуцах;

7. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд одоогоор зөвхөн иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авдаг эрхийг өргөжүүлж хохирлыг тодорхой нөхцөлд барагдуулж болох заалт хуульд оруулах;

8. Ялтныг ажлаар хангаж, иргэдэд учирсан хохирлыг төлүүлдэг системийг боловсронгуй болгох, зарим тохиолдолд хохирлоо нөхөн төлсөн нь одоогийн хуульд байгаа шиг ял шийтгэлийг хөнгөрүүлнэ гэсэн ерөнхий заалт биш тодорхой хэмжээгээр /жишээ нь: ялын 1/3, 2/3-оор/ ялаас чөлөөлөх;

9. Хохирогч, ялагдагч, ялтан нарын хооронд хохирол арилгах тал дээр эвлэрлийг зуучилдаг оролцогчийг бий болгох заалт Эрүүгийн байцаан шийтгэх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд оруулах;

10. Гэмт хэргийн хохирлыг тогтоож буй одоогийн практикыг өөрчилж аймаг дүүргийн Засаг даргын тамгын газрын үнийн мэргэжилтэн биш мэргэшсэн шинжээч нар тогтоодог болгож өөрчлөх зэрэг асуудлуудыг судалж хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг санал гаргаж байна.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**ГЭМТ ХЭРГИЙН БОЛОН ЗАХИРГААНЫ ХУУЛЬ БУС
АЖИЛЛАГААНААС ИРГЭНД УЧИРСАН ХОХИРЛЫН
НӨХӨН ТӨЛӨЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ**

Д.Батжаргал,
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ерөнхий газрын дарга, хурандаа

Монгол Улсын Ерөнхийлөгчөө, эрхэм ноёд, хатагтай нараа,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт Хүний эрхийн үндэсний чуулган зохион байгуулж буй явдал нь цаг үеэ олсон бөгөөд үүнтэй холбоотой шийдвэрлэж чадаагүй олон асуудлыг шийдвэрлэх чухал хөшүүрэг болно.

Нэг. Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс шүүх эрх мэдлийн байгууллага, төрийн байгууллагуудын тогтолцоог шинэчлэн зохион байгуулахад ач холбогдол бүхий хуулиудыг хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Уг шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүрэг оролшоо улам бүр өсөн нэмэгдсээр байгаа энэ цаг үед бидний хувьд ч гэсэн шийдвэрлэвэл зохих, нэн чухалд тооцогдож буй асуудлын нэг нь гэмт хэргийн болон захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас иргэнд учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаа байдаг.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх², түүний дотор гэмт хэргийн улмаас эрх нь зөрчигдсөн иргэн буюу төлбөр авагчийн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд албадлагын журмаар төлбөр төлөгчийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байна.

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйл


Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөр төлөгчийн эд хөрөнгөд халдах, тэдний эрхийг хязгаарлах ажлыг хуулийн хүрээнд албадлагаар хэрэгжүүлдэг онцлогтой тул түүнтэй холбоотой гарсан өргөдөл, гомдол, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхэд цаг хугацаа, чирэгдэл багагүй гарч, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, шуурхай, энэрэнгүй байх зарчим цөөнгүй тохиолдолд алдагдаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Хохирлыг барагдуулах ажиллагаанд тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж байгаа байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, ажлын ачаалал, алба хаагчдын хөдөлмөрийн хөлс, урамшуулал, хариуцлагыг оновчтой тодорхойлох явдал нь хохирлыг төлүүлэхэд тодорхой хэмжээгээр эерэгээр нөлөөлдөг.


Хоёр. Өнөөдөр хорих ангид нийт 6127 ялан ял эдэлж байгаагаас төлбөртэй 2997 яланд холбогдох хадгаламж зээлийн хоршооны хэргийн хохирлыг тооцогүйгээр үзэхэд 9.7 тэрбум төгрөгийн хохирол байгаагаас 783 яланд холбогдох 1.7 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулаад байна.




Хохирлын хэмжээ
лгүйцэтгэх хуудасны тоол



Ой өсөөдүй ойг ажы
/и °и ä°и ä¿и ñä.ò°ä/





Хорих ангид ял эдэлж байгаа ялтны хувьд удаан хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлдэг бөгөөд тэдгээр нь хувьд ногдох хөрөнгө, орлогогүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалттай биелэгддэггүй. Ялтнаас учруулсан хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хохирлын хэмжээ нь хадгаламж зээлийн хоршооны хэргийн хохирлыг оролцуулан тооцоход **52.8** тэрбум төгрөгөөр өсжээ. Нийт ял шийтгүүлсэн ялтнаас учруулсан хохирлын 54.9 тэрбум төгрөгийн хохирол нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирол эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 93 хувийг залилангийн гэмт хэрэг, 7 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь залилангийн гэмт хэрэг сүүлийн үед ихээр үйлдэгдэх болсонтой шууд холбоотой. Манай Улсад зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн энэ үед эдийн засгийн болон бусад төрлийн хүнд гэмт хэрэг олноор гарч, түүний үр дагавар нь олон хүнийг хамрах боллоо.

Үүний нэг тод жишээ бол Хадгаламж зээлийн хоршоодын эздийн үйлдсэн гэмт хэрэг юм. Олон иргэдийг хохироосон энэ гэмт хэргүүдийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс УИХ-аас Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай нэг удаагийн үйлчлэлтэй хуулийг боловсруулан, баталсан билээ.

Уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор зохих байгууллагад санал оруулснаар Монгол Улсын Засгийн газраас 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 242 дугаар тогтоолоор “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журам”-ыг батлуулж, хэрэгжүүлж эхлээд байна.

Хадгаламж зээлийн хоршооны **8747** хохирогчдод холбогдох хохирлоос тус байгууллагад шүүхийн шийтгэх тогтоолоор 3 шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн бодит хохирол болох: **Монгол Торго, Бизнес Кредит, Оюу Алт**, зэрэг нийт **12** Хадгаламж зээлийн хоршоонд холбогдох **3460** хохирогчдын **32.9** тэрбум \32.895.893.9\ төгрөгийн хохирол барагдуулахтай холбоотой шүүхийн гүйцэтгэх хуудсыг хүлээн авч, хуульд заасан хойшуулшгүй ажиллагааг зохион байгуулан явуулж байна.

Өнөөдрийн байдлаар Хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хохирлын 50 хувийг олгох ажлыг зохион байгуулснаар тус байгууллагын дансанд 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 1.3 тэрбум төгрөгийг байршуулаад байгаа бөгөөд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ байгуулсан **123** хохирогчдод **339.4** сая төгрөгийг тус бүрийн дансанд нь шилжүүлээд байна.

Энэ онд торгох, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтнуудаас бусдад учруулсан хохирол болох 60.5 сая төгрөгийн 52 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 35 гүйцэтгэх баримт бичгийн 30.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулаад байна.

Хорихоос өөр төрлийн ял, түүний дотор торгох ялаар шийтгүүлсэн ялтнаас гаргуулах хохирлыг гүйцэтгэх ажиллагаа хүндрэлтэй байдаг бөгөөд энэ нь торгох ялыг оногдуулж буй эрх зүйн зохицуулалт төвөгтэй, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар заасан торгуулийн хэмжээ өнөөгийн нөхцөл байдалд бүрэн нийцээгүй, зарим нэг төлбөрийн чадваргүй этгээд торгох ял шийтгүүлж байгаатай холбоотой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганыг угтаж, тус байгууллагаас улсын хэмжээнд 14 хоногийн зохистой ажлыг зохион байгууллаа. Уг ажлын хугацаанд гэмт хэргийн улмаас иргэнд учруулсан хохирол болох 103 гүйцэтгэх баримт бичгийн 49.2 сая төгрөгийг, захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирол болох 22 гүйцэтгэх баримт бичгийн 8.8 сая төгрөгийг тус тус барагдууллаа.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогчийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгоогүйгээс гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтад авах ажиллагаа хангалттай хийгддэггүй. Зөвхөн гэмт хэрэг, түүнд холбогдогчийг илрүүлэх чиглэл рүү түлхүү анхаарснаас гэм буруутай этгээд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх, худалдан борлуулах, улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шатанд төлбөр төлөгч хувьд ногдох ямар нэгэн эд хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй болсон байдаг.

Хуульд "...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүнд ногдох эд хөрөнгөөс төлүүлж, үлдэгдэл төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлж байх"³-аар заасан. Гэвч практикт гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад ял эдлэгсдийн ихэнх хувь нь төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие байдаг. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтныг ял эдлэх хугацаанд нь хөдөлмөрт татан оролцуулж, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагааг тухайн хорих ангийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа боловч ихэвчлэн хохирлын хэмжээ их байдгаас шалтгаалан хангалтгүй байдаг тул энэ төрлийн гүйцэтгэлийн ажиллагаанд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тус байгууллага нь уламжлалт үйлдвэрлэлийг сэргээх, шинээр үйлдвэр байгуулах замаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад ял эдэлж байгаа ялтнуудыг барилга, барилгын материалын үйлдвэрлэл, шохой болон боржин чулуу олборлолт, мал аж ахуй, газар тариалан, мод, модон эдлэл, оёдол, уран дархан, бэлэг дурсгалын зүйл урлах гэх мэт ажлуудыг хийлгэх болсноор

-2006 онд 5179-7322 ялтан хорих ял эдэлсний **2250** яланг,

-2007 онд 6127 ялтан хорих ял эдэлж байгаагаас **3597** яланг тус тус дээрх чиглэлээр ажлын байраар хангасны улмаас хохирол барагдуулах ажиллагаанд тодорхой ахиц гарсан боловч хохирлын хэмжээ үлэмж их учир дааштай нөлөөлж чадахгүй байна.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дахь зүйлийн 66.2 дахь заалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ангид ял эдэлж буй ялтнаас гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо төлөөгүй тохиолдолд ялтныг хугацааны өмнө тэнсэн сулгах саналыг шүүхэд оруулахгүй байх⁴ талаарх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан нь өмнөх хуулиудад байгаагүй дэвшилтэй зохицуулалт болсон төдийгүй ялтнаас хохирол барагдуулахад онцгой хөшүүрэг болсон юм.

Уг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ялтнаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал өмнөх онуудаас нэмэгдэж байгаа хэдий боловч хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүссэн гэм хорын төлбөр биелэгдэхгүй удааширч, иргэд хохирсоор байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Хохирогчдод нөхөн төлбөр олгох үүднээс *Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд хуулийн төсөлд төсвөөс гадна “Хохирол барагдуулах сан”* байгуулах, үүнд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа талаар оновчтой саналуудыг тусгасан нь хэрэгжилт шийдлээ олбол ихээхэн ач холбогдолтой зүйл болно.


Гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаанд нөлөөлж буй нөлөөллийг дүгнэж үзвэл:

- Сүүлийн жилүүдэд шунахай, залилангийн шинжтэй гэмт хэргийн гаралт эрс өсч, иргэд өөрсдөө хуулийн мэдлэг, дутамгаас бараг **“сайн дураар”** шахуу гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд орж байна. Энд урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна.
- Гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар бүрэн хангах боломж хомс байна.
- Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны шатанд гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтад авах ажиллагаа төдийлөн хангалттай хийгддэггүй.
- Хууль тогтоомжид хохирогчийн эрх ашгийг хамгаалах, бусдад учруулсан хохирлыг арилгах асуудлыг зарчмын хувьд тунхагласан боловч хэрэгжүүлэх механизмыг тодорхойлон хуульчлаагүй, эрүүгийн ялын бодлогод цээрлүүлэх хандлагыг түлхүү барьжээ.

4 Мөн хуулийн 126.1.1 дэх заалтыг үзнэ үү.

Гурав. 2007 онд захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн захиргааны шүүхийн шийдвэртэй 143 гүйцэтгэх баримт бичгийн 540.0 сая төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 100 гүйцэтгэх баримт бичгийн 207.9 сая төгрөгийг барагдуулаа. Үүнд:

- төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан 501.2 сая төгрөгийн хохирол барагдуулахаас 206.7 төгрөгийг барагдуулсан байна.
- хуулийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан 38.8 сая төгрөгийн хохирол барагдуулахаас 1.2 сая төгрөгийг тус тус барагдуулжээ.



Сүүлийн жилүүдэд захиргааны хэргийн шүүхэд хандах иргэдийн тоо эрс өсч, захиргааны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 55 хувийг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас иргэн, байгууллагад хохирол учруулсан гэж шүүхээс шийдвэрлэсэн байна.

Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэнд учруулсан хохирлыг барагдуулахаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг. Учир нь төлбөр төлөгч нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрөө байдаг. Нөгөө талаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан иргэнийг өмнө эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулахаар мэдэгдлийг холбогдох байгууллагад хүргүүлдэг боловч төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрлийг үндэслэн Төрийн сан дансны хасалт хийхээр журамласнаас төсөвт байгууллагын дансанд хасалт хийх боломжгүй байдалд хүрдэг. Гэтэл төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан захиргааны албан тушаалтан өөрөө байдаг учраас шүүхийн шийдвэрийг эс биелүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулдаг.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д **“ажилтныг үндэслэлгүйгээр халах**,-гүй байхаар заасан заалтыг зөрчихийг хориглосон боловч тухайн захиргааны албан тушаалтан нь ажилд эгүүлэн томилох талаар шүүхийн шийдвэр гарсаар байхад уг шийдвэрийг эс биелүүлэх, аль эсвэл биелүүлэхдээ хойрго ханддаг.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь эрхлэх асуудлынхаа хүрээний улсын төсвийн байгууллагуудын **тайлан болон улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ**” гэж, мөн хуулийн 14.1.3-д “санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, **хохирлыг нөхөн төлөх үүрэг авах**”-ыг төсвийн байгууллага, албан тушаалтанд хориглосон байна. Энэ заалт нь шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр иргэний зөрчигдсөн эрхийг сэргээсэн атал захиргааны байгууллага, албан тушаалтнаас шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх байдлаар иргэний эрхийг дахин зөрчих, хохироох явдал байсаар байна.

Эдгээр нөхцөл байдлыг авч үзвэл: захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нөлөөлж буй дараах нөхцөл байдлууд байна.

Тухайлбал:

- Хуульд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны талаар тусгайлан зохицуулалт байдаггүй;
- Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй буруутай захиргааны албан тушаалтанд хүлээлгэж байгаа хариуцлагын арга, хэмжээ учир дутагдалтай байна.
- Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон иргэн өмнөх ажилдаа эргэн томилогдсон боловч ажилгүй байсан хугацааны цалинг авахад хүндрэлтэй байдаг;
- Төлбөр авагч иргэн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хүссэн хүсэлтийг Шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлдэггүй буюу ирүүлсэн боловч хуульд заасан зохих гэрээг тус байгууллагатай байгуулдаггүй;

Дөрөв. Цаашид гэмт хэргийн болон захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг шуурхай гүйцэтгэхэд зохион байгуулалтын тодорхой ажлуудыг үе шаттайгаар явуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Иймд дараах саналыг байгууллагын түвшинд дэвшүүлж байна.

Үүнд:

Зохион байгуулалтын талаар

- Хорих ангид ял эдэлж байгаа ялтны ажлын байрны асуудлыг зах зээлийн нөхцөлд төрийн бодлоготой уялдуулан, бүрэн цогцоор шийдвэрлэн шинэ түвшинд гаргаж ирэх; (Хорих ангиудад бизнес, стратеги төлөвлөгөө боловсруулан, удирдлага зохион байгуулалт, менежментийн оновчтой хэлбэрийг нэвтрүүлэх)
- Хорих ял эдлэх хугацаанд ялтанд тодорхой төрлийн мэргэжил эзэмшүүлэн холбогдох байгууллагуудтай хамтран ялтны мэргэжлийн үр чадварын зэрэглэлийг тогтоож, хорих ангиас суллагдсаны дараа ажиллах орчинг бүрдүүлж, хохирлоо төлөх боломжоор хангах;
- Гадаад орны хорих байгууллагын эрхлэж буй үйлдвэрлэлийн чиглэл, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг хэрхэн барагдуулж байгааг судалж, боловсон хүчнийг сургах, туршлага солилцох боломжийг нээлттэй болгох;
- Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлын тодорхой хэсгийг төрөөс төлөгдөх нөхцөл боломжийг бий болгох;

- Гэмт хэрэг зөрчилд оногдуулсан торгууль, шийтгэвэр, улсын орлогод оруулахаар хураагдсан эд хөрөнгийг борлуулсны үнэ зэргийг зохих санд төвлөрүүлж, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулахад зарцуулах;

Эрх зүйн орчин боловсронгуй болгох чиглэлээр

- Захиргааны байгууллага, албан тушаалтнаар хууль бус шийдвэр гаргуулахгүй байх, өөр хоорондоо агуулгын хувьд зөрчилдөж байгаа эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх;
- Захиргааны байгууллага, албан тушаалтантай хариуцлага тооцох арга хэмжээг сайжруулах, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Захиргааны хэргийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны тухай бүлгийг нэмж оруулах;
- Захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах тусгай санг байгуулах;
- Захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг улсын төвлөрсөн төсөв хэлэлцэх үед тухайн байгууллагын төсөвт нь бүрэн хэмжээгээр заавал тусган өгч байхаар хуульчлах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд **“гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн”** тохиолдолд ялтанд тодорхой хэмжээний шагналын хоног олгох, ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах саналыг гаргаж байхаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай байна.

Чуулганаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ц.Одончимэг,
Хууль зүйн үндэсний төвийн Криминологийн
судалгааны секторын орлогч эрхлэгч

Энэхүү илтгэлээр НҮБХХ-ийн “ЕТГ-ын институцийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн захиалгаар ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны сектороос явуулсан “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт” судалгаа, түүний нэг хэсэг болох гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгааны зарим үр дүнг Та бүхэнд хүргэхийг зорилоо.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгосон “*...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрх*”-ийг баталгаатай эдлүүлэх зорилгоор ЭБШХ-иар гэмт хэргийн хохирогчид ЭБША-нд оролцох нэлээд эрхийг олгосны дотроос судалгааны дүнд хэрэгжихгүй буюу бүрэн бус хэрэгжиж байна гэж үзсэн эрхийн төлөв байдлыг авч үзье. Үүнд:

1. Хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллагад мэдүүлэх эрх
ЭБШХ-ийн 167; 168 дугаар зүйлүүдэд зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан гэмт хэргийн халдлагад өртөж, хохирсон талаар Цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл гаргах эрхтэй.

Санал асуулгын аргаар авсан судалгаанд оролцогчдын **75.3%** нь гэмт хэргийн улмаас хохирч байсан байх бөгөөд **51.5%** нь гэмт хэргийн улмаас хохирсон тухайгаа Цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байх бөгөөд тэдний **75.8%** нь ийнхүү хохирогчийн эрхийг хангах чиг үүрэг бүхий байгууллагад хандахгүй байгаа шалтгаанаа төвөг, чирэгдэл ихтэй, хүнд сурталтай, Цагдаагийн байгууллагад итгэдэггүй, өмнө нь хандсан ч туслаагүй хэмээн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбон тайлбарласнаас⁵ үзэхэд Цагдаагийн байгууллага гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах, хангах төрийн чиг үүргийг хангалттай биелүүлдэг гэж дүгнэх боломжгүй байна.

⁵ НҮБХХ-ийн “Ерөнхийлөгчийн Тамгын газрын институцийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн захиалгаар ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны сектороос явуулсан “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт” судалгааны тайлан, 2007 он, 10 дахь тал.

2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нэхэмжлэх эрх

ЭБШХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ... иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй.

Судалсан хэргийн 81%-д нь хохирогч хохирлоо нэхэмжилсэн байх ба үүний 5.1% нь иргэний нэхэмжлэлээ бичгээр, бусад нь байцаалтад дурдах, хохирлын баримт бүрдүүлэх хэлбэрээр нэхэмжлэл гаргаснаас үзэхэд хохирол нэхэмжилсэн хохирогчдын 83.1% нь нэхэмжлэлийг ямар хэлбэрээр гаргааа мэдэхгүй байна⁶ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Судалгаанд оролцсон хохирогчид хохирлоо нэхэмжлэх журмын талаархи мэдлэггүй, тэмдэгтийн хураамж төлөх санхүүгийн боломжгүй, юу нэхэмжлэх талаархи мэдлэггүй, хохирол учруулсан этгээд олдохгүй зэрэг байдлаас болж иргэний нэхэмжлэл гаргаагүй гэж тайлбарлаж буйгаас үзэхэд хохирогчийн иргэний нэхэмжлэл гаргах эрх нь хохирогчдын эрх зүйн мэдлэг дутмаг байдалтай холбоотой гэх дүгнэлтэд хүргэж байна.

Хохирогчийн энэхүү эрхийн хэрэгжилт нь ийнхүү хохирогчийн эрх зүйн мэдлэгтэй холбоотой боловч нөгөө талаар байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн үүрэгт хамаардаг.

Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид болон өмгөөлөгчдийн зүгээс хохирогч иргэний нэхэмжлэл гаргахын учир холбогдол, ямар шаардлага бүхий нэхэмжлэлийг байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатанд гаргаж болох, нэхэмжлэлээ ямар хэлбэрээр гаргах, иргэний нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар хүсэлт, гомдол гаргах эрхийн талаар ёс төдий тайлбарладаг, зарим нь эрх, үүрэг тайлбарласан тухай баримтад гарын үсэг зуруулах төдийгөөр энэхүү ажиллагааг явуулж байгаа төдийгүй иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэрээр гаргуулах явдалд ч хайнга, хариуцлагагүй хандаж байгаа нь байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид болон өмгөөлөгчдийн үйл ажиллагааны дутагдал гэж дүгнэхээс аргагүй.

Эдийн хохирол нэхэмжлэх эрх

Судлагдсан хэргээс хохирол нэхэмжилсэн хэргийн 86.7%-д нь хохирогч эдийн хохирол нэхэмжилсэн байна.

⁶ Дээрх судалгааны тайлан, 8 дахь тал.

Эдийн хохирол нэхэмжлэх эрхийг хангаж буй өнөөгийн байдал

- Эд зүйл үнэлэх мэргэшил, мэдлэггүй хүмүүсээс бүрдсэн “Үнэлгээний комисс” болон үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээдүүд үнэлгээ тогтоож буй нь ЭБШХ-д заасан “хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдох, гаргуулах” шаардлагыг зөрчиж байна.
- Үнэлгээ хийх мэргэшсэн тусгай байгууллага, аргачлал байхгүйгээс үнэлгээг харилцан адилгүй байдлаар тогтоож байна. Ялангуяа, экологийн, мөн түүх соёлын дурсгалт зүйл, байгалийн болон амьтны гаралтай ховор, хэрэгцээтэй зүйлс, эрдэнэсийн зүйлсийг үнэлэх байгууллага, аргачлал байхгүй нь БША-нд нэлээд бэрхшээл учруулж байна.
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар эд зүйлийн шинж чанар, хэр хэмжээ /эдэлгээ, элэгдлийн байдал/-г тогтоох ажиллагаа хийдэггүй.
- Хохирогч гэмт хэргийн улмаас амь насаа алдсан тохиолдолд хохирлыг зөвхөн оршуулгын зардлаар тооцож, шашны зан үйлтэй холбогдон гарсан зардал нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх шүүхийн практик нь Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгосон “Шашин шүтэх, эс шүтэх эрх”-ийг зөрчиж буйгаас гадна хохирогч шашны тэрхүү зан үйл хийсний төлөө сэтгэл санааны тайвшрал авах явдлыг харгалзан үзэхгүй байгаа хэрэг юм.
- Монгол Улсын Дээд шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан шууд хохирлыг ЭБША-ны явцад, шууд бус хохирлыг иргэний журмаар жич нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлж байх чиглэл бүхий тайлбар⁷ гаргасан нь хохирогчид нэлээдгүй чирэгдэл учруулж байна.
- Шүүхээс шаардаж буй хохирсныг нотлох баримтыг бүрдүүлэхэд үйлчилгээний байгууллагуудаас “үйлчилгээ үзүүлсний хөлс төлсөн тухай баримт” гаргаж өгөхгүй байгаа явдал хохирогчдод бэрхшээл учруулдаг. Жишээлбэл, өнөөдөр баримтаар үйлчилж буй нэг ч тээврийн үйлчилгээ алга байна.

⁷ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 27 дугаар тогтоолын 5 дахь заалт. /www.Legalinfo.mn/

Эдийн бус хохирол нэхэмжлэх эрх

Судлагдсан хэргээс хохирол нэхэмжилсэн хэргийн 13.3%-д нь эдийн бус хохирол нэхэмжилсэн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол нэхэмжлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй байгаа бөгөөд энэ нь хүний эрхийг хангах асуудал болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй байна.

Эдийн бус хохирол нэхэмжлэх эрхийг хангаж буй өнөөгийн байдал:

- ЭБША-ны явцад эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох ажиллагаа хийгддэггүй.
- Эдийн бус хохирлын талаар онол, практикийн түвшинд тайлбар байхгүйгээс байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн энэ талаарх мэдлэг дутмаг, хохирлын төрөл, хэмжээг тогтоох талаарх мэдлэг, идэвх санаачлага муу, хохирлын эдийн бус хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх байгууллага болон аргачлал байхгүй.
- Хүний амьнас, эд эрхтнийг үнэлэх үнэлгээ байхгүй, бие эрхтэндээ гэмтэл авч, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд эмчилгээ хийлгэсний дараа бодитой гарсан зардлаар хохирлыг тооцдогос санхүүгийн боломж муутай хохирогч улам хохироход хүрдэг.
- Эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх, уг хохирлыг мөнгөөр тооцон үнэлэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй байна.

3. Хүсэлт, гомдол гаргах эрх

ЭБШХ-ийн 42 дугаар зүйлд зааснаар “...өөрийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах талаар арга хэмжээ авахыг хүсэх”, ЭБША-нд төлөөлөгч оролцуулах эрхтэй.

Иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авах хүсэлт гаргах эрх

ХБ, МБ байгууллагаас иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авсан байдлыг авч үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын хэмжээтэй харьцуулахад дунджаар 9.6%, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээтэй харьцуулахад дунджаар 2.9-тэй тэнцэхүйц

хэмжээний хөрөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Харин судалсан хэргийн дөнгөж 1.6%-д нь л иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авсан байна.

Энэхүү тоо нь энэ ажиллагаа ямар түвшинд хийгдэж байгааг, мөн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд хэт анхаарч, хохирол нөхөн төлүүлэх талаар хийх ажиллагаанд төдийлөн анхаарахгүй байгааг харуулж байна.

ЭБШХ-ийн 123 дугаар зүйлд иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шаардлагатай тохиолдолд авч болохоор хуульчилсан нь энэхүү ажиллагааны үзүүлэлтэд ийнхүү нөлөөлдөг байх боломжтой.

Мөн ЭБШХ-д сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оргон зайлах, хэргийн бодит байдалд саад учруулах, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас сэргийлэх зорилгоор “эд хөрөнгө барьцаалах” таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай зохицуулсан атлаа иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах буюу хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх баталгаа болгож эд хөрөнгө барьцаалах тухай зохицуулалт байхгүй байна.

Судалгааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нэхэмжлэлийг иргэний журмаар шийдвэрлүүлэхээр үлдээдэг явдал бараг хэвшил болсон байдал харагдсан бөгөөд энэ нь ихэвчлэн хохирогчийн эрхээ хэрэгжүүлж буй байдалтай холбоотой боловч хохирогчид эрх, үүргийг тайлбарлах байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн үүрэгтэй салшгүй холбоотой болохыг анхаарах шаардлагатай.

Байцаан шийтгэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч оролцуулах эрх

Хохирогч байцаан шийтгэх ажиллагаанд төлөөлөгч оролцуулах эрхтэй боловч хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуульчилж өгөөгүйгээс тодорхой бэрхшээл учирдаг байна. Тухайлбал, гэмт хэргийн улмаас хохирсон этгээд Монгол Улсад байхгүй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөгч оролцуулах тохиолдолд энэхүү төлөөлөгчийг ямар журмаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах тухай хуульчлаагүй учраас хэрэг хэрэгсэхгүй болгогдох, түдгэлзүүлэх зэргээр хохирогчийн эрх хангагдахгүй удааширдаг.

Мөн гэмт хэргийн улмаас хохирол учирсан тохиолдолд иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тогтоох ажиллагаа шаардлагын түвшинд явагдахгүй, мөн тэднийг төлөөлөн “Хэн” байцаан шийтгэх ажиллагаанд оролцох нь тодорхойгүй байна.

Жишээлбэл:

- Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрийг байцаан шийтгэх ажиллагаанд иргэний хариуцагчаар хууль ёсны төлөөлөгчийг нь татан оролцуулах ажиллагаа хуулийн дагуу хийгдэхгүй байна / ЭБШХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.1.1/
- Хуулийн этгээдийн удирдлага үйл ажиллагааныхаа хүрээнд зохих үүргээ биелүүлээгүйн улмаас хохирол учирсан хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар татах тухай хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
- Гэмт хэрэг /алт хууль бусаар улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг гэх мэт/-ийн улмаас төрийн эрх, ашиг сонирхол зөрчигдөн хохирол учирсан тохиолдолд байцаан шийтгэх ажиллагаанд иргэний нэхэмжлэгчээр төрийг төлөөлөн ямар субъект оролцох нь тодорхойгүй байдаг.

4. Хохирол нөхөн төлүүлэх эрх

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч нь өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Хорих ял эдэлж буй ялтны хохирол нөхөн төлүүлэлт

Хорих ял эдэлж буй ялтнуудын хохирол нөхөн төлөлт 2006 онд хамгийн өндөр буюу 22.9%-тай байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм.

Өнөөдөр хорих ял эдэлж буй хоригдлуудын хувьд хугацаанаас өмнө тэнсэн суллагдах тохиолдолд хуульд заасан шаардлагын дагуу хохирлыг нөхөн төлөхөөс бусад тохиолдолд хохирлыг нөхөн төлдөггүй, хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх ажлын байргүйгээс хөдөлмөр эрхлүүлэх боломж муу байдаг, хөдөлмөрийн үнэлгээ нь зах зээлийн үнэлгээнээс бага байдаг, хорих ангийн ачаалал буюу хоригдлын тоо хэвийн буюу байх ёстой хэмжээнээс 50 орчим хувь илүү байгаагаас хоригдлын хөдөлмөр эрхэлсний хөлсийг хоригдлын хэрэгцээний төсөвт зарцуулдаг хохирол нөхөн төлөх боломж байдаггүй гэх шалтгаанаар бусдад учруулсан хохирлоо төлдөггүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ч хохирол нөхөн төлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авдаггүй байна.

Мөн ШШГЕГ-т хоригдлын нэрийн дансны зарцуулалтын судалгаа алга байна.

Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтны хохирол нөхөн төлүүдэлт

Хорихоос өөр төрлийн ял, тэр дундаа торгох ял эдэлж буй этгээдүүдийн хувьд ял болон хохирлын аль алиных нь хэмжээ өндөр байгаа тул ял, хохирлын алийг эхний ээлжид гүйцэтгэх вэ гэдэг асуудал анхаарал татаж байна.

Хорихоос өөр төрлийн ялыг биелүүлэхгүй 1 жилийн хугацаа өнгөрвөл ял эдлүүлж болохгүй гэх Эрүүгийн хуулийн зохицуулалтаас⁸ шалтгаалан шийдвэр гүйцэтгэгч нар ялыг эхлээд гүйцэтгэх бодлого барин ажиллаж буйг буруутгах аргагүй боловч энэ нь нөгөө талаасаа хохирогчийн эрхэд хэрхэн нөлөөлж буйг анхаарах, энэ асуудлыг журамлах цаг болжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах

Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр батлан мөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй “Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах тухай хууль”-ийг эс тооцвол гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах зохицуулалт байхгүй байна. Энэхүү хуулийг батлан гаргасан “Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын эрхийг хангах” асуудалд төр анхаарал хандуулж байгаагийн эхлэл бөгөөд дэвшил гэж үзэж байна.

Монгол Улс Үндсэн хуулийнхаа Арван есдүгээр зүйлийн 1-д заасан **“төр нь хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах”** үүргээ хэрэгжүүлэх үүднээс цаашид гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалах, хохирлыг төрөөс нөхөн барагдуулах бие даасан хууль батлан гаргах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Цаашид авах арга хэмжээ:

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг ханган хамгаалахын тулд дараахь чиглэлийн хүрээнд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

Арга зам: ЭБШХ-д:

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг заавал

⁸ Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д “хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн боловч нэг жил өнгөрсөн бол ялтны үндсэн ба нэмэгдэл ялыг эдлүүлж болохгүй” гэж заасан.

шинжээчийн дүгнэлтээр тогтоож байх;

- Гэмт хэргийн улмаас хохирол учирсан тохиолдолд заавал иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч байхыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгож;
- Иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээнд “хөрөнгө барьцаалах арга хэмжээ авах” асуудал багтах агуулга бүхий зохицуулалт нэмж оруулах.

Иргэний хуульд:

- “Хүний амь нас, эд эрхтнийг үнэлэх”, мөн Гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд бодит хохирлоор бус гарах шаардлагатай хохирлоор тооцон хохирлыг гаргуулах агуулга бүхий зохицуулалт оруулах;
- Хуулийн 511 дүгээр зүйлд “сэтгэл санаа, бие махбодийн хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцон гаргуулах” агуулга бүхий зохицуулалт нэмж оруулах;

ШШГТХ-д:

- 121 дүгээр зүйлийн 121.1-ийн “...шалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж ...” гэснийг тодорхой болгож буюу ямар төрлийн суутгал хамаарахыг нэрлэн зааж хуульчлах замаар өөрчлөх.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тухай бие даасан хууль батлан мөрдөх. Хууль батлан гаргасантай холбогдуулан уг хуульд дараахь агуулгыг тусгах:

- Хохирлын сан бий болгох;
- Хохирлын сангийн санхүүгийн эх үүсвэрийг гэмт хэргийн хохирлын даатгалд иргэдийг хамруулах замаар, мөн торгох, эд хөрөнгө хураах ялын орлого болон бусад захиргааны торгууль, ААХЯ-ыг хөлстэй гүйцэтгэж, хөлсийг санд оруулах замаар, мөн төсвөөс тодорхой хэмжээгээр санхүүжүүлэх гэх мэт аргаар эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг хуульчлах;
- Гадаад улсын хууль тогтоомжид хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулахаар зохицуулсан байдаг боловч тус хуульд хүч хэрэглэсэн гэмт хэргээс өөр төрлийн гэмт хэргийн хохирогчийн хохирлыг нөхөн барагдуулах онцгой шаардлагыг хуульчлах;
- Төрөөс хохирол нөхөн гаргуулах журам, шаардлагыг хуульчлах гэх мэт.

Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх хүрээнд:

1. Иргэдэд гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах.
2. Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх талаарх идэвх, санаачлага, мэдлэг чадвар, хандлагыг сайжруулах.
3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэмжээг тогтоох аргачлал, журам, заавар боловсруулж мөрдүүлэх.
4. Хохирлын хэмжээ, үнэлгээг шинжээч томилон дүгнэлт гаргуулах шаардлагатай холбогдуулан хууль сахиулах байгууллагын төсөв дэх байцаан шийтгэх ажиллагааны зардлын төсвийг тодорхой хувиар нэмэгдүүлэх.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны журмыг боловсронгуй болгох.

Зохион байгуулалтын хүрээнд:

1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын зэрэг, шинж байдлыг иж бүрэн тогтоох шинжилгээний байгууллага бий болгох, энэ чиг үүргийг Шүүхийн шинжилгээний үндэсний төвд хариуцуулах;
2. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх эмчилгээгээр засах гэх мэт замаар арилгах аргыг судалж, нэвтрүүлэх;
3. Иргэний нэхэмжлэлийг хуульд заасан хэлбэр /иргэний нэхэмжлэлийг бичгээр гаргах ИХШХШХ-ийн заалт бий/-ээр гаргуулж хэвшүүлэх, энэ талаар байцаан шийтгэх ажиллагааны үе шат бүрт анхаарч ажиллахыг, мөн иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах ажиллагаа хийсэн байдлыг байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийн ажил дүгнэх үзүүлэлт болгох;
4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг баримтжуулах, нотлох хуулийн шаардлагыг хангах үүднээс үйлчилгээний бүх төрлийн байгууллагуудад баримтаар үйлчлэх шаардлага тавих;
5. ШШГЕГ-т хоригдлын хөдөлмөр эрхэлсний орлогын зарцуулалтыг хуулийн дагуу хийх, мөн энэ талаар тодорхой судалгаатай байхыг даалгах;
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг сайжруулах үүднээс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.

**ЗАХИРГААНЫ ХУУЛЬ БУС
ШИЙДВЭРИЙН УЛМААС
ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

Д.Ганзориг,
Монгол Улсын их сургуулийн багш, докторант

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын институцийн чадавхийг бэхжүүлэх” төслөөс зарласан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулах хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганд зориулсан “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирсон иргэдийн эрхийг нөхөн сэргээх” сэдэвт судалгааг дараах чиглэлүүдээр хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн Захиргааны байгууллага, түүний албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны талаар гарсан Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт;
2. Хууль бусаар халагдсан төрийн захиргааны албан хаагчийг хуучин ажилд нь эгүүлэн томилсон Захиргааны хэргийн шүүхийн болон Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт;
3. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас хохирсон иргэдийн нөхөн төлүүлэлтийн байдал.

Дээр дурдсан судалгааны чиглэл тус бүрийн хүрээнд бие даасан сэдвийн хүрээнд тусгайлан судалгаа хийж, дүгнэлт гаргахыг зорьсон, нөгөөтэйгүүр эдгээр сэдвийн хувьд нийтлэг нийтлэг зүйлд тулгуурлан судалгааны нэгдсэн зорилго тавьсан болно.

Судалгааны үндсэн зорилго

Сүүлийн үед бусдын хууль зөрчсөн үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх өргөн утгаараа хохирогчийн зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээх асуудал нь улс төрчид, эрдэмтэд, судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл, эрх зүйчдийн зүй ёсны анхаарлыг татсаар байна.

Нэг талаас хохирогч буюу зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүх, эрх бүхий байгууллагад хандаж буй иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль

ёсны ашиг сонирхлыг хамгаалах механизм, түүний үйлчлэл, эцсийн дүндээ хохирогчийг ямар нэг байдлаар хохиролгүй болгох, нөгөө талаас хууль бус үйл ажиллагаа явуулсан этгээд хуульд заасны дагуу хариуцлага хүлээж, шударга ёс, хууль дээдлэх ёс, хүний эрх, эрх чөлөөг хангах талаарх Үндсэн хуульд заасан суурь зарчмуудыг хэлбэрэлтгүй мөрдлөг болгоход өнөөгийн эрх зүйн орчин, бодит байдал зэрэгт оршиж буй сөрөг хүчин зүйлсийг тодруулан илрүүлж, цаашид хохирогчийн эрхийг сэргээх баталгаатай механизм бүрдүүлэн тогтооход хэрэгцээ болохуйц дүгнэлт, санал гаргах нь судалгааны үндсэн зорилго⁹ байлаа.

Гэхдээ хохирогчийн эрхийг сэргээх асуудлыг илүү голлож төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан судлахыг зорилоо. Учир нь урьд өмнө хийгдэж байсан судалгаа гол төлөв гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд анхаарлаа хандуулж байсан бөгөөд захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, захиргааны албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудал судалгаанд тэр бүр хамрагдаагүй байсаар иржээ. Иймээс хохирогч гэдгийг тодорхойлох, түүний эрх зүйн байдлыг хэрхэн яаж нөхөн сэргээх, хууль бус үйл ажиллагаа явуулсан төрийн албан байгууллага, албан тушаалтан яаж хариуцлага хүлээх тухай асуудал нь судалгааны амин сүнс байсаар ирсэн бөгөөд энэ үүднээс хохирогчийг дараах байдлаар бүлэглэн үзсэн болно.

1. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирсон хохирогч-иргэн, хохирогч-хуулийн этгээдийн эрхийг нөхөн сэргээх асуудал;
2. Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн улмаас хууль бусаар халагдсан болох нь тогтоогдсон Төрийн захиргааны албан хаагч-иргэний эрхийг нөхөн сэргээх асуудал;
3. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирсон хохирогч-иргэн, хохирогч-хуулийн этгээдийн эрхийг нөхөн сэргээх асуудал.

⁹ Үндсэн хуулийн Нэгдүеэр зүйлийн 2 дахь хэсэг

Нэг. Төрийн захиргааны байгууллага, түүний албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны талаар гарсан захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжилт

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “... эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэж заажээ.

Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй¹⁰ байхаар хуульчилсан байна. Түүнчлэн “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна”¹¹ гэж заасан нь төрийн байгууллага, тэр дундаа тусгайлан хэлбэл төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөхгүй байх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар заасан байна.

Хэрэв иргэн захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдлоо гаргах эрх¹² нь Үндсэн хуулиар олгогджээ.

1990 оноос 2003¹³ он хүртэл захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмыг “БНМАУ-ын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай” хууль¹⁴, БНМАУ-ын иргэний байцаан шийтгэх хууль, 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **нэгэн зэрэг зохицуулж** байсан байна. Эд хөрөнгийн хохирлоос гадна иргэн хүн өөрийн нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл түүнээс ийнхүү гутаагдсанаас

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэг

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

¹² Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг

¹³ Уг хууль 2002.12.26-ны өдрийн хуулиар хүчингүй болсон

¹⁴ www.legalinfo.mn

учирсан гэм хорыг хохирлыг арилгуулахаар шаардах эрхийг 1994 онд шинэчлэн найруулсан Иргэний хуулийн 7 дугаар зүйлд заасан нь дорвитой алхмын нэг мөн байв.¹⁵

“БНМАУ-ын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай” хуульд “Төрийн захиргааны байгууллага, түүний албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа” гэдгийг БНМАУ-ын Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон иргэний эд хөрөнгө, гэр бүл, орон сууц, хөдөлмөрийн болон амин хувийн бусад эрхээ бүрэн эдлэх боломжийг хууль бусаар хязгаарласан буюу алдагдуулсан, түүнчлэн иргэнд ямар нэг үүрэг хууль бусаар оногдуулсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа гэж тодорхойлж, хэрэв захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хууль бус гэж үзвэл зөрчлийг арилгахыг тэдэнд үүрэг болгосон шүүхийн шийдвэр гардаг байжээ.

Төрийн захиргааны байгууллага, шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хоёр хууль 1990 онд гарсан боловч зөвхөн олгогдоогүй цалин хөлсийг л нөхөн гаргуулахаас хэтэрсэнгүй өдий хүрчээ. /2001 он хүртэл/¹⁶

Иймээс Үндсэн хуульд заасны дагуу дагнасан шүүх байгуулах шаардлага, хэрэгцээний үндсэн дээр Төрийн захиргааны байгууллага, түүний албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны талаар гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол, нэхэмжлэлийг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан болон шүүх хянан шийдвэрлэх зохицуулалт бүхий Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдаж, 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Захиргааны үйл ажиллагааг хууль бус гэж үзэж буй иргэн хүн ЗХХШТХ-д зааснаар гомдлоо дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргадаг.¹⁷ Дээд шатны байгууллага, албан тушаалтан гомдлыг хүлээж аваад хангаж эсхүл хангахгүйгээр шийдвэрлэх эрхтэй байна.¹⁸ Гэхдээ хуульд “дээд шатны байгууллагагүй захиргааны байгууллага” гэсэн

¹⁵ Хүний эрхийн төлөв, байдал 2001 он, 10 дахь тал

¹⁶ Хүний эрхийн төлөв, байдал 2001 он, 92 тал

¹⁷ Уг харилцааг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг байна.

¹⁸ ЗХХШТХ-ийн 2 дугаар бүлэгт “урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах” гэж тодорхойлдог

ойлголт шинээр бий болсон бөгөөд энэ тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд шууд нэхэмжлэл гаргаж болно. Үүнээс гадна “урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй тохиолдолд” иргэн шүүхэд шууд хандах боломж бий.

Дээд шатны байгууллага, албан тушаалтан гомдлыг хангаагүй эсхүл огт шийдвэрлээгүй тохиолдолд иргэн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үүснэ.¹⁹ Нэхэмжлэл гаргахдаа зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээлгэхийн тулд тухайн актыг хүчингүй болгуулах, илт хууль бус гэж тооцуулах, үйлдэл хийхийг даалгах агуулга бүхий нэхэмжлэл гаргахын сацуугаар ЗХХШТХ-ийн 32.5.3-т зааснаар “учирсан хохирлоо нөхөн төлүүлэх” нэхэмжлэл гаргаж болдог. Гэвч хохирлын хэмжээний талаар маргаан үүсвэл иргэний шүүхээр шийдвэрлүүлдэг. Захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг үүсгэсний үндсэн дээр ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлд заасан шийдвэрийн аль нэгийг гаргаж болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ”, 78 дугаар зүйлийн 78.1-д “хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй” гэж зааж, шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлэх арга, журмыг “хуулиар шууд биш”, хуульд заасан эрхийнхээ дагуу шүүх “шийдвэртээ” тодорхойлж болохоор²⁰ тусгасан байна.

Хэрэв захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтан сайн дураар биелүүлээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлэхээр хуульд заасан байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа нь ИХШХШТХ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу явуулдаг байна. Тиймээс ч 1994 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль, 1996 он, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудаас үзвэл захиргааны шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагаа иргэний шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

¹⁹ ЗХХШТХ-ийн 12 дугаар зүйл

²⁰ ЗХХШТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.2

ажиллагаатай нэгэн адил зарчмаар явагддаг байжээ. Харин ЗХХШТХ батлагдсанаар Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 11 дүгээр тогтоолд “Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр” гэдэгт эрх зүйн маргаан, **захиргааны хэрэг** болон эрүүгийн хэргийн хохирол, төлбөрийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр... **хамаарах**”-аар зааж өгснөөс өөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрхэн явуулах талаар нарийвчилсан хуулийн зохицуулалт байхгүй байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд ногдуулах албадлагын арга хэмжээг 1992 оны Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “Шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол **500-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна**” гэж заажээ.

Харин Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байх бөгөөд энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэсэн **тайлбартай** байх юм.


Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн шүүх 2004-2006 онуудад нийт 27 хэрэг шийдвэрлэснээс **12** буюу **44.4** хувьд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн байна.

Төв аймгийн Захиргааны хэргийн шүүх 2004-2006 онуудад нийт 27 хэрэг шийдвэрлэснээс **14** буюу **52** хувьд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн хангаж шийдвэрлэсэн байна.

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн материалаас судалгаа хийж үзэхэд 2004 онд 40 хэргээс **22** хэрэг буюу **55** хувийг, 2005 онд 157 хэргээс **88** хэрэг буюу **56** хувийг, 2006 онд 199 хэргээс **111** хэрэг буюу **56** хувийг, 2007 оны эхний хагас жилийн

114 хэргээс **63** хэрэг буюу **55** хувийг нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг болон бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна. Өнгөрсөн хугацаанд Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн дунджаар **55** хувьд нь нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан **284** шийдвэр, үйл ажиллагааг хууль бус гэж дүгнэжээ.

Зураг 1




Эдгээр хууль бус шийдвэр, үйл ажиллагаа нь ямар эрх зүйн харилцаанаас үүдэн гарсныг авч үзвэл:

- Газрын маргаан **66** буюу нийт хэргийн **23** хувийг
- Татварын маргаан **57** буюу нийт хэргийн **20** хувийг
- Төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас халсан маргаан **38** буюу нийт хэргийн **13.3** хувийг
- Ашигт малтмалын лицензийн талаарх маргаан нийт хэргийн **32** буюу **11.2** хувийг тус тус эзэлж байна.

Дээр дурдсан хэрэг маргааны дийлэнх хувь буюу 68 хувийг эзэлж байгаа бөгөөд Засаг дарга, газрын алба, мэргэжлийн хяналтын байгууллага, кадастрын байгууллагаас гаргаж буй шийдвэр /үйл ажиллагаа/-ийг хууль бусад тооцсон байна.²¹

²¹ Дээр дурдсан хэрэг маргааны талаарх дэлгэрэнгүй хавсралтаас үзнэ үү.

Зураг 2



Судалгаанд онцлон авч үзсэн **284** шүүхийн шийдвэрийг удирдлага болгосон заалтаар нь авч үзвэл:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон – **167** буюу 57 хувь, ЗХХШТХ-ийн 70.2.1

2. Захиргааны байгууллага, албан тушаалтан - иргэн, хуулийн этгээдийн хооронд эрх зүйн харилцаа байгаа гэж үзсэн - **4** буюу 1.4 хувь, ЗХХШТХ-ийн 70.2.2

3. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн – **21** буюу 7.4 хувь, ЗХХШТХ-ийн 70.2.3


4. Захиргааны байгууллага, албан тушаалтныг захиргааны шийдвэр гаргахыг даалгасан – **13** буюу 4.6 хувь, ЗХХШТХ-ийн 70.2.4

5. Татварын улсын байцаагчийн актын төлбөрийн хэмжээг багасгасан – **22** буюу 7.7 хувь ЗХХШТХ-ийн 70.2.6

6. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлсэн – **9** буюу 3.2 хувь, ЗХХШТХ-ийн 70.2.7

7. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь иргэн, хуулийн этгээдийн гаргасан шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эвлэрсэн – **48** буюу 17 хувийг тус тус эзэлж байна. ЗХХШТХ-ийн 42, 43

Зураг 3



Хөдөө орон нутагт захиргааны хэрэг багаар шийдвэрлэгддэг, шийдвэрлэгдсэн цөөхөн хэрэгт нэхэмжлэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар тэр бүр шүүхэд ханддаггүй тул ихэнх хэрэг нь биелэгдсэн гэж үздэг байна. Тухайлбал, Төв аймгийн 1 хэргийн шийдвэрийг албадан биелүүлэхээр Аймгийн шийдвэр гүйцэтгэх албанд хандсан байхад Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхээр нэхэмжлэгч нараас шүүхэд хүсэлт гаргаагүй байна.²²

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг нийт хангаж шийдвэрлэсэн **284** хэргээс 70 хувийг буюу 2004 оны 15 хэрэг, 2005 оны 60 хэрэг, 2006 оны 82 хэрэг, 2007 оны 46 хэрэг, нийт **203** хэргийг түүвэрлэн авч судалснаас **76** хувь буюу **155** шүүхийн шийдвэр биелсэн, **24** хувь буюу **48** шүүхийн шийдвэр биелээгүй байна.²³

Шүүхийн шийдвэр биелэгдсэн	155 буюу 76 хувь
Шүүхийн шийдвэр биелэгдээгүй	48 буюу 24 хувь

Судалгаанд хамрагдсан хохирогч иргэд шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа шалтгааныг:

²² Төв аймгийн шүүх, Дархан-Уул аймгийн шүүхээс авсан судалгаа

²³ 2004-2007 онуудад НЗХШ-ээс нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хэргийн оролцогчтой ярилцсан ярилцлага болон НШГА-ны шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэргийн материалд тулуурлав.

1. Захиргааны албан тушаалтанд хариуцлага тооцох механизм сул байгаагаас шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлдэггүй
2. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын идэвхгүй үйлдэл гэж дүгнэж байв.²⁴

Захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэхгүй, иргэнийг хохироосон үйлдэл үргэлжлэх тохиолдолд ИХШХШТХ-ийн 185-д зааснаар иргэн шүүхэд хандан “албадан биелүүлэх захирамж гаргуулах эсхүл гүйцэтгэх хуудас олгуулах”-аар хүсэлт гаргах эрхтэй байдаг. Үүний үндсэн дээр Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгч нараас шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр 2004 онд 1 хүсэлт, 2005 онд 18 хүсэлт, 2006 онд 15 хүсэлт, 2007 онд 11 хүсэлт, нийт 45 хүсэлт гаргажээ.

Уг хүсэлтийн дагуу шүүхээс гүйцэтгэх хуудас, албадан гүйцэтгэх захирамж гарган Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлсэн байна.

Эдгээр 45 хүсэлт биелэгдсэн эсэхийг шийдвэр гүйцэтгэлийн материалаас судалж үзэхэд:

1. шийдвэр гүйцэтгэх байгууллагатай зардал, урамшууллын гэрээ байгуулаагүй шалтгаанаар 6 шийдвэрт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаагүй,
2. шүүхийн шийдвэр биелсэн -20,
3. шийдвэр биелээгүй байна-19 байна.

НШГА хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг явуулж, хохирогчийн эрхийг нөхөн сэргээх талаар арга хэмжээ авдаг боловч дээр дурдсан тоон үзүүлэлт болон судалгааны бусад үр дүнгээс үзэхэд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа байдал нилээд өргөн хүрээтэй байгаа нь ажиглагдаж байна

Шүүхийн шийдвэр биелээгүй шийдвэр гүйцэтгэлийн материалд шийдвэр гүйцэтгэгчээс: Захиргааны албан тушаалтанд шийдвэр гаргахыг мэдэгдсэн албан бичгийг удаа дараа явуулж, олон удаа тухайн албан тушаалтантай болон хуулийн зөвлөхтэй уулзаж шүүхийн шийдвэрийг хэзээ биелүүлэхийг **асуухаас** өөрөөр ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Харин шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа нэг Засаг даргад арга хэмжээ авахуулахаар шүүхэд хандсанаас өөрөөр захиргааны болон эрүүгийн хариуцлага оногдуулахаар Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас холбогдох байгууллагад хүсэлт тавиагүй байна.

²⁴ Хохирогч нартай ярилцсан ярилцлагын тэмдэглэл

Шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа шалтгаан, түүнчлэн шийдвэрийг биелүүлэх явцад учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоох зорилгоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч нартай ярилцлагын аргаар шүүхийн шийдвэр биелэгдээгүй шалтгааныг тодруулж ярилцлага хийсэн бөгөөд дараах хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Үүнд:

1. Шийдвэр биелүүлэгч нь Захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг учир шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг тоодоггүй, үл хэрэгсдэг.
2. Шүүхийн шийдвэр ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаар гардаг.
3. Ажлаас үндэслэлгүй халагдсан төрийн албан хаагчид цалин гаргуулахаар Төрийн санд хандахад төсвийн ерөнхийлөн захирагчаас бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн цалинг олгоно гэдэг. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн албан хаагчийг халсан захиргааны албан тушаалтан байдаг.
4. Захиргааны шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх нарийвчилсан тусгай хуулийн зохицуулалт байхгүй байдгаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулсан шийдвэр гүйцэтгэгч буруутгагддаг.
5. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийг ажилд нь оруулах гэтэл өөр хүн тухайн албан тушаалд ажиллаж байдаг.

Захиргааны хэргийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх онцлогтой холбоотойгоор шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт хуульд байхгүйгээс шийдвэр гүйцэтгэгч нар шийдвэр биелүүлэх ажиллагаа хэрхэн явуулах талаар нэгдсэн ойлголтгүй, түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн захиргааны байгууллага учраас хариуцагч байгууллагад шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар шаардлага тавьсан ч биелүүлэхгүй байх тохиолдол элбэг байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны дэд сэдвийн хүрээнд тавигдсан зорилго зорилтыг дараах үндсэн дүгнэлтийг хийх боломжтой гэж үзэж байна.

1. Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас хохирсон иргэд өөрийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, хохирлоо нөхөн төлүүлэхээр хандаж болох шүүхийн бие даасан тогтолцоо төлөвшиж байна гэж дүгнэж болно. Захиргааны хэргийн шүүхэд шийдэж буй хэргийн тоо нийслэл, орон нутгаар авч үзвэл харьцангуй хол зөрүүтэй байгаа боловч ерөнхий хандлага ихсэх чиглэл рүү байгаа нь судалгаагаар тогтоогдлоо. Харин дээд шатны байгууллага, албан тушаалтан гомдлыг хэлэлцэх буюу “урьдчилан шийдвэрлэх ажиллагаа” явуулах нэрийдлээр цаг хугацаа “уях” хохирсон иргэдийг чирэгдүүлэх байдал нилээд байгааг цаашид өөрчилж захиргааны үйл ажиллагааны тухай хуулиар хугацааг аль болох богино болгох зохицуулалт хийх бүрэн боломжтой юм.
2. Захиргааны хэргийн шүүх иргэдийн нэхэмжлэлийг хангасан тохиолдолд гаргаж буй шийдвэрээ тодорхой болгох, ялангуяа “илт хууль бус гэж тооцох”, “даалгах” шийдвэр гаргахдаа тухайн шийдвэр нь хэрэгжих боломжтой байдлаар тооцож, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийг өргөнөөр хэрэглэх шаардлага байгаа нь судалгаагаар тогтоогдлоо. Шүүхийн шийдвэр ойлгомжтой олон утга санаа агуулаагүй байж, хэрэгжих магадлалтай болно. Мөн шүүхийн шийдвэрт учирсан хохирлыг хэрхэн төлүүлж байх механизмыг тусгах нь хохирогч-иргэн дахин дахин шүүхээр шийдвэрлүүлэхгүй байхад тус дөхөмтэй. Үүнийг үндэслэн захиргааны хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлын асуудлыг хэрэв нэхэмжлэгч хүсвэл хамтад нь шийдвэрлэж байх нь зүйтэй юм.
3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа төлөвлөөгүй, түүнд шийдвэрлэвэл зохих асуудал багагүй байна. Тухайлбал Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй адилтгаж болох боловч түүний онцлогийг харгалзсан эрх зүйн зохицуулалт шаардагдаж байна. Үүнд: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд төлбөр авагч, төлбөр төлөгч гэсэн субъект тэр бүр байхгүйг

бодолцох, хугацаатай (жишээлбэл 30 хоног) гэх мэт зохицуулалт хийж болно.

4. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр зарим тохиолдолд “хийх хоосон шийдвэр” болж болзошгүй байдал ажиглагдлаа. Ялангуяа төрийн захиргааны дээд, төв байгууллагатай шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа багагүй хүндрэлтэй явагдаж байна. Тиймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтолцооны асуудлыг дахин нягталж болж өгвөл захиргааны байгууллагаас хамаарал багатай тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болжээ.
5. Захиргааны хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал дөнгөж эхлэлийн төдий байна. Үүнд: нэг талаас иргэн хохирлоо нөхөн төлүүлэх талаар тэр бүр ханддаггүй байдал зохих ёсоор нөлөөлж байгаа боловч нөгөөтэйгүүр хууль бус шийдвэр гаргасан захиргааны албан тушаалтан хариуцлага хүлээх механизм байгаа нь ийм дүгнэлт хийх үндсэн шалтгаан болж байна. Үүнээс гадна захиргааны албан тушаалтан шүүхийн шийдвэрийг эс биелүүлсэн тохиолдолд 500-10000 төгрөгөөр торгож буй нь яавч үр нөлөөтэй зүйл биш бөгөөд захиргааны шийтгэлийн хэмжээг ихэсгэх шаардлагатай юм.

Хоёр. Хууль бусаар халагдсан төрийн албан хаагчийг хуучин ажил нь эгүүлэн томилсон Захиргааны хэргийн шүүхийн болон Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, учирсан хохирлын нөхөн төлүүлэлт

“Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ”²⁵ гэж Монгол Улсын ТАТХ-ийн 3 дугаар зүйлд тодорхойлжээ. Үндсэн хуульд төрийн жинхэнэ албан хаагч нь гагцхүү ард түмнийхээ тусын тулд хувийн ашиг сонирхлоо умартан ажиллах талаар заасан байдаг. Нэгэнт төрийн албан хаагч нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллаж буй албан хаагч учраас түүний ажиллах нөхцөл, баталгааг төрөөс хангах үүргийг ТАТХ-д хуульчилсан билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд улс төрийн сонгуулийн дараа төрийн мэргэшсэн аппарат их хэмжээгээ “эвдэрч”, төрийн албан хаагч нар нь улс төрийн албан тушаал эрхэлдэг хүмүүсийн шийдвэрээр хууль бусаар халагдах болсон нь бүх төрлийн судалгаагаар нотлогдож байгаа бөгөөд ийм байдал нь эцсийн дүндээ төрд болон тухайн хүнд хохирол учруулсаар байгаа

²⁵ Төрийн мэдээлэл. Сэтгүүл. УБ., 2002 он. №28

билээ. Иймээс уг асуудлыг нарийвчлан судалж, төрийн албанаас хууль бусаар халагдсан болох нь тогтоогдсон иргэдийн эрхийг хэрхэн яаж нөхөн сэргээж буй асуудал нь судалгааны бас нэг чиглэл байв. Түүнээс гадна, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангахад голлох чиг үүрэг бүхий Төрийн албаны зөвлөлийн үүрэг, гарсан шийдвэрийн биелэлтийн асуудал нь зүй ёсоор анхаарал татав.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”²⁶-т заасан “Хүний эрхийг хангах” тухай 2 дугаар бүлгийн 2.2.2.1-д “Төрийн захиргааны болон тусгай алба хаших нөхцөл болзол нь нийт иргэний хувьд адил тэгш байх үндсэн дээр төрийн албанд иргэдийг шалгаруулж авах, мэргэшүүлэн ажиллахдаа намчирхах, нутгархах, танил талаар дэмжих, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлах, авилгалд автах зэрэг хууль бус үйлдэлд өртөхгүй, тийм хандлага гаргахгүй байх баталгааг буй болгоно”. Мөн хөтөлбөрийн 2.2.2.4-д ТАЗ-ийг хараат бусаар ажиллуулж, төрийн албанд томилох, дэвшүүлэх, бууруулах, шилжүүлэх, халахад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг арилгаж, уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна²⁷ хэмээн тодорхойлсон байна.

Судалгааныхаа зорилго, зорилтыг хангахтай уялдуулан Монгол Улсын ТАТХ-ийн 17, 19, 23, 26, 39 дүгээр зүйлүүд буюу ТЖАХ-ийн эрх зөрчигдсөн тухай маргааны талаарх заалтыг Монгол Улсын Төрийн албаны анхны болон шинэчлэн найруулсан хуулийн хүрээнд харьцуулан авч үзсэн юм.

ТАТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1-д ТАЗ-ийн бүрэн эрхийг тодорхойлон тогтоосон бөгөөд үүний хүрээнд 35 дугаар зүйлийн 35.1.2-д “Энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх”²⁸ гэж заажээ. Түүнээс гадна ТАЗ төрийн албатай холбоотой маргааныг шийдвэрлэх талаар “ТАЗ-ийн дүрэм” /Улсын Их хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан/-ийн 2.17-д заасан “Төрийн албан хаагчаас салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн маргааныг хянан шийдвэрлэх” чиг үүрэгтэй байхаар заажээ.

²⁶ Монгол Улсад Хүний эрхийг хангах хөтөлбөр. УБ., 2003 он. 22 дахь тал

²⁷ Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. УБ., 2003 он. 22 дахь тал.

²⁸ ТАТХ-ийн 39.1. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан дараах маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ:

39.1.1. Энэ хуулийн 17.2, 19.2, 23, 25, 26 дугаар зүйлүүдэд заасан асуудлаар төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн өөрийнх нь гаргасан маргаан

39.1.2. төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

Төрийн байгууллагын удирдлага тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчийг халах хоёр янзын үндэслэл байна. Тухайлбал, ТАТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д зааснаар “Хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ биелүүлээгүй” бол ТЖАХ-ийг төрийн албанаас халахаар заасан бол уг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3-д “26.1-д заасан сахилгын зөрчил гаргасан бол Төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” шийтгэл оногдуулахаар заажээ. **Эндээс үзэхэд:** төрийн албанаас халах, 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл, хугацаа зэрэг нь өөр өөр байдлаар зохицуулагджээ.

ТЖАХ нь Төрийн албаны шийдвэрийг эс зөвшөөрвөл ямар процедурын дагуу гомдол гаргах харилцааг уг хуулийн 26 дугаар зүйлийн 26.8, 39 дүгээр зүйлийн 39.4²⁹ гэсэн заалтуудаар зохицуулагджээ. Эдгээр заалтуудад гомдол гаргагч иргэн ТАЗ /салбар зөвлөл/ эсхүл шүүхэд хандахаар заасан байна. ТАЗ-д төрийн албатай холбоотой маргааныг шийдвэрлэх журмыг Улсын Их хурал /ТАТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.3/ болон Засгийн газар /ТАТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.9/-д заасны дагуу тогтоожээ³⁰.

ТАЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт

Хууль бусаар халагдсан гэж үзсэн төрийн албан хаагч ТАЗ-д 2004 онд 26 хэрэг, 2005 онд 133 хэрэг, 2006 онд 85 хэргийг шийдвэрлүүлэхээр хандсан бөгөөд дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Нийт гомдлын 59 хувь буюу 143-г хэргийг салбар зөвлөл рүү шилжүүлсэн, 20 хувь буюу 50 хэргийг гомдол гаргагчийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн, 8 хувь буюу 20 хэргийн хувьд гомдол гаргагчийн шаардлагыг хангаж шийдвэрлээгүй³¹, бусад 13 хувь нь бусад харьяалагдах байгууллага руу шилжүүлсэн, харьяаллын бус тул буцаасан, гомдол гаргагч гомдлын шаардлагаасаа татгалзсан байна. /Зураг N01/

²⁹ ТАТХ-ийн 26.8. Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

ТАТХ-ийн 39.4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэж үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор, уг шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана.

³⁰ ТАТХ-ийн 26.9. Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журмыг Засгийн газар тогтооно.

ТАТХ-ийн 39.3. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг Улсын Их Хурал тогтооно.

³¹ Төрийн албаны зөвлөлийн нийт шийдвэрлэсэн хэргийн 83 хувь буюу 50 хэргийн гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн, 17 хувь буюу 20 хэргийн гомдлын шаардлагыг хангаагүй байна. Судалгааны тайлан.

Δ/Δ	Гомдол	Тоо /тус бүр/	Хувь
	ТАЗ-д хандаж гаргасан гомдол	244	100%
	Салбар зөвлөл рүү шилжүүлсэн	143	59%
	Гомдол гаргагчийн шаардлагыг хангасан	50	20%
	Гомдол гаргагчийн шаардлагыг хангаагүй	20	8%
	Бусад	31	13%

Эдгээр тоон үзүүлэлтээс ТАЗ-ийн нийт шийдвэрлэсэн 70 хэргийн³² 71 хувь буюу 50 хэргийн гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэсэн, 19 хувь буюу 20 хэргийн гомдлын шаардлагыг хангаагүй байгаа нь ТЖАХ-ийг ажлаас үндэслэлгүй халж, эрх ашгийг нь зөрчих явдал түгээмэл байгааг харуулж байна.

ТАЗ-ын гомдлыг хангаж шийдвэрлэсэн 50 хэргийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар 15 гомдол гаргагчтай ярилцаж, дараах нийтлэг асуултуудыг тавьсан болно.

ТАЗ-ийн шийдвэр биелсэн эсэх талаар асуултад нийт ярилцлагад хамрагдагсдын 33.3 хувь нь ТАЗ-ийн шийдвэр биелсэн, 66.6 хувь нь ТАЗ-ийн шийдвэр биелээгүй гэж хариулсан байна.

/ Зураг №2/



ТАЗ-ийн шийдвэр биелээгүй гэж хариулсан нийт 66.6 хувь буюу 10 хэргийн оролцогчдоос ТАЗ-ийн шийдвэр биелэхгүй байгаа нь дараах шалтгаантай гэж хариулсан байна.

³² 70 хэрэг гэдэгт ТАЗ-ийн шийдвэрлэсэн /хангаж эсхүл хангаагүй шийдвэрлэсэн/ хэрэг орсон болно.

ТАЗ-ийн үйл ажиллагаа:

- ТАЗ хугацаандаа асуудлыг шийдвэрлэж чаддаггүй, удаан хугацаанд чирэгдүүлсэн, хариуцагч байгууллагыг ирүүлж чаддаггүй;
- ТАЗ төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг хангах, тэдний эрхийг хамгаалах байгууллага байж чадахгүй байна;
- ТАЗ шийдвэрийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, биелүүлээгүйн төлөө хариуцлага тооцох механизм байдаггүй;

Төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаа:

- Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлоо төрийн ашиг сонирхлоос давуу үздэг;
- Төрийн байгууллага, албан тушаалтан нь ТАЗ-ийн шийдвэрийг үл ойшоож, шийдвэрийг биелүүлдэггүй;

Бусад:

- Төрийн албан тушаалыг нэг тал нь худалддаг, нөгөө талаас худалдаж авчихдаг учраас шүүхийн шийдвэр гарсан ч биелүүлдэггүй;
- Төрийн алба улс төрийн намаас харьяалалтай байгаа учир албан тушаалтанд нөлөөлдөг.

Түүнчлэн, судалгаанд хамрагдагсад ТАЗ-ийн шийдвэр биелэхгүй гол шалтгаан нь ТАЗ-ийн шийдвэрийг ТЗБ, албан тушаалтан биелүүлдэггүй, шийдвэр хэрэгжилтэд хяналт тавих, биелүүлээгүйн төлөө хариуцлага тооцох механизм байхгүй байгаатай холбоотой гэж судалгаанд хамрагдагсдын 85 хувь нь хариулсан байна. /Хавсралт-2/

Ярилцлагад хамрагдсан /ТАЗ-д гомдол гаргасны дагуу гомдлын шаардлагыг хангасан/ 3 гомдол гаргагч тутмын зөвхөн нэг нь ТАЗ-ийн шийдвэрийн дагуу хуучин ажилдаа эгүүлэн томилогдсон бөгөөд үлдсэн 2 гомдол гаргагчдын хувьд шийдвэр нь хэрэгждэггүй, хохирлоо нөхөн төлүүлж чаддаггүй байна.


ЗХШ-ийн шийдвэрийн хэрэгжилт

НЗХШ-ээр 2004-2007 оны хагас жил хүртэл 2004 онд 2 хэрэг, 2005 онд 8 хэрэг, 2006 онд 19 хэрэг, 2007 оны хагас жилийн байдлаар 10 төрийн албатай холбоотой нийт 39 хэргийг шийдвэрлэсэн байна.

/Хавсралт-3/

Төв аймгийн ЗХШ 2004-2007 оны хагас жилийн байдлаар 2005 онд 1 хэрэг, 2006 онд 2 хэрэг, 2007 оны хагас жилийн байдлаар 1 төрийн албатай холбоотой нийт 4 хэргийг шийдвэрлэсэн байна.

Дархан-Уул аймгийн ЗХШ 2004-2007 оны хагас жилийн байдлаар төрийн албатай холбоотой хэрэг шийдвэрлээгүй байна. /Зураг 3³³/



ШШГБ-д хандсан хэргийн судалгаа

НЗХШ-ээр 2004-2007 оны байдлаар шийдвэрлэсэн нийт 39 хэргийн 2005 онд 6 хэрэг, 2006 онд 5 хэрэг, 2007 оны байдлаар 3 хэргийн нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг албандан биелүүлэхээр шүүхэд хүсэлт гаргасан бөгөөд үүний дагуу НШГА хэрэг үүсгэсэн байна. Энэхүү үзүүлэлт нь ЗХШ-ээр шийдвэрлэсэн төрийн албатай холбоотой хэргийн 35 хувийг эзлэж байгаа нь ЗХШ-ээр шийдвэрлэсэн нийт хэргийн хэмжээнд шийдвэр гүйцэтгэлд хандсан үзүүлэлтийн хувьд илүү байгаа юм. /Зураг №4/

Δ/д	Он	Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хэргийн тоо	НШГА-д хандсан хэргийн тоо	Нийт хэрэгт эзлэх хувь
	2004	2	0	35%
	2005	8	6	
	2006	19	5	
	2007	10	3	
Нийт		39	14	

³³ Төрийн албаны хэргийн харьцуулсан судалгаа. Дээд шүүхийн тайлан мэдээ. УБ., 2004, 2005, 2006, 2007 он.

ШШГБ-д ирсэн нийт хэргийн 64 хувь буюу 9 хэргийн шийдвэр биелсэн, 36 хувь буюу 5 хэргийн шийдвэр биелээгүй байна. Хэдийгээр ШШГА-д хандсан нийт хэргийн 64 хувь биелэгдсэн гэсэн дүн үзүүлэлт гарч буй ч шүүхийн шийдвэр 2005 онд гарсан, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа үүсгэсэн ЗХШ-ийн шийдвэр биелээгүй хэргүүд байна.

Жишээ №1

НЗХШ 2005 оны 09 дүгээр сард нэхэмжлэгч “А”-ийн Гаалийн ерөнхий газрын даргын 2005 оны 07 дугаар сарын тушаалыг хүчингүй болгож, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна. Шүүхийн шийдвэрийн дагуу хариуцагч байгууллага шийдвэрийг биелүүлэхгүй байсан тул нэхэмжлэгч 2005 оны 10 дугаар сард НШГА-д хандсаны дагуу 2005 оны 10.05-ны өдөр ажиллагаа үүсгэсэн ч одоо болтол шийдвэр хэрэгжээгүй байна.

Шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа шалтгаан, түүнчлэн, шийдвэрийг биелүүлэх явцад ямар хүндрэл гарч буйг тогтоох зорилгоор НШГА-ны /ЗХШ-ийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хийж байсан/ шийдвэр гүйцэтгэгч нартай ярилцлагын аргаар биелэгдээгүй хэрэг тус бүр дээр хэрэгжээгүй шалтгааныг тодруулж ярилцлага хийсэн бөгөөд дараах дараах зүйлүүдийг онцолсон байна. Үүнд:

- ТЗБ, түүний албан тушаалтанд шийдвэр гаргахыг мэдэгдсэн албан бичгийг удаа дараа явуулж, шийдвэрийг биелүүлэх талаар уулздаг боловч биелүүлдэггүй;
- Тухайн албан тушаалтныг өмнөх ажилд нь эгүүлэн тогтоох гэтэл орон тоо байдаггүй, өөр хүнийг томилсон байдаг;
- Шүүхийн шийдвэр ойлгомжгүй, гүйцэтгэх хуудас шийдвэрийг хэрхэн биелүүлэх талаар зааж өгдөггүй;
- Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох механизм сул байдаг;

ЗХШ-ийн маргаан хянан шийдвэрлэх онцлогтой холбоотойгоор шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт хуульд байхгүйгээс шийдвэр гүйцэтгэгч нар шийдвэр биелүүлэх ажиллагаа хэрхэн явуулах талаар нэгдсэн ойлголтгүй, түүнчлэн, хариуцагч нь ТЗБ байдаг учраас шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар шаардлага тавьсан ч биелүүлэхгүй байх тохиолдол элбэг байна.

ШШГБ-д хандсан хэргийн судалгаанаас нийт хэргийн 36 хувь нь биелээгүй байгааг өмнө дурьдсан бөгөөд энэ тохиолдлуудад шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр Захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулахаар холбогдох байгууллагад хүсэлт тавиагүй байна.

Түүнчлэн, ажлаас үндэслэлгүй халагдсан төрийн албан хаагчийг хуучин ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах шийдвэрийг биелүүлэхэд Төрийн санд хандаг бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчаас бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн цалинг олгох зохицуулалтын дагуу бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэж мөнгө гаргана хэмээн хариу өгдөг байна. Гэтэл төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн албан хаагчийг халсан захиргааны албан тушаалтан байдаг нь ажлаас халагдсан ТЖАХ-ийн эрхийг бүрэн хэмжээгээр сэргээхэд бэрхшээлтэй асуудлын нэг болдог талаар шийдвэр гүйцэтгэгчид дурдаж байлаа.

ШШГБ-д хандаагүй хэргийн судалгаа

ЗХШ-ийн шийдвэрийг биелүүлэхээр ШШГБ-д хандсан хэргийн судалгаа нь нийт хэргийн 35 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдэх 65 хувь буюу 25 хэргийн хувьд шийдвэр биелэгдсэн эсэх талаар судалгааг явуулав. /Хавсралт-5/

Уг судалгааг хийх болсон шалтгаан нь ШШГБ-д хандаагүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг биелэгдсэн гэж үздэг нийтлэг жишгийн дагуу хийсвэр байдлаар тоон үзүүлэлтийг дүгнэхээс зайлсхийж, бодит үр дүнг гаргахыг зорьсон юм.

Судалгаанд хамрагдагсдын дунд ЗХШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг судлахын тулд дараах нийтлэг асуултуудыг тавьж ярилцлагыг явуулсан болно. /уг судалгаанд нийт 15 нэхэмжлэгч хамрагдсан/

1. ЗХШ-ийн шийдвэр биелсэн эсэх талаар асуулга авахад нийт оролцогчдын 40 хувь 10 хэргийн нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэр биелэгдсэн, 20 хувь буюу 5 хэргийн нэхэмжлэгч шүүхийн шийдвэр биелээгүй гэж хариулсан³⁴ байна.

³⁴ Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг ярилцлагын аргаар судлахад нийт 8 нэхэмжлэгчтэй холбоо барих боломжгүй байсан болно.

/Зураг №05/



2. ЗХШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг талаар ярилцлага хийсэн хэргийн оролцогчдоос шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа нь дараах шалтгаантай гэж хариулсан байна. Үүнд:

ШШГБ-ын илэвхитэй бус үйл ажиллагаа, ТЗБ, түүний албан тушаалтан шүүхийн шийдвэрийг үл хүндэтгэх байдал

- Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх албан тушаалтан нь санаатайгаар шийдвэрийг биелүүлдэггүй;
- Шүүхийн шийдвэрээр эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоогоод шийдвэр гаргахыг даалгадаг ч захиргааны байгууллагын албан тушаалтан хурлаар хэлэлцүүлнэ, нэмж материал шаардах зэргээр хүнд суртал гаргадаг;
- ТЗБ-ын хүнд суртал, авилгалд автсантай холбоотой.

ЗХШ-ийн үйл ажиллагаа

- ЗХШ тухайн асуудлыг шийдвэрлэхдээ хэт бөөрөнхийлж, ойлгомжгүй шийдвэр гаргасан;

Бусад

- Давамгай байр суурьтай байгаа нам нь төрийн албан хаагч болон шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд нөлөөлдөг, дээрээ нь үүрэг болгодог;
- Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох механизм нь сул байгаатай холбоотой.

Шүүхийн шийдвэр биелүүлэхээр ШШГБ-д хандаагүй тохиолдол болгон биелэгдсэн гэж үзэж болохгүй бөгөөд нийт хэргийн 28 хувийг эзэлж буй нь бага тоо биш юм.

Түүнчлэн, төрийн албатай холбоотой шүүхийн шийдвэрийг орон тоо байхгүй өөр хүн орон тоонд нь ажиллаж байгаа, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу өмнө эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах шийдвэрлэсэн ч өөр албан тушаалд томилдог, цалингаа авахгүй бол ажилд нь томилно гэх мэт үндэслэлгүйг шалтаг зааж шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй талаар судалгаанд оролцогчид дурьдаж байв. Шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд хариуцагч этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй байтал ТЗБ, түүний албан тушаалтан шийдвэрийг биелүүлэхгүй ТЖАХ-ын хувьд шийдвэр гарсан ч эрхээ сэргээлгэж чадахгүй удаан хугацааны турш хохирч байгаа тохиолдол байна.

Жишээ №2

Нэхэмжлэгч “Б”-ийн Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын 2006 оны 03 дугаар сарын №18 дугаар тушаалыг хүчингүй болгуулж, ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий хэргийг хэлэлцэж НЗХШ-ээс тушаалын “Б”- д холбогдох хэсгийг хүчингүй болгож, ажилгүй байсан хугацааны 592.295 төгрөгийг Улсын мэргэжлийн хяналтын газраар гаргуулж олгохоор шийдвэрлэсэн байна. Шүүхийн шийдвэр гарсны дагуу хариуцагч биелүүлээгүй бөгөөд нэхэмжлэгчээс авсан ярилцлагад дурдсанаар: төрийн албаны шалгалтад ороогүй хүнийг миний оронд ажилуулснаар байгаа бөгөөд одоо болтол шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй гэжээ. Түүнчлэн, нэхэмжлэгч ажилгүй байсан хугацааны 1.6 жилийн хугацааны цалингаас зөвхөн 6 сарын цалинг байгууллагаас гаргуулсан байна.

Тухайн харилцаатай холбоотой зохицуулж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан гэх эрх гэх эрх зүйн бусад аргууд нь өөр хоорондоо зөрчилтэй, бүрэн зохицуулагдаагүй байдал ажиглагдаж байна. Тухайлбал: ТАТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.1 ба 26 дугаар зүйлийн 26.1.3-д зааснаар төрийн байгууллагын удирдах албан тушаалтан ТЖАХ-г өөрийн үзэмжээр халах өргөн боломжийг олгосон гэж үзэж болохоор байна. Зарим харилцааг бүрэн зохицуулаагүй орхигдуулснаас албан тушаалтан хууль бус үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн нь ажиглагдаж байна.

ТАТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.8-д ТЖАХ-д оногдуулсан сахилгын шийтгэл нь үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллага эсвэл шүүхэд аль алинд нь шууд гомдлоо гаргаж болохоор зохицуулсан байхад Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолын 9 дүгээр зүйлд дээд шатны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл ТАЗ-д эсвэл шүүхэд³⁵ гаргаж болохоор заасан байна. Түүнчлэн ТАТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.4-д ТЖАХ ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзвэл гомдлоо ТАСЗ болон төрийн албаны төв байгууллагад хандаж болох ба энэ зохицуулалтад сахилгын шийтгэл оногдуулж халах үндэслэлд хамаарч байгаа нь журам болон ТАТХ-ийн 26.8 дах заалтуудтай зөрчилдсөн байдлаар зохицуулсан байна.

ТАТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.4-д ТЖАХ-ийг ажлаас үндэслэлгүй халагдсан гомдлоо ТАСЗ болон төрийн албаны төв зөвлөлд гаргахаар заасан байна. Гэтэл нарийвчилсан зохицуулсан УИХ-ын 2002 оны 85 дугаар тогтоолд ТАЗ нь зөвхөн салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн маргааныг хянан шийдвэрлэхээр³⁶ түүнчлэн УИХ-ын 2003 оны 14 дүгээр тогтоолд ТАЗ болон ТАСЗ-ийн шийдвэрлэх маргааныг тодорхойлж, ТЖАХ-г үндэслэлгүйгээр ажлаас халсантай холбоотой маргааныг ТАЗ шийдвэрлэхээр³⁷ заасан байна. Эдгээр заалт нь хоорондоо зөрчилтэй бөгөөд ТЖАХ-г ажлаас үндэслэлгүй халсан талаарх маргааныг шууд ТАЗ, эсхүл салбар зөвлөлд гаргах эсэх нь ойлгомжгүй бөгөөд тодорхой бус байна.

Төрийн албанд “мэргэшсэн тогтвортой” зарчмыг хангуулах чиг үүрэг бүхий ТАЗ-ийн үүрэг сул, түүний гаргасан шийдвэр тэр бүр хэрэгждэггүй болох нь судалгаанаас харагдлаа. Тухайлбал, судалгаанаас харахад ТАЗ авч ирсэн хэргийн 59 хувийг төрийн албаны салбар зөвлөлд шилжүүлсэн нь нэг талаас дамжлагын шинжтэй нөгөө талаас төрийн албаны салбар зөвлөл нь гомдол гаргагчийн хүсэлтийг хүлээн авдаггүй, чирэгдүүлдэг тал ажиглагдаж байна.

Төрийн байгууллага, албан тушаалтан ТАТХ-ийг зөрчин ТЖАХ-ийг халах явдал түгээмэл байгаа нь ажиглагдав. Төрийн албан зөвлөлийн нийт шийдвэрлэсэн хэргийн нийт шийдвэрлэсэн хэргийн 83 хувьд гомдол гаргагчийн шаардлагыг хангасан нь төрийн байгууллага, албан тушаалтан ТАТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 26 дугаар зүйлийн 26.1.3

³⁵ <http://www.parl.gov.mn/>

³⁶ <http://www.parl.gov.mn/>

³⁷ <http://www.parl.gov.mn/>

дах заалтыг зөрчиж шийдвэр гаргадаг ажээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. ТАЗ, түүний салбар зөвлөл төрийн албатай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэдэггүй учраас цаг хугацаа алдаж, хохирлоо нөхөн төлүүлэх байдал улам сунжирахад шууд нөлөөлдөг гэсэн үзэл, хандлага ихээхэн түгээмэл болсон нь судалгааны үр дүнд харагдаж байна. ТАЗ гомдол, маргааныг шийдвэрлэсэн шийдвэрийг төрийн байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэх үүрэгтэй гэж заасан боловч энэ нь “хий хоосон” зүйл болжээ.

Төрийн албанаас хууль бусаар халагдсан иргэн өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх боломж хомс, зарим тохиолдолд бүр байхгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, ажилгүй байсан үеийн цалингаа буцааж авна гэдэг нь эрх зүйн болоод зохион байгуулалтын хувьд туйлын хүнд болох нь судалгаанаас тодорхой болсон.

Дүгнэлт

1. Төрийн алба түүний дотор төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар халах асуудалтай холбогдуулан нэн тэргүүн ээлжид эрх зүйн орчныг өөрчлөх шаардлага байна. Төрийн албаны тухай хуулийн 25.1.1 болон 26.1.3 гэсэн үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг халдаг байдлыг зогсоохын тулд эдгээр заалтыг нэгтгэх, эсхүл хооронд нь уялдуулах шаардлага байна. Мөн сахилгын шийтгэлээр халагдсан эсхүл бусад шалтгаанаар халагдсан албан хаагчийн хувьд эрхээ сэргээлгэх нэг процедур байх шаардлагатай болжээ. Гомдол гаргах хугацаа, хандах субъектийг өөр өөрөөр тодорхойлох нь эцсийн дүндээ сөргөөр нөлөөлөх нь тодорхой юм.
2. Төрийн албатай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхэд шат дамжлага их байгаа нь хохирсон төрийн албан хаагчийг улам хүнд байдалд оруулж байна. Төрийн жинхэнэ албан хаагч гомдлоо заавал төрийн албаны зөвлөл, төрийн албаны салбар зөвлөлд хандаж цаг хугацаа ихээхэн алддаг байдал нилээд байна. Тиймээс ийм төрлийн “урьдчилан шийдвэрлэх ажиллагаа” заавал байх шаардлагатай эсэхийг шийдвэрлэх болсон байна.
3. *Дээрх дүгнэлт нь Төрийн албатай холбоотой* маргааныг Төрийн албаны зөвлөлд шийдвэрлэсний үр нөлөө сул байгаатай шууд холбоотой. Судалгааны явцад ярилцсан цөөн хүмүүсийн дийлэнх нь Төрийн албаны зөвлөлийн шийдвэр биелэгдэхгүй,

зарим хэсэг нь шүүхэд ханддаг зэргээс дүгнэхэд Төрийн албаны зөвлөлийн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүргээ Төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлдэггүй гэж хариулж байсныг анхааралгүй өнгөрч болохгүй юм. Түүнээс гадна, төрийн албаны салбар зөвлөл гэх хууль бусаар халах шийдвэр гаргасан албан тушаалтнаар ахлуулсан зөвлөл байх шаардлагагүй юм. Харин түүний оронд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүдээс бүрдсэн комисс дүгнэлтээ Төрийн албаны зөвлөлд танилцуулж байх механизм байж болохыг хуульчлах нь зүйтэй юм.

4. Хууль бусаар халагдсан албан хаагч ажилгүй байсан хугацааны цалингаа авч чаддаггүй байдал нилээдгүй байна. Тиймээс тушаалыг хууль бус гэж тогтоосон бол уг тушаалыг гаргасан албан тушаалтан цалинг нь шууд хариуцдаг болох шаардлагатай байна.

Гурав. Шүүгч, Прокурор, Хэрэг бүртгэгч, Мөрдөн байцаагчийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас хохирсон иргэдийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдал

Судалгааны хамрах хүрээ нь 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг, бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах” хэмээх бүлэгт хуульчилсан, мөн хуулийн 388-397 дугаар зүйлд заасан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг олж тогтоож түүнд үнэлэлт өгөх явдал бөгөөд энэ хүрээнд иргэд шүүгч, прокурор, ХБ, МБ-ын хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас өөрт нь учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд хандан нэхэмжлэл гаргаж буйг эсэхийг олж тогтоож, тийнхүү хохирлоо нөхөн төлүүлэхэд нь тулгарч буй бэрхшээлийн шалтгааныг судлан тогтоох явдал нь судалгааны үндсэн гол судлагдахуун нь боллоо.

Монгол Улсад энэ төрлийн харилцааг зохицуулж байсан болон, эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй дараах хууль, Улсын дээд шүүхийн тогтоол байна. Үүнд:

1990 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай”

хууль, 2002 оны 09 дүгээр сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”, 1994 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн “Иргэний хууль”, 2002 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Иргэний хууль”, 2006 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Засгийн газрын тусгай сангийн” тухай хууль, Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоол зэрэг байна. Судалгааны хүрээнд дээрх хууль, УДШ-ийн тогтоолуудыг харьцуулсан судалгааны аргаар судлан үзлээ.

1990 оны хуулийн 3 дугаар зүйлд	2002 оны хуулийн 389 дүгээр зүйлд
Гэмт хэрэг гараагүй, тухайн хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй	Баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс судлагдсан
Тухайн иргэн гэмт хэрэг үйлдсэн буюу захиргааны эрх зүйн зөрчил гаргасан нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон	Тухайн иргэнийг цагаатгасан шүүхийн тогтоол гарсан
Түүнчлэн тухайн иргэнийг цагаатгасан	Тухайн хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эсхүл тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон
	Эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон бол

Иргэн ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх үүсэх хууль зүйн үндэслэлийн хувьд:

Дээрх хуулиудад иргэн ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд хандах үндэслэлүүдийг тогтоохдоо тухайн иргэнд холбогдуулан шалгаж байсан хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг цагаатгах шүүхийн тогтоол гарсан гэх үндэслэлүүд нь хэвээрээ бөгөөд гагцхүү 2002 оны ЭБШХ-иар “Эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус тогтоолыг хүчингүй болгосон

бол”, “Баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс сулагдсан” гэх үндэслэлүүдийг тогтоож өгчээ.

Судалгааны хүрээнд иргэнд учирсан хохирлыг нөхөн төлөх субъектыг:

1990 оны хуулийн 4 дүгээр зүйлд	2002 оны хуулийн 389.1. дүгээр зүйлд
Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан сэргийлэх арга хэмжээ болгон цагдан хорьсон, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулснаас иргэнд учирсан эд хөрөнгийн хохирлыг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын албан тушаалтны гэм бурууг харгалзахгүйгээр улс хариуцан арилгана.	Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.

Эдгээр хуулиудад иргэнд учирсан хохирлыг төр (улс) хариуцан арилгахаар зохицуулжээ. Энэ нь иргэнд төрийн үйл ажиллагааны нэг чиг үүргийг хэрэгжүүлэгч албан тушаалтнууд болох шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн алдаанаас учруулсан хохирлыг иргэний өмнө төр хариуцахаар тогтоожээ.

Уг зохицуулалтын давуу тал: төрийн байгууллагын үйл ажиллагаа буюу ЭБША-ны явцад шүүх эрх мэдлийн хүрээнд дэх албан тушаалтнуудын иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлж иргэнийг хохиролгүй болгож байна.

Уг зохицуулалтын сул тал: төр (улс)-өөс хохирлыг нөхөн төлөхөөр зохицуулсан нь чухам хэн хариуцан иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлөх нь тодорхойгүй болгож байна. Түүнчлэн, иргэнд өөрийн шийдвэр, үйл ажиллагааны улмаас хохирол учруулж буй албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх буюу тэдний хариуцлагыг өндөржүүлэх боломжгүй болгож байна. Энэ нь дээрх хоёр хуулиудын нийтлэг тал болжээ. Тэгвэл уг сул талын хязгаарласан заалт 1990 оны хуулийн 4 дүгээр зүйлд “ . . . Харин шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын гэм буруутай албан тушаалтанд БНМАУ-ын хууль тогтоомжид зааснаар эрүүгийн, сахилгын, эд материалын болон бусад хариуцлага хүлээлгэнэ.

Хэрэв уг ажиллагаа гэмт хэрэг болох нь зохих журмаар тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар бүрэн төлүүлнэ. Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг холбогдох санхүүгийн болон бусад байгууллага БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмаар шүүхэд гаргана . . .” гэж заасан нь төрөөс өөрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтнуудад хариуцлага тооцох замаар төрөөс буюу татварын хөрөнгөөс бүрдсэн төсвийн эх үүсвэрийг заасан заалт болжээ. Тэгвэл энэ төрлийн зохицуулалт 2002 оны ЭБШХ-иар зохицуулагдаагүй орхигдсон нь сул тал нь болжээ.

Хохирогчид нөхөн төлөх эд хөрөнгийн хохирлын талаарх зохицуулалт уг хуулиудад ижил байдлаар тусгагдсан байна. Тэгвэл иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудал хууль зүйн институтыг 2002 оны ЭБШХ-ийн 391 дүгээр зүйлд зохицуулсан байна.

Дээрх хуулиудаар зохицуулсан нэг харилцаа нь хохирогчид шүүхэд хандах эрхийг тайлбарлаж өгөх институт юм.

1990 оны хуулийн 12 дугаар зүйлд	2002 оны хуулийн 394 дүгээр зүйлд
Таслан шийдвэрлэх цагаатгах тогтоол гарсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллага тухайн иргэний хөдөлмөрийн хамт олонд буюу оршин суугаа газрынх нь төрийн захиргааны байгууллагад энэ тухай 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй . Иргэнийг ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан сэргийлэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, эсхүл захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ авсан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа дурдсан ажиллагаа хууль зөрчсөн болох нь нотлогдвол шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллага уг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй.	394.2 Иргэнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хуулийн байгууллага тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан цагаатгасан тухай шийдвэрийн талаар 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй

Дээрх хуулиудын уг заалтууд ижил байдлаар тусгагдсан байна. Харин 2002 оны ЭБШХ-иар зохицуулсан нэг зохицуулалт нь ЭБШХ-ийн 394.1-т заасны дагуу “Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүх, прокурор нь иргэнд зөрчигдсөн **эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж өгөх**, түүнчлэн иргэний хүсэлтийн дагуу 1 сарын дотор өөрийн гаргасан шийдвэрийн талаар түүний ажиллаж байгаа байгууллагад **бичгээр лавлагаа өгөх үүрэгтэй**” гэх заалт юм. Учир нь уг заалт ёсоор иргэн ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах, улмаар шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлэх заалт болжээ. Тэгвэл уг заалтын хэрэгжилтийг нийслэлийн хэмжээний шүүгч, өмгөөлөгч нарын хамарсан мэргэжлийн бүлгийг хамруулсан судалгааны үр дүнгээс³⁸ хархад нийт судалгаанд оролцогчдын дийлэнх нь **энэ лавлагааг өгдөггүй, сонирхогч этгээдийн хүсэлтээр л өгч байгаа** хэмээх хариулатыг өгчээ.

Уг судалгаанаас үзэхэд ЭБША-наас хохирсон иргэдийн хувьд хохирол нөхөн төлөгдөх үндэслэлийг тайлбарлаж өгөх үүрэгтэй байгууллагын зүгээс хуулиар тогтоож өгсөн үүргээ биелүүлэхгүй байгаа нь иргэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд хандахгүй байгаа нэг шалтгаан болж байна.

Судалгааны хүрээнд ихээхэн анхаарал татаж буй нэг асуудал нь 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоолын 24 дүгээрт Хуулийн 397 дугаар зүйлийн 397.1.-д заасан **“хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдөл”** гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3.-т заасан **“хүсэлт”** гэж ойлгон, энэ төрлийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт зохицуулагдсан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ хэмээн зохицуулсан болж байна. Учир нь ИХХШТХ-ийн

³⁸ Судалгаанд Нийслэлийн хэмжээний 40 шүүгч, 10 өмгөөлөгч нарыг судалгаанд хамруулсан бөгөөд судалгааг асуумжийн аргаар явуулан нэгдсэн боловсруулалтыг хийлээ. Судалгааны үр дүнг гаргахдаа оролцогчдын дийлэнхи олонх хариулатыг буюу чанарыг шалгуур болгон гаргалаа.

онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх маргааны 133 дугаар зүйл³⁹ зааж өгсөн байх бөгөөд үүнд нь энэ төрлийн маргааны талаар зохицуулаагүй байна. Тэгвэл уг хуулийн заалт УДШ тайлбар хоёрын хоорондох зөрчлийн талаар мэргэжлийн бүлгээс авсан судалгааны үр дүнд **оролцогчдын дийлэнх нь ИХШХШТХ-д нэмэлт оруулах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй** гэж үзсэн байна. Учир нь УДШ-ийн тайлбараар хуулиар зохицуулаагүй харилцааг зохицуулсан шинжийг агуулж байна.

Судалгааг Нийслэлийн хэмжээнд 2003-2006 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн хүрээнд явуулсан бөгөөд ингэхдээ ЭБШХ-ийн 389.1 дэх “Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн **гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана**” гэж заасны дагуу судалгаагаа **төр** буюу түүний байгууллага албан тушаалтан хариуцагчаар татагдан оролцсон хэргийг судлан үзлээ.

Ийнхүү судлах болсон шалтгаан нь ЭБШХ-ийн 396.8 дэх хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон прокурор, шүүхийн байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг холбогдох байгууллага **Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шүүхэд гаргана**” гэж заасны дагуу иргэн өөрт учирсан хохирлоо иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна.

Судалгааг 3 үндсэн бүлгийн хүрээнд бүлэглэн авч үзлээ. **Нэг:** нийслэлийн хэмжээнд анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн нийт хэргээс нэхэмжлэгч өөртөө учирсан гэм хор арилгуулахаар нэхэмжлэл гаргасан хэргийг **Хоёр:** Судалгааны нэгдүгээр хэсгийн нийт хэргээс төрийн байгууллага албан тушаалтан хариуцагчаар оролцсон анхан шатны нийт хэргийг **Гурав:** Судалгааны хоёрдугаар хэсгээр тогтоосон маргаанаас Иргэний хуулийн 498.4 дэх хэсэг буюу тус судалгааны гол судлагдахуун болох маргаан шүүгч, прокурор, ХБ, МБ-ын хууль бус

³⁹ 133.1.Шүүх дараах хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ: 133.1.1. эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох; 133.1.2. хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах; 133.1.3. сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох; 133.1.4. хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох; 133.1.5. асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох; 133.1.6. эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх; 133.1.7.иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох; 133.1.8. хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх; 133.1.9. нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах гэжээ.

шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдлыг дээрх 2 судалгаан дээр үндэслэн олж тогтоов Ингэхэд 2006 оны байдлаар 2 маргааныг олж тогтоолоо. Энэ нь Баянзүрх дүүргийн шүүхээс 2004, 2005 онд хянан шийдвэрлэсэн маргаан байлаа. Иймээс өмнө дурдсан суурь оноос хойш шүүхээр хянан шийдвэрлэгдсэн маргааныг судлан үзлээ. Өөрөөр хэлбэл, 2007 оны хагас жилийн байдлаар Иргэний хуулийн 498.4 дэх “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс **үл хамааран төр хариуцан арилгана**” хэмээн зааснаас үндэслэн шүүгч, прокурор, ХБ, МБ-ын хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдлыг судаллаа. Судалгааг 2007 оны эхний хагас жилийн шүүхээр хянан шийдвэрлэсэн маргаанд явуулав. Энэ хугацаанд нийт 5 маргааныг шүүхээс хянан шийдвэрлэжээ.

1. Нэхэмжлэгчдийн хувьд 7 нэхэмжлэгчтэй 11 иргэн ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхээс учирсан хохирлыг нөхөн төлөх үндэслэлтэй хэмээн хянан шийдвэрлэжээ. Эдгээр иргэд нь тус судалгааны ажлын хүрээн дэх хохирогч болж байна;
2. Эдгээр 7 маргааны хувьд шүүхэд хандах хууль зүйн үндэслэлийн нь хувьд авч үзвэл ЭБШХ-ийн **389.2.3 дах хэсэгт зааснаар** прокуророос хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолыг үндэслэн шүүхэд нэхэмжлэл гаргасан 3 нэхэмжлэгч, **ЭБШХ-ийн 389.2.2 дах хэсэгт зааснаар** шүүхээс хэргийг цагаатгасан 4 нэхэмжлэгч байна. Үүнээс үзвэл: манай өнөөгийн практикт шүүхийн цагаатгах тогтоол, прокурорын хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолыг үндэслэл болгон шүүхэд нэхэмжлэл гаргаж байна.
3. Шүүхээс **эд хөрөнгийн хохиролд** эрүүгийн хэргийн улмаас хорьж, мөрдөгдөх хугацаанд олох ёстой байсан орлогыг ойлгож маргааныг шийдвэрлэж байна. Ингэхдээ иргэн эрүүгийн хэргийн улмаас хорьж, мөрдөгдөхөөс өмнөх хугацаанд ажил эрхлэлтийн байдлаас үүдэн хэрэв ажил эрхэлж байсан бол цалингийн хувь хэмжээгээр нийгмийн даатгалын шийтгэл төлсөн байдлыг

шалгуур болгон олох ёстой байсан орлогыг нөхөн төлүүлж байна. Харин олох ёстой байсан үр шимийн асуудлыг гагцхүү Ч.Эрдэнэ-Очирын нэхэмжлэлтэй маргаанд шүүхээс авч үзсэн байна. *Жишээ нь:* “185 толгой малын өсөлт, үржилт, ашиг шим нь болох 20988000₮, “445 толгой малтай буюу малын үнэ 9205000₮, малаас олж болох ашиг 11 800 000 төгрөгийг оруулж тооцсон байгаагаар харагдаж байна. Эд хөрөнгийн хохиролд шүүхээс өмгөөллийн хөлс, эмчилгээний зардал, бусад эд хөрөнгөөр үнэлж болох зардлуудыг нийтлэг байдлаар оруулан тооцож байна.

4. **Сэтгэл санааны хохирлыг тооцох** хуульчдын дунд ихээхэн маргаантай бөгөөд нэг мөр болоогүй ойлголт бололтой. Иймээс сэтгэл санааны хохирлыг арилгуулахдаа олон янзын шалгуурыг үндэслэл болгож байгаа боловч нөгөөтэйгүүр ямар ч гэсэн уг хохирлыг гаргуулах шүүхийн шийдвэр анхны оролдлого гарч байгаа сайшаалтай.
5. **Нэр, төр алдар хүндийг шүүхээс үнэлэхдээ** олон нийтийн мэдээллийн хэрэглэснээр чухам хэдэн удаа мэдээлснийг шалгуур болгож байна. *Жишээ нь:* Л.Хажидмаагийн нэхэмжлэлтэй хэрэгт **8 сонинд 23 удаа шалгагдаж буй** хэргийн талаар нийтлэгдсэн байх тул 5 000 000 төгрөг гаргахаар шийдвэрлэжээ. Түүнчлэн, телевизээр олон нийтэд хүрсэн байдлыг У.Оргилболдын нэхэмжлэлтэй хэрэгт дараах байдлаар тооцон авч үзсэн. Үүнд: 1 минут 30 секундын сурвалжлагыг **1 минутыг 100 000 төгрөгөөр тооцон** 150 000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Ингэхдээ Монголын мэдээ агентлагийн мөрдөх үнэлгээгээр 1 минутын сурвалжлага 100 000 төгрөг байдгийг шалгуур болгожээ.
6. Энэ төрлийн маргааны нэг онцлог нь **шүүхээс хариуцагчаар ямар байгууллагыг оролцуулах нь маргаатай байна.** Жишээ нь: Ч.Эрдэнэ-Очир, У.Оргилболд нарын нэхэмжлэлтэй хэрэгт хариуцагчаар Сангийн яамны (тухай үеийн нэрээр) төрийн сангийн газрыг оролцуулсан бол Г.Мөнхбаатарын нэхэмжлэлтэй хэрэгт **хариуцагчгүйгээр** маргааныг хянан шийдвэрлэжээ. Бусад маргаанд нь **харьяалах дүүргийн прокурор төрийн нэрийн** өмнөөс оролцжээ. Дээрх байдлаас үүдэн Сангийн яамны Төрийн сангийн газар хариуцагчаар оролцсон маргаанд давж заалдах

болон хяналтын шатанд гомдолд гаргасан бол бусад хэрэгт анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргаагүй байна. Шүүхийн бүх шийдвэрт шүүгч, прокурор, ХБ, МБ-ын хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг Сангийн яамны Төрийн сангийн газраас гаргуулахаар шүүхийн шийдвэрт тусгажээ. Түүнчлэн, маргаан хянан шийдвэрлэхэд хэрэглэж буй хуулийн хувьд анхаарал татаж байна. Учир нь хохирол нөхөн төлөгдөх үндэслэлийг ЭБШХ-иар (процессын хэм хэмжээ агуулсан) зохицуулсан боловч хохирлын нөхөн төлөгдөх шийдвэрийг ИХ-ийн гэм хор учруулсан гэх зохицуулалтыг үндэслэн маргааныг хянан шийдвэрлэж байна.

Судалгааны үр дүнгээс хархад ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд хандах иргэдийн хандлага сул байгааг харж болно. Учир нь шүүхэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хандах эрхтэй иргэдийн тоо өндөр байгаа боловч **шүүхэд нэхэмжлэл гаргах иргэдийн хүрээ хязгаарлагдмал байгаагийн шалтгаан, нөхцөлийг тогтоох үүднээс** ЭБША-наас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх хууль зүйн зохицуулалтын мэдээллийн хүртээмжтэй байдал буюу уг заалтыг иргэд мэддэг эсэхэд тандалт хийх үүднээс социологийн судалгааг явууллаа.

Судалгаанд 18-56 насны 190 иргэдийн дунд явуулсан социологийн судалгааны үрдүнд **“Та Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгээр иргэн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад учирсан хохирлоо арилгуулах хууль зүйн боломжийг зааж өгсөн байдаг. Энэ талаарх таны мэдлэг”** гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 16.2 % буюу 32 хүн нь мэднэ гэх хариултыг, 83.8 % буюу дийлэнх олонх нь мэдэхгүй гэх хариултыг ингэхдээ анх удаа сонсож байна гэж 17.7 %, урьд өмнө нь сонсож байсан сайн мэдэхгүй гэж 24.7% нь хариулжээ.

Шүүхээс ЭБША-наас иргэнд учруулсан шүүгч, прокурор, ХБ, МБ-ын хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй болохыг тогтоосны үндсэн хариуцагчаас гаргуулах хохирлын үнийн дүнг бодитоор нөхөн төлүүлэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шатанд хамаарна. Судалгааны хүрээнд энэ түвшинд өнөөгийн практикийг судлан үзлээ. Ингэхдээ өмнө дурдсан шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн шийдвэрийн хэрэгжилтэд судалгааг явууллаа.

Судалгааны явцад шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 7 маргааныг хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд нийт 7 маргаанаас 2 буюу Ч.Эрдэнэ-Очир, У.Оргилболд нарын төлбөрийг гаргуулжээ. Энэ төрлийн маргааны хувьд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу шүүхээс тогтоосон хохирлыг төлбөр гаргуулагч болох Сангийн яамны Төрийн сангийн газраас шүүхээс тогтоосон хохирлыг гаргуулжээ. Уг ажиллагааны явцад дараах нийтлэг бэрхшээл тулгарч байна. Үүнд:

1. Хэдийгээр шүүхээс Сангийн яамны Төрийн сангийн газраас нөхөн төлүүлэхээр гаргасан хүчин төгөлдөр шийдвэр байгаа боловч төлбөр гаргуулагчийн зүгээс шийдвэр биелүүлэхээс татгалзах хандлага ажиглагдлаа. Ингэхдээ Сангийн яамны Төрийн сангийн газар нь уг хохирлыг учруулаагүй түүнчлэн, нөхөн төлүүлэх зардлыг гаргахад СЭЗЯ-ны сайдын 2003 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 361 дугаар тушаалын дагуу төсвийн байгууллагын харилцах данснаас хийх шууд хасалтыг зөвхөн тухай байгууллагын төсвийн захирагчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хийж байхаар заасан гэх тайлбарыг хийж шийдвэр гүйцэтгэхийг түдгэлзжээ. Түүнчлэн, Сангийн яамны Төрийн сангийн газраас тус газар бие даан төсөв захиран зарцуулах эрхгүй гэдгээ албан ёсоор илэрхийлсэн байна. Энэ байдал нь ЭБША-ны улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх зохицуулалт нь өөрөө тодорхойгүй буюу **“төр”** хариуцах зохицуулалттай байгаа нь Сангийн яамны Төрийн сангийн газраас шүүхээс тогтоосон хохирлыг нөхөн төлөхөөс татгалзах боломжийг буй олгож байна. Нөгөө талаасаа ЭБША-г эрхлэн явуулж буй албан тушаалтнуудад хүлээлгэх хууль зүйн хариуцлагын боломж хязгаарлагдмал байгаа нь нөлөөлж байна.
2. Шийдвэр биелэгдсэн хугацааны хувьд НШШГ албанаас 2005 оны 2 дугаар сарын 17-нд үүсгэн энэ хугацаанд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаануудыг хийсний дараагаар Сангийн яамны сайдын 2005 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 79 дугаар тушаалаар Ч.Эрдэнэ-Очирт учирсан хохирол болгож шүүхээс тогтоосон 18 010 625 төгрөгийг барагдуулсан байна. Хохирогч Ч.Эрдэнэ-Очир 2005 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр бэлнээр гаргуулж авсан байна. Энэ үед л Ч.Эрдэнэ-Очирт ЭБША-ны явцад учирсан хохирол нөхөн төлөгдсөн гэж үзнэ. Түүнчлэн, У.Оргилболдын нэхэмжлэлтэй маргааны хувьд хохирол нөхөн

төлөгдсөн үйл ажиллагаа нь өмнөх маргаантай төсөөтэй бөгөөд Сангийн яамны Төрийн сангийн газраас ЭБША-ны явцад учруулсан хэмээн шүүхээс тогтоосон хохирол болох 13 597 000 төгрөгийг мөн Сангийн сайдын 2006 оны 06 өдрийн 06 дугаар тогтоолоор гаргаж шийдвэрлэжээ. Дээрх хоёр тохиолдлын хувьд Сангийн яамны Төрийн сангийн газраас ЭБША-ны явцад иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлбөрийг гаргахдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг аль болох удаашруулсан, саатуулах байдал ажиглагдаж байна.

3. Шүүхээс хохирогчоор тогтоож учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй болсон бусад иргэдийн хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар хохирол нөхөн төлөгдөх ажиллагааны шатанд явагдаж байна. Уг шийдвэрүүдэд **эдүгээ тулгамдаж буй гол бэрхшээл нь** төлбөр төлөгчийн зүгээс Ч.Эрдэнэ-Очир, У.Оргилболд нарт учирсан хохирлыг нөхөн төлүүлснээс хойших маргаанд Сангийн яамны Төрийн сангийн газрын зүгээс төлбөр төлөгч нь тус газар хариуцахгүй болохыг дурдаж байна. Жишээ нь: Т.Баярчимэгийн нэхэмжлэлтэй хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэн Сангийн яамны Төрийн сангийн газарт явуулсан албан бичгийн хариу болгож Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7 дах хэсэгт зааснаар Засгийн газрын тусгай сангаас барагдуулах боломжгүй бөгөөд Төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газарт хүсэлт тавьж шийдвэрлүүлэх буюу хохирлыг бий болгосон хүмүүст зохих хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Өөрөөр хэлбэл, өмнөх 2 иргэний хохирол нөхөн төлүүлэх маргаанд хохирол нөхөн төлүүлэлтийн асуудал эдүгээ эрх зүйн зохицуулалтын хувьд маргаантай байна.

ДҮГНЭЛТ

1. Шүүхээс энэ төрлийн маргаанд хариуцагчаар чухам (төр) хэнийг оролцуулах нь зөрчилдөөнтэй байна;
2. Шүүхээс маргаан хянан шийдвэрлэхэд хэрэглэж буй эрх зүйн зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилтэй, УДШ-ээс энэ маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдуулан гаргасан тайлбар нь хуультай зөрчилтэй утга санааг агуулсан байна;
3. Иргэд ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд хандах нь хязгаарлагдмал, эрхээ хамгаалуулах хууль

зүйн боломжийн талаарх мэдээлэл хүртээмж муутай байна. Энэ нь ЭБША-ны явцад учирсан хохирлоо нөхөн төлүүлэх хууль зүйн зохицуулалтын дагуу учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах нь хязгаарлагдмал байна;

4. ЭБШХ-ийн 44 дүгээр бүлгээр зохицуулсан зарим нэг тухайлбал ЭБШХ-ийн 394.1-т заасны дагуу “Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болон гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүх, прокурор нь иргэнд зөрчигдсөн **эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж өгөх**, түүнчлэн иргэний хүсэлтийн дагуу 1 сарын дотор өөрийн гаргасан шийдвэрийн талаар түүний ажиллаж байгаа байгууллагад **бичгээр лавлагаа өгөх үүрэгтэй**” гэж заасны дагуу хохирол нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж өгч буй практикийг судлах. Түүнчлэн, мөн хуулийн 394.2 дах “Иргэнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хуулийн байгууллага тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан **цагаатгасан тухай шийдвэрийн талаар 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй**” гэх заалтууд өнөөгийн практикт хэрэгжихгүй байгаа нь шүүгчид, өмгөөлөгчдөөс авсан судалгааны явцад тогтоогдлоо;
5. Хууль зүйн системчлэлийн хувьд иргэн учирсан хохирлоо нөхөн төлүүлэх үндэслэлийг ЭБШХ буюу процессын харилцааг зохицуулсан хуулиар зохицуулж байна;
6. Энэ төрлийн маргаан буюу ЭБША-ны явцад учирүүлсан хохирлыг арилгах маханизмын хүрээнд бодитойгоор хохирол учирүүлсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх хууль зүйн зохицуулалт одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар нарийвчлан зохицуулаагүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Онолын хүрээнд: хохирогч гэж хэн гэдгийг тодорхой болгох. Хохирогч гэдэг бол зөвхөн ЭБШЭЗ-н асуудал биш бололтой. Хэн нэгний хууль бус үйл ажиллагаа байх, үүнд ялангуяа төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа байх, нөгөө талдаа иргэний эрх зөрчигдсөн байх, үүнээс үүдэн ямар нэг хохирол үүссэн байх тухай асуудал үүнд хамаарна. Судалгаанаас харахад хохирогч бол олон янз байна: эрх бүхий байгууллагын шийдвэртэй атлаа ажилдаа эргэж орж чадахгүй байгаа төрийн албан хаагч, ЗХШ-ийн шийдвэртэй атал газраа бушааж авч чадахгүй байгаа иргэн, гэмт хэрэгт сэжиглэгдэн бөгөөд эцэст нь цагаатгагдсан иргэн зэрэг. Иймээс хохирогчийн тухай асуудал нь ЗЭЗ, ИЭЗ, ЭБШЭЗ, ИХШХШЭЗ-н гэх мэт олон эрх зүйн дунд судлагдах ойлголт болж байна. Гагцхүү хохирол гэж юуг хэлэх тухай асуудал нь хамгийн гол асуудал бөгөөд Энэ бол эрдэмтэд судлаачдын өмнө тавигдаж буй судалгааны ажил мөн.

Эрх зүйн хүрээнд: хохирогчийн эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулж буй олон төрлийн хууль тогтоомж, шийдвэрийг нэг мөр болгох. Үүнд: хууль бус үйл ажиллагаа гэж чухам юу болох (бүрэн эрхээ хэрэгжүүлсэн төрийн албан хаагчийн гаргасан алдаа, хууль зөрчсөн шийдвэр, үйл ажиллагаа гэх мэт), чухам аль тохиолдолд төр хариуцах, ер нь төр гэдгийг хэн төлөөлөх, хохирлыг хэний ямар төсвөөс гаргуулах гэх мэт олон асуудлыг нэг мөр зохицуулах шаардлага байгаа бөгөөд энэ нь тодорхойгүй байдгаас иргэд янз бүрийн байдлаар хохирсоор байна.

Хохирогч нар өөрийн зөрчигдсөн эрхээ бүрэн сэргээлгэхийн тулд шүүх, бусад байгууллагад ханддаг, түүнийг нь тухайн байгууллага аль болох түргэн хугацаанд, чирэгдэл багатайгаар шийдвэрлэж болох эрх зүйн зохицуулалттай болох. Жишээлбэл, хууль бусаар халагдсан төрийн албан хаагч аваагүй цалингаа авах гэж дахин иргэний хэргийн шүүхэд ханддагийг өөрчилж, нэг мөр шийдвэрлэдэг болох гэх мэт иргэнд ашигтай эрх зүйн зохицуулалтыг хийх бүрэн боломжтой юм.

Шүүхийн шийдвэрийг үл ойшоодог, биелүүлдэггүй, биелүүлсэн дүр үзүүлдэг төрийн байгууллагын удирдах албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг боловсронгуй болгох. Жишээлбэл, ЗХТХ-ийн холбогдох заалтыг өөрчилж, захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх тухай асуудлыг нэн даруй судалж, шийдвэрлэх ёстой гэж үзэж байна.

Практикийн хүрээнд: Хууль бус үйл ажиллагаа явуулсан төрийн албан хаагч хариуцлага хүлээдэг тогтолцоо байхгүйгээс төрийн албан хаагч нар хууль бус үйл ажиллагааг дахин дахин явуулсаар байна. Тиймээс төр иргэнд учирсан нөхөн төлсний дараа буруутай албан хаагчаас улсад учирсан хохирлыг заавал нөхөн төлүүлж, улс (төр)-ыг хохиролгүй болгох ёстой. Ийм механизм үгүйлэгдэж байгаа бөгөөд үүнд иргэний хэргийн шүүхэд төрийг төлөөлж буй прокурорын оролцоо их байж болно.

Иргэн төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхээ тэр бүр хэрэгжүүлдэггүй нь тэдний эрх зүйн ухамсар, мэдлэгтэй нь шууд холбоотой. Тиймээс энэ чиглэлээр хуулийн талаар сурталчилгаа хийх ажил зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ХОХИРСОН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Д.Энхжаргал,
Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийн хамгаалалтын байдал, тулгамдсан асуудлууд:

Судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах бодлого, эрхзүйн үндэс тавигджээ. 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай бие даасан хууль, тус хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Улсын дээд шүүхийн тогтоол 2006 тус тус батлагдан хэрэгжиж байна. 2007 оны 9 сард Засгийн газраас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөрийг батлан гаргаад байна.


Ийнхүү эрх зүйн үндэс тавигдсан ч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд өөрчлөлт ороогүй, хуулийг хэрэгжүүлэх бүтэц, механизм бүрдээгүй, мэргэжилтнүүдийн ойлголт, мэдлэг, хувийн асуудал гэж үздэг хандлага өөрчлөгдөөгүй зэргээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна. Хууль хэрэгжиж эхлээд 2 жил 10 сар болоход аюулгүй байдлаа хамгаалуулахаар шүүхэд хандсан байдал улсын хэмжээнд **19** байна.

Тус хуульд зааснаар хохирогчийг төлөөлөн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах хүсэлтийг өөрийн санаачлагаар шүүхэд гаргах үүрэг цагдаагийн ажилтанд оногдсон ч хангалтгүй хэрэгжүүлж байна. Хууль хэрэгжсэнээс хойш 2 жил гаруйн хугацаанд хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор энэ үүргээ хэрэгжүүлсэн тохиолдол улсын хэмжээнд ганцхан байна. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан 19 хэргийн тухайд тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, эрсдлийн түвшинг үнэлэх үүргээ нийгмийн ажилтан хэрэгжүүлсэн тохиолдол ганц ч алга, шүүгч ч энэ үнэлгээг шаардаагүй байна. Дээрх шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд хохирогчид нэхэмжлэл, гомдолдоо учирсан бодит болон сэтгэл санааны хохирлоо үнэлж нэхэмжилсэн тохиолдол байхгүй байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийн хэрэгжилт туйлын хангалтгүй байна. 2002 оны Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хуулийн 82.3-т "...шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлэх", 83.1-т "шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10 хүртэлх хувиар урамшуулах"-аар заасан байгаа нь үүнд нөлөөлж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн байгууллага хэдий боловч аж ахуйн тооцоотой, өөрсдийгөө санхүүжүүлэх зарчмаар үйл ажиллагаа явуулдагтай холбоотойгоор мөнгөн дүн өндөртэй хэргүүдийн биелэлтийн араас түлхүү явах сонирхол давамгайлж байгаагаас хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах гэх мэт шүүхийн шийдвэрийн араас араас хөөцөлдөх сонирхол бага байна.

Давхар хохирол амсаж буй байдал: Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай бие даасан хууль батлагдсан ч Захиргааны хариуцлагын хуулийг дангаар нь хэрэглэн арга хэмжээ авах явдал түгээмэл байна. ГБХ үйлдсэний улмаас удаа дараа баривчлагдаж байгаа хүмүүс нь нийт баривчлагдсын 20%-ийг эзэлж байна.



Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого барьдаггүйгээс гарч ирсний дараа үзүүлэх дарамтаас айсандаа баривчлагдсан хүмүүсийн 60 хувийнх нь ар гэрээс эргэлт ирдэг байна. Хүчирхийлэл үйлдэгчид баривчлах арга хэмжээ авахуулсан эмэгтэйчүүдийн 55 % нь 2-3 удаа эргэлт оруулжээ. Дунджаар 20.0-70.0 төгрөгийн зардал гаргасан байна.

ЦЕГ-ын даргын 2004 оны ... тушаалаар баривчлагдсаас хураах зардлын хэмжээг тогтоосон бөгөөд баривчлагдсан хоног, үйлчилгээний төрлөөс хамааран 8400-26900 төгрөгийг хураадаг байна. Албадан

саатуулах, баривчлах төв нь 2007 онд улсын төсвөөс 256.259.000 төгрөг, баривчлагдсан этгээдийн төлсөн төлбөрөөс 10.000.000 төгрөгөөр санхүүжиж байна. Нийт баривчлагдсан 75%-ийг нь ажилгүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд төлбөрийн ихэнх хэсгийг ар гэрээс нь төлжээ.

Хүчирхийлэл үйлдэгчийг согтуу тохиолдолд эрүүлжүүлэх байранд аваачих нь түгээмэл ч маргааш нь мөнгийг нь хохирогч төлж авах явдал нийтлэг байна. Ахуйн хүрээнд дахин эрүүлжүүлэгчид 27 орчим хувийг эзэлдэг.



Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 58/62 дугаар тушаалаар Эрүүлжүүлэх байрны үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон бөгөөд 1 хүний үндсэн төлбөр 4150 төгрөг, нэмэгдэл үйлчилгээний төлбөртэйгөө нийлээд 7900 төгрөг болдог байна.

Сүхбаатар дүүргийн эрүүлжүүлэх байранд 2006 онд 10148 хүн эрүүлжүүлэгдсэнээс 5522 хүн 22.000.000 төгрөг, 2007 оны 11 дүгээр сарын 13-ны байдлаар 6854 хүн эрүүлжүүлэгдсэнээс 4374 хүн 18.000.000 төгрөгийн төлбөр төлөөд байна. Эрүүлжүүлэгчдийн 60 орчим хувийг ажилгүйчүүд эзэлдэг, ар гэрээс нь төлбөрийн 40 орчим хувийг төлдөг байна. 2006 оноос 2007 оны 11 дүгээр сарын 13-ныг хүртэл уг дүүргийн Эрүүлжүүлэх байр нийт 40 сая төгрөгийг улсын төсөвт оруулсны 40 хувь буюу 16 сая төгрөгийг ар гэрээс нь төлжээ. Ийнхүү гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хуулийн байгууллагад хандсанахаа төлөө эдийн засгийн хувьд давхар хохирол амсдаг байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатан дахь хохирол барагдуулалтын байдал:

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй гэсэн заалтыг үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлүүдэд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах хандлага түгээмэл байна. Энэ тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирлоо барагдуулах, нөхөн төлүүлэх асуудал боломжгүй болж байна. Сүхбаатар дүүргийн Прокурорын газраас 2006 он, 2007 оны эхний хагас жилд Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн 99.1 дэх хэсэг /Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах/-т заасан нийт **35** эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Тогтоолд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэм хорын хохирлыг нэхэмжилсэн, үнэлсэн, нөхөн төлүүлсэн байдлыг дурьдаагүй байна. Эрүүгийн хэрэг бус хэмээн хэргийг хэрэгсэхгүй болгосон ч хохирогчийн эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэр бүлийн хүчирхийлэлд тооцож, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг авахуулахаар хэргийг хэрэгсэхгүй болгосон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар шүүхэд хүсэлт гаргах үүрэгтэй ч ийм практик тогтоогүй байна.

ЭБШХ-д “Хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураар эвлэрсэн бөгөөд **учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан** бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно” гэж заасан боловч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай, нэг дор амьдардаг, хүчирхийлэл, заналхийлэлд өртөх үед хуулийн хамгаалалт авах боломж хязгаарлагдмал байдаг зэргээс албадлага, дарамтын дор эвлэрч, хохирол нөхөн төлүүлэх тухай зүйл, заалт тэр бүр хэрэгжих боломжгүй байна.

Сүхбаатар дүүргийн шүүхээр 2006 онд гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн энэ төрлийн **2** хэргийг шийдвэрлэсэн бол 2007 онд нэг ч хэрэг шийдэгдээгүй байна. Шүүхээр шийдвэрлэсэн 2 хэргийн хохирогчид хохирол, төлбөр нэхэмжлээгүй, шүүхээс гэм хорын хохирол гаргуулаагүй байна.

Зөрчил гаргагч болон гэмт этгээдтэй гэрлэсэн буюу гэр бүлийн харилцаатай эсэх нь хохирогчийн статусыг бууруулах ёсгүй байтал ийнхүү иргэний, захиргааны, эрүүгийн гэх мэт бүх шатанд хохирогчийг

хамгаалах үр дүнтэй хамгаалалтыг авч чадахгүй байгаагаас эмэгтэйчүүд хувийн журмаар асуудлыг шийдвэрлэх гэж оролдох, гэр бүлийн хүчирхийллийг зогсоох хариу арга хэмжээ авахдаа гэмт үйлдлийг сонгож байгаа тохиолдлууд нэмэгдэж байна. 2007 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 281 эмэгтэй хорих ял эдэлж байгаагаас 29 эмэгтэй гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэгтэй ял эдэлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийг зүйлчлэлээр авч үзвэл, тэдний 86 хувь нь “Бусдыг санаатай алах” гэмт хэрэг үйлдэн 10-15 жилийн хорих ялаар шийтгэгдсэн байна. Өөрийнх нь эсрэг биеийн хүч хэрэглэж, эсхүл хэрэглэхийг завдаж байгаад итгэж, өөрийгөө болон гуравдагч хүнийг хамгаалахын тулд халдагчийн эсрэг хүч хэрэглэсэн тохиолдлыг аргагүй хамгаалалт гэж үзэх, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал байгаа эсэхийг нухаштай нягтлах шаардлагатай байна. Эндээс үзэхэд манай ЭБША-ны практикт эд мөрийн баримт, мөр гэх мэт нүдэнд харагдах биет зүйлүүдэд шинжилгээ хийгддэг хэрнээ сэтгэлзүйн байдалд үнэлгээ дүгнэлт өгөгддөггүй, зөвхөн хэрэг хариуцах чадвартай эсэхийг л шинжилдэг дүр зураг харагдаж байна. Дарамтад олон жил өртсөний улмаас эцэст нь хэрэгт холбогдогч болон хувирсан тэрхүү жинхэнэ хохирогч өөрөө аюулыг хэрхэн дүгнэж байна вэ гэдэгт онцгой анхаарал хандуулах ёстой байтал хайхардаггүй байна. Байнгын хүчирхийлэл, дарамтад байсан тэрхүү хохирогчийг сэтгэл мэдрэлийн хувьд эрүүл мөн эсэх дээр нь анхаарал төвлөрөхгүй, тэр хохирогч юуг туулсан, хүчирхийлэл үйлдэгч юу хийснийг олж харахыг хичээх нь хүчирхийллийн үр дагавар түүнд хэрхэн туссан дүр зургийг гаргаж ирэхэд ач холбогдолтой хэмээн үздэг олон улсын туршлагыг энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд нэвтрүүлэх шаардлагатай.

Хүчингийн гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалтын байдал, тулгамдсан асуудлууд:

Хүчингийн гэмт хэрэг нь зөвхөн бэлгийн эрх, эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бус хүний бие эрхтэн, сэтгэл санаа, эрүүл мэндийн бүрэн бүтэн байдал, нэр төр, өөрийнхөө биеийг өөрөө мэдэх эрхийг зөрчиж байгаа гэмт хэрэг байтал Эрүүгийн хуульд энэ агуулга, үндсэн шинжийг нь гажуудуулан бүрэн бусаар тодорхойлсон нь энэ төрлийн хэргийг зөв тогтоох, хохирлыг бүрэн тооцох, барагдуулах асуудлыг зохицуулах боломжийг хуулиар үгүйсгэхэд хүрсэн байна.

Зөвхөн бие эрхтэн, эд зүйлд учирсан хохирлоор хязгаарласнаар сэтгэл санаа, нэр төр гутаагдах, гэмт хэргийн улмаас учирсан шууд бус хохирлыг тооцох, барагдуулах боломжгүй байна. .

Түүнчлэн, хүчингийн гэмт хэргийг зөвхөн хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр айлган сүрдүүлэх, биеэ хамгаалж чадахгүй байдлыг ашиглах гэх мэтээр явцуу тодорхойлсноос итгэл эвдэх, хууран мэхлэх, ямар нэг хэлбэрээр эрхшээлдээ байгааг ашиглан тулган хавчих замаар хүчингийн гэмт хэрэг үйлдсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй өнгөрч байна. Үүнээс шалтгаалан болзооны хүчин, гэрлэгсдийн хүчин гэх мэт хүчингийн бусад төрлийн хохирогчид хуулийн хамгаалалтаас гадуур оршиж байна.



Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдсан хэргүүдийн статистикаас үзэхэд дийлэнх хувийг гэр бүлийн гишүүн, төрөл төрөгсдийн зүгээс үйлдэгдсэн хүчингийн хэрэг эзэлж байна. Улсын мөрдөн байцаах газрын 2006 он, 2007 оны эхний хагас жилийн статистикаас үзэхэд нийт 50 хэрэг мөрдөн байцаах ажиллагаа хийгдсэнээс 56 хувь нь гэр бүлийн хэн нэгэн гишүүний зүгээс үйлдэгдсэн байна. Үүний 20 хувь нь 1-5 жил хүртэлх хугацаанд удаа дараагийн үйлдэл байна. Гэвч эдгээр 50 хэргийн 46 хувьд нь эмчилгээний зардлын багахан хувь нь мөрдөн байцаалтын шатанд барагджээ. Сэтгэл санааны хохирлыг тооцож барагдуулсан тохиолдол байхгүй байна. Хэргийг хэрэгсэхгүй болгох саналаар прокурорт шилжүүлсэн хэрэг дээрх 50 хэргийн 28 хувийг эзэлж байна.

Хэдийгээр 2002 онд Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдсан ч хүчингийн гэмт хэргийн зохицуулалт нь өмнөх Эрүүгийн хуультай адил

хуульчлагдсанаас хуулийн байгууллагын ажилтнууд 1998 оны Улсын дээд шүүхийн тогтоолын дагуу хүчингийн гэмт хэргийг тайлбарласан тайлбарын агуулга, зарчмаар өнөөг хүртэл энэ төрлийн хэргийг шийдвэрлэсээр байгаа нь олон хүндрэлийг хохирогчид авчирч байна. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэргийг дур тачаалтай холбон үздэгээс хэргийг нотлох гол шалгуурыг хохирогчийн зүгээс эсэргүүцэл үзүүлсэн болон зөвшөөрсөн байдал, хэрэг үйлдэгч, хохирогчийн өмнө хойшдын харилцаа зэргийг онцгойлон анхаарч, хохирогчийн хувийн амьдрал руу хэт өнгийн, бэлгийн амьдралын түүхийг сөхөх, хурьцлын улмаас бие махбодид учирсан гэмтэл эсхүл үрийн шингэн гэсэн явцуу хүрээнд, цөөн хэдэн материалаг нотолгооны зүйлд анхаарал хандуулан нотолдог хуучинсаг арга барилаар ажилласаар байна. Энэ нь хохирогчид үл итгэх улмаар хохирогчийг буруутгах хандлагыг бий болгодог байна.

Хүн худалдах гэмт хэргийн хохирогчийн эрхийн хамгаалалтын байдал, тулгамдсан асуудлууд:

ЦЕГ-аас авсан мэдээгээр 2006 онд хүн худалдах 6 хэрэг, 2007 оны эхний хагас жилийн байдлаар 2 хэрэг дээр мөрдөн байцаах ажиллагаа хийгдсэн байна. 2006-2007 онуудад энэ асуудлаар шүүхээр шийдсэн хэрэг 2 байна.

Хэдийгээр энэ төрлийн хэрэг манай улсад тотмол өсч байгаа ч одоогоор энэ чиглэлээр манай улсад хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа дэмжлэг үзүүлэх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин болоод ямар нэг механизм байхгүй байна. Монгол Улсад 2005 онд хүн худалдаалах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр батлагдан гарсан ч хэрэгжүүлэх тал дээр төрөөс явуулж байгаа арга хэмжээ удаашралтай байна.

Монгол Улсад шийдэгдэж байгаа хүн худалдах гэмт хэргийн хохирогчийн хохирлоо арилгах, төлүүлэх практикийг үзэхэд хохирогч эмэгтэйчүүд хохирлоо төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байна. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч нь бусад хэргийн хохирогчийг бодвол онцлогтой байдаг. Энэ нь тухайн хохирогч хилийн чанадад эрх чөлөөгүй хүний эрхэнд, хүнд дарамтад амьдарч, ажиллах үедээ бие, эрүүл мэндэд хохирол учирсан ч Монгол Улсад ирээд хэргээ шийдүүлэх тэр үед түүний биед учирсан гэмтэл, өвчин эдгэрч гэмтлийн зэрэг тогтоогдох боломжгүй байдал үүсдэг. Гэмтлийн зэрэг тогтоогдохгүй, бие эрүүл мэндэд авсан

хор хохирол анх гэмтэл авсан үеэсээ цаг хугацаа, эмчилгээний явцад эдгэрсэн байдаг нь хохирогчийг бие, эрүүл мэндэд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах бололцоогүй болгодог. Учир нь манай улсын шүүхийн практикт хохирогчийн гэмтлийн зэрэг нь тогтоогдоогүй, эмчилгээний зардал гаргасан нь тогтоогдоогүй, сэжигтэн, яллагдагч нь тогтоогдоогүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгодог. Иймээс дээрх хууль эрх зүйн орчны зохицуулалт байхгүйгээс болж хохирогч сэтгэл санааны болон бие, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргалаа ч шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож нөхөн төлбөр авч чаддаггүй байна. Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид сэтгэл санааны гүн дарамт хямралд орохоос гадна, эрүүл мэндийн хувьд маш ихээр хохирсон байх нь элбэг байна. Гэтэл энэхүү сэтгэл санааны хохирлыг төлүүлэх, барагдуулах эрх зүйн орчин хангалтгүй байна.

Дүгнэлт:

1. Үндэсний хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээ, стандартад нийцүүлэх ажил хангалтгүй. Монгол Улсын олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил байх тухай Үндсэн хуулийн 10.3 дахь хэсэгт заасан ч шүүхийн практикт хэрэглэж байгаа тохиолдол байхгүй байгаа нь хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд эрхээ хамгаалуулах хангалттай баталгааг бий болгож чадахгүй байна. Түүнчлэн, зарим чухал шаардлагатай олон улсын хэм хэмжээ тухайлбал, ХХГХ-ийн асуудлаар олон улсын хэм хэмжээ болсон Палермогийн протоколд нэгдээгүй байна.
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр /2007/, Хүн ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр /2005/ зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах асуудал бодлогын хүрээнд нарийвчлан тусгагдах эхлэл тавигдсан ч хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын төсөвт тусгайлан тусгадаггүйгээс хэрэгжилт нь хангалтгүй байна.
3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс хохирогчдыг хамгаалах талаар эрхзүйн орчин цогцоор бүрдээгүй, хуулийг хэрэгжүүлэх бүтэц, механизм хангалттай тусгагдаагүй, хуулийг хэрэгжүүлэх

мэргэжилтнүүдийн чадавхи сул байна. Тухайлбал, өвөрмөц онцлог бүхий Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар тусдаа хуульгүй байгаагаас олон асуудал түүний дотор хохирогчийг хамгаалах, хохирлыг төлөх, барагдуулах зэрэг нь тулгамдсан шинжтэй асуудал болоод байна.

4. Хуулийн практикт хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хүний эрхийг зөрчих, үгүйсгэх, ялгаварлан гадуурхах явдал түгээмэл байна. Энэ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх нарийвчилсан удирдамж, заавар, стандарт байдаггүйтэй холбоотой байна.
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид учирсан амь нас, эд хөрөнгө, бие эрхтэн, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, барагдуулах, нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх талаар хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгүүдэд хангалттай тусгагдсан ч хохирлын тухай ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүйгээс амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг үнэлж, нөхөн төлүүлсэн практик байхгүй байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрхзүйн цогц орчин бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын 2008 оны хаврын чуулганд өргөн барих арга хэмжээг цаг алдалгүй эхлэх;
2. 2002 оны Эрүүгийн шинэ хуулиар хохирогчийн биед ямар нэгэн гэмтэл учраагүй бол гэмт хэрэг гэж үзэхгүй болсноор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхзүйн байдлыг илт дордуулсан байгааг харгалзан “гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэх” гэсэн зүйл, хэсэг нэмж оруулах;
3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц болон түүний нэмэлт болох хүн худалдаалах, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол, мөн цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай конвенцид нэгдэн орох асуудлыг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэх;

4. Хүн худалдах гэмт хэргийн талаар бие даасан хуультай болох хүртэл Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл ангийг өөрчлөн сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах буюу бие даасан хуультай болох хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтыг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбар гаргах;
5. Хүчингийн гэмт хэргийг шийдвэрлэх, хохирогчийн хохирлыг барагдуулахын тулд уг гэмт хэргийн сэдэл, зорилгыг зөв томъёолж, олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох шаардлагатай. Хүчингийн гэмт хэргийг итгэл эвдэх, хуурч мэхлэх болон эрхшээлдээ байгаа байдлыг ашиглан үйлдэж болохыг хуулиар хүлээн зөвшөөрч хүчингийн гэмт хэргийн онцлог хэлбэрүүд болох “ураг төрлийн хүчин”, “гэрлэгсдийн хүчин”, “болзооны хүчин”, “бэлгийн халдлага ба түүний төрлүүд” зэргийг бие даасан хэлбэрээр тусгайлан хуульчлах;
6. Хүний амь нас, сэтгэл санааны хохирлыг үнэлэх аргачлалыг тодорхой болгож, нөхөн төлүүлэх талаар холбогдох хуулиудад зүйл, заалтуудыг оруулж өгөх, Иргэний хуульд эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр алдар хүндэд учирсан хохирлыг арилгахаар заасныг өөрчилж сэтгэл санааны бусад хохирлууд болох сэтгэцийн эрүүл мэндэд учирсан хохирлууд, мөн сэтгэлийн дарамт, гутрал зэргийг тооцон үнэлж барагдуулах талаар нэмж оруулах болон сэтгэл санааны хохирлын зэргийг сэтгэл судлалын мэргэшсэн байгууллага тогтоож мөрдөн байцаалтын шатанд үнэлж эхлэх;
7. Эрүүгийн хуульд “хохирол” гэдгийг тусгайлан зааж өгөх, мөн шууд болон шууд бус хохирлуудыг оруулан тодорхойлох. Тухайлбал, гэмт хэргийн улмаас бий болсон бие эрхтний гэмтлийг нөхөн сэргээх зардал, сэтгэл санааны хохирол, сэтгэцийн хэвийн байдлыг сэргээх үйлчилгээний зардал, түүнчлэн тухайн гэмт хэргийн улмаас оршин суух газраа болон эрхэлдэг ажлаа сольсны зардал, оршуулгын зардал, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүл, төрөл садан хийгээд санхүүгийн хувьд хараат байсан этгээдийн алдсан орлого, асрамж халамж гэх мэт/, уг хохирлыг хэрхэн тооцож үнэлж барагдуулах талаар тусгайлсан заалт оруулах;

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.3 дахь хэсэгт заасны дагуу “...шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлэх” болон 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10 хүртэлх хувиар урамшуулна” гэсэн зохицуулалтууд нь шийдвэр гүйцэтгэгчдийг мөнгөн дүн өндөртэй хэрэг дээр л шийдвэр гүйцэтгэл хийхээр ажилладаг буруу практикийг тогтоож, гэмт хэргийн хохирогч, төлбөрийн чадваргүй иргэний нэхэмжлэгчдэд дарамт болж, давхар хохироож байгааг харгалзан дээрх хоёр зүйл, хэсгийг хүчингүй болгох.

Хуулийг нэг мөр хэрэгжүүлэх хүрээнд:

1. Шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон ЭБШ хуультай холбогдуулан өмнөх хуулийг тайлбарласан тайлбаруудыг хүчингүй болгон шинэ тайлбар батлан хэрэгжүүлэх;
2. Дээрх хуулиудад заагдсан хохирол барагдуулахтай холбоотой заалтууд болон эдийн бус хохирол гэдэгт юуг ойлгох, хэрхэн үнэлж барагдуулах талаар нэг бүрчлэн тайлбарлаж, зөвхөн материаллаг хохирлыг бус сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцож үнэлж барагдуулах талаар шүүхийн зөв практик тогтоох;
3. Хүн худалдах гэмт хэргийн асуудлаар бие даасан хуультай болох хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтыг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбар гаргах.

Зохион байгуулалтын хүрээнд:

1. Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7, 8 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3-ын “А” заалтуудыг үндэслэн зэрэг төрийн байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг жил бүр гэрээ байгуулах замаар ТББ-аар гүйцэтгүүлэн, гүйцэтгэлийг дүгнэн ажиллаж байхыг НХХЯ-ны сайдад даалгах;

2. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан хамгаалах байрны сүлжээг нийслэлийн дүүрэг, аймгийн төв, томоохон хот суурин газарт байгуулах, түүний үйлчилгээг өргөжүүлэх, нийгмийн ажлын ба сэтгэлзүй, эрхзүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад оруулах замаар хэрэгжүүлж ажиллахыг Жендэрийн тэгш байдлын үндэсний хорооны ажлын алба болон Сангийн сайд, Нийгмийн хамгаалах, хөдөлмөрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах;
3. Шүүхийн нэмэлт хүч, ажиллах цагийг хуваарилах болон баривчлах гм шүүгчийн яаралтай зөвшөөрөл өгөх зохицуулалтуудыг нэгтгэн зөвшөөрлийн шүүгч ажиллуулах замаар хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шүүхийн шийдвэрийг хохирогчийн амь нас, эрүүл мэндийг нэн даруй хамгаалах зорилгоор 24 цагийн дотор гаргах нөхцлийг бүрдүүлэх ажлыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороотой хамтран Улсын дээд шүүхээс 2008 онд багтаан хэрэгжүүлэх;
4. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг 24 цагийн дотор хязгаарлах арга хэмжээ авсан шүүхийн шийтгэврийн биелэлтийг цагдаагийн байгууллагад даалгах, үүнээс урт хугацааны дотор хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах арга хэмжээ авсан шүүхийн шийтгэврийн биелэлтийг харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадад хариуцуулах; гүйцэтгэх хуудас бичиж хэвшүүлэх;
5. Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг дээр ажиллах чиглэлийн ахлах байцаагчийг аймаг, дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд, хүчингийн хэргийг дагнан шалгадаг эмэгтэй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийг цагдаагийн бие бүрэлдэхүүнд бий болгох;
6. Хүчирхийлэлд өртсөн хохирогчоос ганцаарчлан мэдүүлэг авах, тэдэнд мэдээлэл өгөх тусгай өрөөг цагдаагийн хэлтсүүд бага насны хохирогчтой хүчингийн хэрэг шалгадаг УМБГ-ын 2 дугаар хэлтэст олон улсын жишгийг баримтлан, зохих стандартын дагуу байгуулан ажиллуулах;

7. Хүчингийн болон эмзэг хохирогчтой харьцах, тэдний нууцыг хадгалах, аюулгүй байдлыг хангах тусгай журам батлан мөрдүүлэх, энэ чиглэлээр хуулийн байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэмд тусгай заалт оруулах;
8. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх аюулгүй байдлын болон нууцлалын тогтолцоог бүрдүүлэх, гомдол гаргагчдыг хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс гарч буй болзошгүй хонзогнолын үйлдлээс хамгаалах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;
9. Алслагдсан дүүрэг, хороодод ажиллаж байгаа цагдаагийн ажилтнууд нь хүчирхийллийн дуудлага аваад очих боломж, хүн хүчний хүрэлцээ муутай байгааг харгалзан унаа, боловсон хүчин, техникийн асуудлыг шийдвэрлэх;
10. Цагдаагийн байгууллагын дүн бүртгэлд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх асуулга оруулж, сар, улирал тутмын мэдээнд тусгаж өгч байх.

Хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “ХОХИРОГЧИЙН ЭРХИЙН БАТАЛГАА” СЭДЭВТ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Хүний эрхийн олон улсын өдрийг угтаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хохирогчийн эрхийн баталгаа” сэдэвт үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс хамтран 2007 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулав. Тус чуулганд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд, эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын 800 гаруй төлөөлөгчид оролцов.

Үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч Пратиба Мехта нар үг хэлж, “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”, “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирогчийн эрхийг хангаж буй байдал, сайжруулах арга зам”, “Гэмт хэргийн болон захиргааны хууль бус ажиллагаанаас учирсан хохирлын нөхөн төлөлтийн өнөөгийн байдал, анхаарах асуудал”, “Хохирогчийн эрхийн талаарх олон улсын стандарт ба үндэсний хууль тогтоомж” зэрэг илтгэлүүдийг хэлэлцүүлэв.

Энэ удаагийн Чуулганаар гэмт хэрэг, хүчирхийлэл, төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон хохирогчдын асуудлыг тухайлан авч үзэж, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдал, хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчийн эрхийн хэрэгжилт зэрэг сэдвээр хийсэн судалгааны тайлангуудыг танилцуулав. Чуулганд оролцогчид хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар олон чухал санал дэвшүүлэв.

Гэмт хэргийн болон захиргааны хууль бус ажиллагаанаас хохирсон иргэдийн эрхийг хангах, хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх хууль тогтоомжийг улам боловсронгуй, хохирогчийн эрхийн тухай хууль гаргах, байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирогчийн эрхийг хангах,

хамгаалах ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх бодит биелэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд Улсын Их Хурал, Засгийн газар, хуулийн байгууллагууд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг чуулганд оролцогсод санал нэгтэй хүлээн зөвшөөрч, чуулганаас дараах зөвлөмжийг гаргав.

Нэг. Монгол Улсын Их Хурал

1.1. Хохирогчийн эрхийн талаар тусгасан Монгол Улсын Олон улсын гэрээнүүдэд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг зохион байгуулж нэг мөр шийдвэрлэх,

1.2. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний хохирлын зохих хэсгийг төрөөс хариуцах, төрийн байгууллага, албан тушаалтны хууль биелүүлээгүй, хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас бүлэг хүмүүст учруулсан хохирол, гэм буруутай этгээд нь төлбөрийн чадваргүй, эсхүл хариуцагч нь тогтоогдоогүй тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх тухай хууль баталж мөрдүүлэх,

1.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан заалтуудыг нэмж тусгах,

1.4. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний аюулгүй байдлыг хангах, хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор хууль баталж мөрдүүлэх,

1.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах үүднээс Гэр бүлийн тухай, Иргэний хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах,

1.6. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар салбар зөвлөлийг орон тооны болгох, Төрийн нарийн бичгийн дарга, Тамгын газрын дарга нар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн дарга байдаг тогтолцоог өөрчлөх,

1.7. Албан тушаалтны хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгодог эрхийг Төрийн албаны зөвлөлд олгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргадаг эрхийг Төрийн албаны зөвлөлд олгох,

1.8. Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүний эрх зөрчсөн тухай гомдлыг шийдвэрлэхэд комиссын оролцоо, эрх хэмжээг нэмэгдүүлэх.

Хоёр. Засгийн газарт

2.1. Гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, нэгэнт хохирсон тохиолдолд эрхээ сэргээлгэх эрх зүйн боломж, баталгааны талаар сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг нийтэд хүртээмжтэй, үр өгөөжтэй хэлбэрээр байнга зохион байгуулах,

2.2. Энэ ажилд эрх зүйн сургалт, судалгааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, иргэдийг өргөнөөр оролцуулах,

2.3. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг бодитой тооцох үнэлгээний нэгдсэн аргачлал, үнэлгээ хийх журмыг боловсруулж улсын хэмжээнд мөрдүүлэх,

2.4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах байрны сүлжээг холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран байгуулж, түүний үйлчилгээг сэтгэл зүй, эмчилгээ, эрх зүйн цогцолбор хэлбэрээр зохион байгуулж ажиллуулах, хохирогчдод эрх зүй, эмнэлгийн болон бусад тусалцаа үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг нийслэл, аймгуудад байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимтэй зохион байгуулах, энэ талаар жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх,

2.5. Төрийн албан хаагч хууль бусаар ажлаасаа халагдах, чөлөөлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн зөрчил гарган бусдыг хохироосон албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх, хууль бусаар халагдсан буюу чөлөөлөгдсөн албан хаагчийн эрхийг сэргээн эдлүүлэхэд хяналт тавьж, ялангуяа энэ талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг шуурхай хангах нөхцлийг бүрдүүлэх,

2.6. Хохирогчийн хохирол нөхөн төлөгдөх томоохон эх сурвалж нь хоригдлын хөдөлмөр эрхлэлт гэдгийг анхааралдаа авч нийт хоригдлуудын хөдөлмөрийн нөөц боломжийг тооцон, тэднийг хөдөлмөрийн зах зээлээр хангах, ажлын хөлсийг бодитой тогтоох талаар шаардлагатай арга хэмжээг авч энэ талаар тулгамдаж байгаа асуудлуудыг судлан шийдвэрлэх,

2.7. Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрт тусгасан бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хангах талаар хуулийн төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх, урьдчилан сэргийлэх болон тухайн улсад эрх нь зөрчигдөж хохирсон иргэдийн эрхийг хамгаалах боломжийг судалж шийдвэрлэх,

2.8. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг боловсруулж, хэрэгжүүлэх,

2.1. Хууль зүй, дотоод хэргийн яаманд

2.1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд гэмт хэргийн хохирогчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, тэдгээрийн эрхийг сэргээж буй байдалд хяналт тавьж холбогдох арга хэмжээ авдаг тогтолцоог бүрдүүлэх,

2.1.2. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.3.4-т “Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх,

2.1.3. Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хохирогчийн эрхийг хамгаалах, хөндөгдсөн эрхийг нь нөхөн сэргээх талаар хийж байгаа ажлыг тэдгээр байгууллагын ажлын үр дүнг үнэлэх шалгуурт оруулж дүгнэдэг болох,

2.1.4. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан албадан сургалтын хөтөлбөрийг боловсруулж тэдний зан үйлд нөлөөлөхүйц үр дүнтэй хэлбэрээр уг сургалтыг зохион байгуулах,

2.2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд

2.2.1. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн эрэлт хэрэгцээг хангах, хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг шинэчлэх арга хэмжээ авах,

2.2.2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хоригдлын хөдөлмөрийг үнэлэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримталдаг болох арга хэмжээ авах,

2.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд

2.3.1. Хохирогчийн эрхийг хангах, хамгаалах, сэргээн эдлүүлэх, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, судалгаа явуулах иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих,

2.3.2. Хохирогч судлалын/виктимологи/ шинжлэх ухааныг эх орондоо хөгжүүлэхэд анхаарал хандуулж энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхийг дэмжин, гэмт явдал судлалын хичээлийн хөтөлбөрт хохирогч судлал тодорхой байр суурьтай байхаар тусгах,

2.3.3. Сургуулийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийг арилгахын тулд хохирогчийн нэр төр, аюулгүй байдал, язгуур эрх ашигт

хүндэтгэлтэй хандаж, хамгааах үүргийг багш, сургуулийн удирдлага хүлээх, хохирогчид дахин халдах нөхцлийг бүрдүүлэхгүй байх талаар арга хэмжээ авах,

2.3.4. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийн язгуур эрх ашгийг дээдэлсэн мэдээ, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэн нэвтрүүлэх,

2.4. Эрүүл мэндийн яаманд

2.4.1. Гэмт хэргийн хохирогчид эмнэлгийн анхан шатны үзлэг, тусламжийг үнэ төлбөргүй, шуурхай үзүүлдэг журмыг эмнэлгийн бүх шатны байгууллагуудад тогтоон хэвшүүлэх,

2.5. Гадаад хэргийн яаманд

2.5.1. Хилийн чанадад иргэд хохирохоос урьдчилан сэргийлэх үүднээс гадаадад байгаа иргэдийн амьдрах, зорчих, хөдөлмөрлөх, суралцах болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын нөхцлийг сайжруулах арга хэмжээг тогтмол авах,

2.5.2. Хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд олноор байгаа улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэх, хүн наймаалах, хар тамхи худалдах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх гэрээ хэлэлцээр нэмж болон шинээр байгуулах,

2.5.3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан байгуулах,

2.5.4. Ямар нэг байдлаар хохирогч болсон, ялангуяа хүний наймааны хохирогч болсон иргэдийг хамгаалах шаардлагатай бол эх оронд нь авчрах талаар бусад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах,

2.5.5. Иргэдийн эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Консулын албыг бэхжүүлж, үйл ажиллагааг нь нээлттэй, шуурхай, үр өгөөжтэй болгох,

2.5.6. Иргэдийн эрх ашгийг хамгаалах талаар дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагууд, тухайлбал хүний эрх, өмгөөллийн байгууллагуудтай хамтран ажиллах,

2.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад

2.6.1. Эрүүгийн хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар гарсан шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл хангалтгүй байгаад анхаарал хандуулж, нэгэнт гарсан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангах талаар тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх,

2.6.2. Хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар цогц арга хэмжээг төлөвлөн Засгийн газарт санал оруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хохирогчийн хохирол аль болох шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх,

2.6.3. Гэмт хэргийн хохирогч болон гэм буруутай этгээдийн хооронд үүссэн сэтгэл зүйн зөрчил арилахгүй байгаа нь цаашид нийгэмд үзэн ядалт үргэлжлэх нөхцөл болдгийг анхаарч зарим орны туршлагаар хоригдлыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд тэрхүү зөрчлийг арилгах, зөөлрүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх,

2.6.4. Хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэхэд төлбөрийн их багын хэмжээнээс шийдвэр гүйцэтгэгч нарын ашиг сонирхол хамаардаггүй байх, шийдвэр гүйцэтгэл алагчлалгүй, жигд, шударга явагдах нөхцлийг бүрдүүлж ажиллах,

2.6.5. Хадгаламж зээлийн хоршоодын хэргийн хохирогчдын хохирлыг нөхөн олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай авч хэрэгжүүлэх,

2.7. Цагдаагийн байгууллагад

2.7.1. Олон нийтийг хохироож болзошгүй аливаа хэлбэрийн хууль бус үйлдлийг тухай бүр илрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,

2.7.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, яллагдагчийн өмч хөрөнгийг илрүүлэн тогтоож, хохирогчийн хохирол нөхөн төлөгдөхөд хүрэлцэхүйц хэмжээнд битүүмжлэн хамгаалах ажиллагааг цаг алдалгүй, шуурхай, чанартай гүйцэтгэх явдлыг мөрдлөг болгох,

2.7.3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, тэдний эрэлт хүсэлтэд анхааралтай хандаж, хөнгөн шуурхай шийдвэрлэх, тэдэнд хүнлэг хандаж харьцах талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт тусгайлсан хөтөлбөрөөр сургалт явуулж үр дүнг тооцох,

2.7.4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхэд санаачилга гарган оролцох,

2.7.5. Гэмт хэргийн бүртгэлд хохирогчийн талаарх шаардлагатай мэдээлүүдийг багтааж мэдээ, тайланд тусган хохирогчид учирсан хохирол, түүнийг нөхөн төлөх нөхцлийг бүрдүүлэх талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хийсэн ажиллагаа, нөхөн төлүүлэх талаар авсан арга хэмжээнд бүртгэлээр хяналт тавьж, хариуцлага тооцож ажилладаг болох,

2.7.6. Хүчирхийлэл болон гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүний эрхийг хангах, тэднийг хамгаалах, эрх зүйн туслахаа үзүүлэх, тэдэнтэй нас, сэтгэхүйн онцлогт нь тохирсон байдлаар харьцахад онцгойлон анхаарч, энэ чиглэлээр цагдаагийн ажилтнуудын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байх,

Гурав. Шүүхийн байгууллагад

3.1. Гэмт хэргийг шүүн таслахдаа хохирогчийн эдийн болон эдийн бус хохирол бодит байдал дээр нөхөн төлөгдөх, гэм хорыг арилгах бүх талын боломжийг авч үзэж, хохирлын хэмжээг бүрэн дүүрэн тогтоож, нөхөн төлөгдөх хэлбэрийг шүүхийн тогтоолд нарийвчлан тусгах асуудалд онцгой анхаарах,

3.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг зохистой шийдвэрлэж, хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээх, баталгааг бүрдүүлэх сэдвийг бүх шатны шүүгчдийн сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх, ялангуяа эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх арга зүйг нэвтрүүлэн хэвшүүлэх,

3.3. Шүүх хуралдаанд хохирогчийн оролцоог бүрэн хангаж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн эрхийг баталгаатай эдлүүлэх, мөн хохирогчийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс шаардлагатай тохиолдолд хохирогчийг шүүх хуралдаанд шууд бусаар оролцуулах боломжийг судалж шийдвэрлэх,

Дөрөв. Прокурорын байгууллагад

4.1. Прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн хууль бус ажиллагаанаас хүн хохирох явдал таслан зогсоогдохгүй байгааг анхааралдаа авч энэ чиглэлээр тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авч тодорхой үр дүн гаргах,

4.2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад сэжигтэн, яллагдагчаас гадна хохирогчийн эрх хэрхэн хангагдаж байгаад тавих хяналтыг чангатгаж, хохирогчийн талаарх зайлшгүй мэдээллүүдийг гэмт хэргийн бүртгэлд хамруулан бүртгэлээр хяналт тавьдаг тогтолцоонд шилжих,

4.3. Холбогдох байгууллагуудтай хамтран хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд мэргэжлийн талаас оролцож идэвхтэй дэмжлэг үзүүлэх,

4.4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хохирогчийн хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгийг илрүүлэн

битүүмжлэх бололцоотой бүх арга хэмжээг авч чадсан эсэхэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх,

4.5. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүний дотор хохирогчийн эрх чөлөөг зөрчиж байгаа аливаа илрэлүүдийг таслан зогсоохын тулд дотоодын хяналт, албаны шалгалтыг үр дүнтэй явуулж, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийн шалтгааныг заавал тогтоож, холбогдох арга хэмжээ авдаг байх явдлыг хэвшүүлэх,

Тав. Төрийн албаны зөвлөлд

5.1. Төрийн албанаас хууль бусаар халагдсан, чөлөөлөгдсөн талаар гарсан шүүхийн шийдвэр болон тухайн байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянаж, буруутай албан тушаалтанд хариуцлага оногдуулж, хохирсон хүний эрхийг бүрэн сэргээх талаарх хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх,

5.2. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар гомдол, санал их гарч байгааг анхаарч бүх шатанд гарч байгаа шийдвэр шударга, хууль ёсны байх нөхцлийг бүрдүүлэх,

5.3. Сахилгын зөрчлийг шалгах, хариуцлага хүлээлгэх, гомдол гаргах журмыг нэг мөр мөрдөж ажиллах явдлыг төрийн албаны хэмжээнд хэвшүүлэх,

Зургаа. Монголын өмгөөлөгчдийн холбоонд

6.1. Өмгөөлөгчдийн эрх зүйн туслалцааны үр нөлөөг хүртээмжтэй, чанартай, шуурхай болгоход өмгөөлөгчдийн ажлыг чиглүүлж, тэдний ажлыг дүгнэхдээ энэ чиглэлийг онцгой анхаарч, өмгөөлөгчдөд зориулсан сургалт, ажлын чиг үүрэгт нь гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх, мэргэшүүлэх, арга хэмжээг авч ажиллуулах,

6.2. Өмгөөллийн ажлын үр дүнг тооцох үзүүлэлтэд хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх шалгуурыг багтаах, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, ялангуяа авто осол, хүний амь ба эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогчийг өмгөөлж буй өмгөөлөгчтэй шүүгдэгчийн өмгөөлөгч мэргэжлийн болон хууль зүйн хүрээнд зөвшилцөх, хохирлыг нөхөн төлүүлэхэд хамтран ажиллах зэргээр шинэ хэлбэр, санаачилгыг гаргах, өмгөөллийн ажлын үр дүнг тооцох аргачлалд оруулах, шүүхийн статистик мэдээнд энэ талаарх тоо, судалгааг оруулж, хууль сахиулах байгууллага, түүний ажилтнуудын нэгдсэн бодлого ажлын уялдааг сайжруулахад анхаарч ажиллах,

Долоо.Иргэний нийгмийн байгууллагуудад

7.1. Төрийн бус байгууллагуудын ажилтнууд, иргэд хохирогчийн эрхийн талаар мэдлэг, боловсрол олгоход чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хэлбэрээр зохион байгуулж байх,

7.2. Хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөж хохирсон иргэдэд туслах, хохирлыг нь нөхөн төлүүлэх, тэднийг хамгаалах эрх зүйн тусалцаа үзүүлэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэн тогтмолжуулах,

7.3. Хохирогчийн эрхийг хамгаалах талаар олон нийтийн санаа бодлыг судалж, тухай бүрт нь төрийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж байх,

7.4.Хэвлэл, мэдээллийн байгууллагууд аливаа хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг, хүчирхийллийн талаар олон нийтэд мэдээлэхдээ хохирогчийн нэр төр, эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандаж, түүнийг зөрчихгүй байх хандлага, хариуцлагыг сэтгүүлч, ажилтнууддаа төлөвшүүлэх арга хэмжээ авах,

Найм. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар

8.1. Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтэд Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс хяналт тавьж ажиллана.

8.2. Зөвлөмж болон түүний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

8.3. 2008 оны 11 дүгээр сард зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын тайланг хэлэлцэх, энэ талаар нийтэд мэдээлэх зорилгоор Чуулганд оролцсон бүх талуудыг хамарсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулна.

ЧУУЛГАНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД

2007 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хот